## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН ТӨСВИЙН ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН, ХЭРЭГЖИЛТИЙГ ХЭМЖИХ ТООН БОЛОН ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

**/2014 он/**

**Төсвийн ерөнхийлөн захирагч - Д.Баярсайхан**

**Төсвийн шууд захирагч - Х.Бум-Эрдэнэ**

| Ерөнхий дугаар | Хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл | Бүлгийн дугаар | Хэрэгжүүлэх арга хэмжээ, ажил үйлчилгээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| Монгол улсын “Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, тогтвортой хөгжлийг бэхжүүлэх”, “Санхүүгийн салбарт итгэх олон нийтийн итгэлийг бий болгох”, “Харилцагч үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, хадгаламж эзэмшигчдийн эрхийг хамгаалах” Хорооны стратеги зорилтуудын хүрээнд: **Нэг. Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, Дээд газрын тогтоол шийдвэр, бодлогын баримт бичигт салбарын чиглэлээр тусгагдсан ажлуудын биелэлтийг хангах** | | | | | | |
| 1 | **1.1. Хуулийн төсөл боловсруулах, ажлын хэсэгт орж ажиллах чиглэлээр** | 1.1.1. | Хорооны үйл ажиллагаанд шууд хамааралтай хууль шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчилсэн, найруулга хийх зэрэгт төсөл, санал боловсруулан оролцох | Хорооны зохицуулалтад хамаарах салбар болон Монгол улсын санхүү эдийн засгийн чиглэлээрх хуулиудад шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг тусгасан байна. | Онцгой албан татварын тухай, Ашигт малтмалын тухай хуулиудад Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд нийцүүлэх тухай саналыг боловсруулж Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр хэлэлцүүлснээр Засгийн газраас хуулийн төслүүдийг УИХ-д өргөн барьсан. ХААБ-уудыг Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай асуудлаар ҮХААЯ, СЯ, СЗХ, ТЕГ, ХАА-н бирж, БЗЗАА, ХААБ-уудын төлөөллийг оролцуулсан уулзалтыг ҮХААЯ-нд зохион байгуулж, оролцсон. Үүний үр дүнд ТЕГ холбогдох хууль, эрх зүйн үндэслэлийг судалж, ХААБ-ын үйл ажиллагаа нь Нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд хамаарахгүй болохыг мэдэгдсэн. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах Хороо, Монголбанк хамтарсан ажлын хэсэг байгуулах тухай тушаалын төсөл боловсруулаад байна. “Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулан 2013 оны 12 дугаар сард Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд өргүүлсэн ба тус хууль нь Улсын Их Хурлын 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэгдэн батлагдсанаар тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 13 дахь заалтыг хүчингүй болгосон. Ингэснээр иргэд гадаад валютын | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | худалдаа эрхлэх эрх зүйн үндэслэлгүй болсон. | |
| **2** | | **1.1.2** | Санхүү эдийн засгийн чиглэлээрх хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, шинээр боловсруулахаар байгуулагдсан ажлын хэсэгт орж ажиллах | | Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль, Компанийн тухай хууль болон Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажиллаж 3 хуулийг батлуулсан байна. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Хохирлыг эргэн төлөх нөхцөлөөр барагдуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Эмнэлэгийн мэргэжилтний хариуцлагын тухай ,Уул уурхайн биржийн тухай хуулиудын төслийг боловсруулах ажлын хэсэгт тус тус ажилласан. Өрийн удирдлагын тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай , Гэмт хэргийн тухай, Зөрчлийн тухай, Захиргааны ерөнхий хуулиудын төслүүд эд Хорооны саналыг нэгтгэж санал өгсөн. Аудитын болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудын төслийн шинэчилсэн найруулга УИХ-аар хэлэлцэгдэж буйтай холбоотойгоор Хорооноос баримтлаж буй бодлого, чиглэлийг тусгасан саналыг УИХ-ын Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн. Мөн Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн төсөлд санал оруулахаар түүнтэй холбоотой татварын зохицуулалтын талаар гадаад улс орнуудын жишгийг судлах, Онцгой албан татварын тухай, Ашигт малтмалын тухай хуулиудыг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд нийцүүлэх, Өрийн удирдлагын тухай хууль, Хувийн тэтгэвэрийн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах чиглэлээр судалгааны ажлыг тус тус хийлээ. Хөдөө аж ахуйн биржүүдийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай асуудлаар Үйлдвэр хөдөө аж ахуйн яам, Сангийн яам, Татварын ерөнхий газар, Хөдөө аж ахуйн бирж, Хөдөө аж ахуйн биржийн зохицуулах зөвлөлийн ажлын алба, Хөдөө аж ахуйн биржүүдийн төлөөллийг оролцуулсан уулзалтыг зохион байгуулснаар Татварын ерөнхий газраас холбогдох хууль, эрх зүйн үндэслэлийг судалж, ХААБ-ийн үйл ажиллагаа нь Нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд хамаарахгүй болохыг шийдвэрлэлээ. | **100** |
| **3** | | **1.1.3** | Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчлэн найруулсан хуулийн төслийг Засгийн газраар УИХ-д өргөн бариулах | | “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль”-ийн шинэчлэн найруулсан төслийг Засгийн газраар УИХ-д өргөн бариулах шийдвэр гарснаар Засгийн газрын 2014 оны 6 дугаар сарын 18-ны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэж санхүүгийн түрээс, ломбард, валютын арилжааны талаарх олон улсын судалгааг ирүүлэхийг үүрэг болгосны дагуу холбогдох судалгааг хийж хүргүүлсэн бөгөөд Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх зорилт тавин ажиллаж байна. | **100** |
| **4** | | **1.1.4** | Хорооноос гаргасан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн акт, бодлогын баримтын бичгийн болон Хорооны даргын тушаал, албан бичгийн | Хорооноос эрх хэмжээнийхээ хүрээнд гаргаж буй эрх зүйн актууд болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон дүрэм журмууд нь холбогдох хууль тогтоомжид бүрэн | 2014 оны эхний хагас жилд Хорооны хуралдаанаар хэлэлцэгдсэн 467 асуудлын төслийн материал, Хорооны даргын 353 тушаал, Улсын ерөнхий байцаагчийн 20 тушаалын эрхзүйн үндэслэлийг хууль тогтоомжид нийцүүлэн хянав. Хорооны 11 тогтоолд кодификаци хийлээ. | **100** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | төслийн эрх зүйн үндэслэлийг хууль тогтоомжид нийцүүлэн хянах | нийцсэн байна. | | |
| **5** | | **1.1.5** | Хороо болон Хяналтын зөвлөлийн дарга, гишүүд, Ажлын алба, ажилтнуудад эрх зүйн чиглэлээр туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах | | Аудитын болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудын төслийн шинэчилсэн найруулга УИХ-аар хэлэлцэгдэж буйтай холбоотойгоор эдгээр хуулиудын төслийн үзэл баримтлал, аудит, нягтлан бодох бүртгэлийн талаар Хорооноос баримтлах бодлого, чиглэлийг нэгтгэх асуудлуудыг хамарсан танилцуулга, семинарыг хуулиудын төслийг боловсруулах ажлын хэсгийн зөвлөхөөр Хорооны удирдлагууд, газар хэлтсийн дарга нар болон холбогдох мэргэжилтнүүдэд зориулан танилцуулга, хэлэлцүүлэг зохион байгуулсан. | **100** |
| **6** | | **1.1.6** | Үнэт цаасны бүртгэл болон давхар бүртгэлийн харилцааг нарийвчлан зохицуулсан журмыг боловсруулах | | Хорооны 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 06 дугаар тогтоолоор "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ыг батлуулсан. Уг журмаар үнэт цаасыг хөрөнгийн биржүүдэд давхар бүртгүүлэн арилжаалах харилцааг нарийвчлан зохицуулсан болно. | **100** |
| **7** | **1.2. Салбарын чиглэлээр шинээр батлагдсан болон шинэчлэн найруулсан, нэмэлт өөрчлөлт орсон хуульд нийцүүлэн дүрэм, журам, зааврыг боловсруулж батлуулах** | **1.2.1** | Монголын ба олон улсын хадгаламжийн бичгийн журам боловсруулах | Журмын төслийг боловсруулан Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж мөрдүүлсэн байх, Хорооноос баталж мөрдүүлж буй дүрэм, журам, заавар нь холбогдох хууль тогтоомжид бүрэн нийцсэн байна. | МҮЦАЭХ, "МХБ" ХК, "ҮЦТТТХТ" ХХК зэрэг холбогдох байгууллагуудаас журмын төсөлд санал авч холбогдох саналыг тусган "Хадгаламжийн бичгийг гаргах, бүртгэх тухай журам"-ыг Хорооны тогтоолоор батлан мөрдүүлж эхлээд байна. | **100** |
| **8** | | **1.2.2** | Үүсмэл санхүүгийн хэрэгслийн журам боловсруулах | | "Үүсмэл санхүүгийн хэрэгслийн журам" боловсруулах ажилд олон улсын стандарт, туршлагыг тусгах зорилготойгоор олон улсын зөвлөхийн туслалцаа авах шаардлагатай байгаа бөгөөд энэ ажилд "Санхүүгийн салбарын чадавхийг бэхжүүлэх МОН-004 төсөл"-өөс санхүүгийн дэмжлэг авах хүсэлтээ гаргаад байна. Үүнтэй холбоотой зөвлөхийн ажлын байрыг зарлах, сонгон шалгаруулах зэрэг дараагийн ажлуудаас хамаарч энэхүү ажил хийгдэхээр байна. Тус газрын зүгээс холбогдох судалгааг хийж ажиллаж байна. | **50** |
| **9** | | **1.2.3** | Дотоод мэдээлэл ашиглаж арилжаанд оролцохыг хориглох, түүнийг эзэмшигчийн үйл ажиллагааг зохицуулсан журмыг боловсруулах | | Дотоод мэдээлэл ашиглаж арилжаанд оролцохыг хориглох, түүнийг эзэмшигчийн үйл ажиллагааг зохицуулсан журмыг боловсруулан Хорооны тогтоолоор баталсан. | **100** |
| **10** | | **1.2.4** | Кастодианы үйл | | Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 46 дугаар зүйлд зааснаар Кастодианы | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | ажиллагаа болон тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг зохицуулсан журам боловсруулах | | харилцааг зохицуулсан журмыг Хороо Монголбанктай хамтран батлав. | **100** |
| **11** | | **1.2.5** | Үнэт цаасны зах зээлийн маргаан таслах зөвлөлийн журам боловсруулах | | Үнэт цаасны зах зээлийн маргаан таслах зөвлөлийн журмыг батлан мөрдөж эхлээд байна. | **100** |
| **12** | | **1.2.6** | Компанийн хувьцааг худалдан авах ажиллагааны журам боловсруулах | | Компанийн хувьцааны хяналтын багцыг худалдан авахтай холбоотой харилцааг өөрчлөхөөр 2013 оны 8 дугаар сард УИХ-ын гишүүн С.Ганбаатар нарын гишүүдээс Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барьсныг жил дамжин хэлэлцсэний эцэст 2014 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн УИХ -ын нэгдсэн чуулганаар дээрх нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсан. Энэхүү хуулийн төсөлтэй хамт 2014 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн "Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" УИХ -ын 41 дүгээр тогтоол батлагдсан бөгөөд уг тогтоолын 1 -д "Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооноос өмнө баталсан холбогдох журам, заавартад зохих өөрчлөлт оруулахыг даалгасны дагуу дээрх харилцааг зохицуулсан "ХК-ийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны тухай журам"-ын төслийг эцэслэн боловсруулаад байна. | **90** |
| **13** | | **1.2.7** | Үнэт цаасны мэргэшлийн шалгаруулалт явуулах, мэргэжилтэнд эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам боловсруулах | | Хорооны 2014 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор "Үнэт цаасны мэргэшлийн шалгаруулалт явуулах, мэргэжилтэнд эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай журам"-ыг батласан. | **100** |
| **14** | | **1.2.8** | Хорооноос зохицуулалттай этгээдэд даалгавар өгөх дотоод заавар боловсруулах | Зааврын төслийг боловсруулж Хорооны хуралдаанд хэлэлцүүлсэн байх | "Үнэт цаасны зах зээлийн өөрийгөө зохицуулах байгууллага болон зохицуулалттай этгээдэд даалгавар зөвлөмж өгөх тухай заавар"-ын төслийг боловсруулсан. | **90** |
| **15** | | **1.2.9** | Зохицуулалттай этгээдийн санхүүгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тухай журам боловсруулах | Журмын төслийг боловсруулан Хорооны хуралдаанаар | Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй олон салбарыг хамарсан техник туслалцааны төслийн шугамаар зөвлөх Д.Уайт "Эрсдэлд суурилсан хяналт шалгалт"-ыг Хороонд хэрэгжүүлэх чиглэлээр аргачлал бэлтгэж 2 удаа сургалтыг явуулсан. Гадны орнуудын эрсдэлд суурилсан хяналт шалгалтын дэвшилтэт туршлагыг багтаасан санхүүгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн аргачлал, асуулга, журмын төслийг англи хэл дээр бэлэн болгосон. Журмын төслийг өөрийн орны нөхцөлд тааруулж шалгуур үзүүлэлтүүдийг өөрчлөх, улмаар | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэлэлцүүлэн батлуулж мөрдүүлсэн байх, Хорооноос баталж мөрдүүлж буй дүрэм, журам, заавар нь холбогдох хууль тогтоомжид бүрэн нийцсэн байна. | байцаагчдыг сургах, дадлагажуулах зэрэг хэрэгжүүлэх ажил ЖАЙКА -гийн төслийн хүрээнд хийгдэнэ. Эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын үндэс суурь нь энэхүү зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тул энэхүү журмын эцсийн хувилбарыг 2015 онд Японы санхүүгийн үйлчилгээний агентлагын мэргэжилтнүүдийн тусламжтайгаар боловсруулахаар болсон. | **70** |
| **16** | | **1.2.10** | Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны тухай журам боловсруулах | | "Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны тухай журам"-ын төслийг боловсруулан Хорооны 2014 оны 1 дүгээр сарын 05-ны өдрийн 07 дугаар тогтоолоор батлаж мөрдүүлээд байна. | **100** |
| **17** | | **1.2.11** | Зохицуулалттай этгээдийн дотоод журмыг батламжлах, бүртгэх, зөвшөөрөл олгох Хорооны дотоод заавар боловсруулах | | Үнэт цаасны зах зээлийн өөрийгөө зохицуулах байгууллага болон зохицуулалттай этгээдийн дүрэм, журмыг батламжлах, бүртгэх тухай заавар"-ыг Хорооны тогтоолоор батласан. | **100** |
| **18** | | **1.2.12** | Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх багц журмыг боловсруулах талаар төлөвлөгөө гаргаж, холбогдох журмын төслийг боловсруулах | | Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийг дагаж гарах багц журам, түүнийг боловсруулах ажлын хэсгүүдийг байгуулан ажиллалаа. Дэлхийн банкны олон салбарыг хамарсан техник туслалцааны төслийн шугамаар зарим холбогдох техникийн туслалцаа авч байна. Уг ажлын хүрээнд Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам, Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журмыг тус тус батлав. | **100** |
| **19** | | **1.2.13** | Хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах журам боловсруулах | | "Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ыг баталсан бөгөөд энэхүү журмаар хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулахтай холбоотой харилцааг зохицуулсан. | **100** |
| **20** | | **1.2.14** | Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам боловсруулах | | "Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам"-ыг Хорооны тогтоолоор баталсан бөгөөд уг журмаар хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавигдах шаардлага, шалгуур, хувь нийлүүлсэн хөрөнгө, удирдлагын бүтэц зэрэг харилцааг нарийвчлан зохицуулсан. Энэхүү журмын хүрээнд 3 компани "Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл" аваад байна. | **100** |
| **21** | | **1.2.15** | Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа, түүнд хяналт тавих журам боловсруулах | | "Хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны тухай журам", "Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны тухай журам"-ыг тус тус баталсан. | **100** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **22** | | **1.2.16** | Хөрөнгө оруулалтын сангийн актив, түүнийг үнэлэх, санхүүгийн тайланд тавигдах шаардлага болон нягтлан бодох бүртгэлийн журам боловсруулах | | Хөрөнгө оруулалтын сангийн актив, түүнийг үнэлэх, санхүүгийн тайланд тавигдах шаардлага болон нягтлан бодох бүртгэлийн харилцааг зохицуулсан журмын төслийг боловсруулахаар олон улсын зөвлөх Ашраф Эл Шаркави ажиллаж эхний байдлаар журмын төслийг 2014 оны 6 дугаар сарын 11-ний өдөр тус газарт ирүүлээд байна. Уг журмын төслийг монгол хэлнээ орчуулан холбогдох байгууллагаас санал авс батлахад бэлэн болоод байна. | **90** |
| **23** | | **1.2.17** | Даатгалын хүртээмжийг сайжруулах зорилгоор ХЗХ-дыг даатгалын төлөөлөгчөөр ажиллуулах эрх зүйн үндсийг бүй болгох талаар холбогдох журамд өөрчлөлт оруулах | ХЗХ нь даатгалын төлөөлөгчөөр ажиллах боломжтой болсон байна. | Хөдөө орон нутгийн иргэдэд даатгалыг боломжит сувгаар хүргэх Хадгаламж зээлийн хоршоодыг даатгалын төлөөлөгчөөр ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлэхээр "Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам", "Хадгаламж зээлийн хоршооны эрхлэх санхүүгийн бусад ажил, үйлчилгээний жагсаалт", " Хадгаламж зээлийн хоршооны эрхлэх санхүүгийн бусад ажил, үйлчилгээний журам", “Хадгаламж зээлийн хоршооны нягтлан бодох бүртгэлийн заавар” -т нэмэлт, өөрчлөлт оруулаа. | **100** |
| **24** | | **1.2.18** | Даатгалын, зах зээлийн, үйл ажиллагааны зэрэг эрсдэл тус бүрээр олон улсын шинжээчийн зөвлөгөө авч судалгаа хийн эрсдэлийг хянах зөвлөмж боловсруулах | Зөвлөмж боловсруулсан байна. | Даатгалын, зах зээлийн, үйл ажиллагааны эрсдэл тус бүрээр судалгаа хийсэн бөгөөд "Даатгалын компанийн эрсдэлийн удирдлагын заавар", "Эрт анхааруулах шинжилгээ хийх зөвлөмж" боловсруулж, даатгалын бүтээгдэхүүний хэлбэрийн жагсаалт гаргаж эрсдэлээр нь ангилан батлав. Мөн даатгалын компаниуд болон даатгалын мэргэжлийн оролцогч компани дээр эрсдэлийн үнэлгээ гарган, хяналтын картыг боловсруулсан. | **100** |
| **25** | | **1.2.19** | Даатгалын багц дүрэмд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах | Хороогоор шийдвэрлүүлсэн байна. | Даатгалын чиглэлээр 2014 онд нийт 11 журам, зааварт өөрчлөлт оруулахаар боловсруулснаас 1 журам шинээр баталж, 4 журамд нэмэлт оруулж, 2 журамд нэмэлт өөрчлөлт оруулав. Үүнд:<br>1. Даатгалын компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-д нэмэлт, өөрчлөлт;<br>2. “Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчдоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журам”-д нэмэлт ;<br>3. Даатгалын бүтээгдэхүүний зохицуулалтыг сайжруулах, хүртээмжтэй даатгалтай холбоотой зохицуулалтын журамд журамд нэмэлт;<br>4. Хадгаламж, зээлийн хоршоог даатгалын төлөөлөгчөөр ажиллах зохицуулалтыг тусган "Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай | **100** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөвшөөрлийн журам"-д нэмэлт;<br>5. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын цэвэр хураамжийн хувь хэмжээг шинэчлэн тогтоосон;.<br>6. "Давхар даатгагчийн өөрийн санхүүгийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам" шинээр тус тус баталж<br>7. "Жолоочийн даатгалын баталгааны загварыг хэрэглэх журам", "Жолоочийн даатгалын баталгааны загвар"-ыг шинэчилсэн журмын төслийг;.<br>8. "Ослын тодорхойлолт олгох заавар" -ын төслийг ;<br>9. "Албан журмын даатгагчдын холбооны санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам"-ын төслийг;<br>10. "Жолоочийн даатгалын сангийн шуурхай албаны ажиллах журам"-ыг шинэчлэн боловсруулав.<br>11. .Хорооны 2012 оны 392 дугаар тогтоолоор батлагдсан "Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах талаар журмын төслийг тус тус боловсруулав. | |
| **26** | | **1.2.20** | Даатгалын мэргэжлийн оролцогчийн зохицуулалтын журам, заавар, аргачлалд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар судалгаа хийж, төсөл боловсруулах | Судалгаа хийж, танилцуулга боловсруулан Хорооны удирдлагад танилцуулсан байна. | Даатгалын мэргэжлийн оролцогчийн зохицуулалтын журам, заавар, аргачлалд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар судалгаа хийсний үндсэн дээр "Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчдод үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журам" , "Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-д тус тус нэмэлт оруулав. | **100** |
| **27** | | **1.2.21** | Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын цэвэр хураамжийн хувь хэмжээг тооцож, Хорооны хуралдаанаар шийдвэрлүүлэх | Нөөцийн санг бүрдүүлэх нөхцөл бүрдсэн байна, судалгаа хийж газрын удирдлагад танилцуулсан байна. | Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын цэвэр хураамжийн хувь хэмжээг тооцож судалгаа хийн Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын цэвэр хураамжийн хувийг 65 хувь байхаар тогтоов. | **100** |
| **28** | | **1.2.22** | Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай шинэчлэн найруулсан хууль батлагдсантай холбогдуулан холбогдох журам, зааврuудыг шинэчлэх, шаардлагатай журам, зааврuудыг | Журам заавруудын төслийг боловсруулан Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж мөрдүүлсэн байх | Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль шинэчлэн батлагдаагүй боловч төлөвлөгөөт ажлын хүрээнд дараах ажлуудыг урьдчилан хийж гүйцэтгээд байна. Үүнд:<br>1/ "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам" -ыг төслийг боловсруулллаа. Мөн одоогийн мөрдөгдөж байгаа "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-д АНУ-ын гадаад дахь дансдыг татварт хамруулах тухай хуультай холбоотой нэмэлт оруулах асуудлыг Хорооны хуралдаанаар хэлэлцсэн ба нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг түр хойшлуулаад байна ; | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | шинээр боловсруулах | | 2/ Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгчийн дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай төслийг шинэчлэн найруулсан хуулийн төсөлтэй холбогдуулан нэр бүхий 3 байгууллага болох “Валютын арилжааны байгууллага”, “Зээлийн байгууллага”, “Санхүүгийн байгууллага” тус бүрд одоогийн мөрдөгдөж буй дүрмийн сангийн хэмжээнд уялдуулан тогтоох тухай журмын төслийн эхний хувилбарыг боловсруулаад байна;<br><br>3/ “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгчийн нягтлан бодох бүртгэл ийг хөтлөх заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт”-ыг шинэчлэх журмын төслийг боловсруулав. 4/ “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгчийн үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх журам” -ыг эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын хандлагын дагуу шинэчлэн боловсруулахаар холбогдох эх сурвалжуудыг судлан, боловсруулалтын ажил хийгдэж байна;<br>5/ “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгчээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлс”-ийг шинэчлэн тогтоохоор холбогдох судалгааны ажил хийгдэж байна.<br>Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай шинэчлэн найруулсан хууль батлагдсаны дараа шинэчлэх шаардлагатай журам заавруудын жагсаалт гарган судалгааны ажлуудыг хийж байна.Үүнд: Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгчийн дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоохтой холбогдуулан ББСБ-уудын 2013 оны байдлаарх дүрмийн сангийн хэмжээний өнөөгийн байдал, түүний өсөлт бууралтын талаарх судалгааг хийлээ. ББСБ-ын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягтыг шинэчлэн найруулсан хуулийн төсөл болон банкны салбарт мөрдөгдөх НББ-ийн заавар, дансны жагсаалтын төсөлтэй нийцүүлэн боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэж байна. Шинэчлэн найруулсан хуулийн үзэл баримтлалд тулгуурлан "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-д нэмэлт өөрчлөлт оруулахаар судлан төслийн шатанд боловсруулаад байна. | **100** |
| **29** | | **1.2.23** | Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн заавар, банк бус санхүүгийн байгууллагын дансны жагсаалт болон банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн тайлангийн маягтад өөрчлөлт оруулах | Сангийн яамтай хамтран батлуулсан байх | Заавар, дансны жагсаалт, тайлангийн маягтын төслийг боловсруулж, Сангийн сайдын тушаалаар хамтран батлуулахаар СЯ-нд хүргүүлсэн. СЯ уг төслийг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчлэн найруулсан хуулийн төсөл болон банкны салбарт мөрдөгдөх НББ -ийн дансны заавар журмын төслийг тус тус батлагдсаны дараа тэдгээ рт уялдуулан дахин боловсруулах тухай санал, зөвлөмжийг ирүүлсэн. Иймд одоо мөрдөгдөж байгаа хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн батлуулах асуудлыг хойшлуулж, шинэчлэн найруулсан хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн хууль батлагдсаны дараа зааврыг батлуулахаар болоод байна. | **100** |
| **30** | | **1.2.24** | Банк бус санхүүгийн байгууллагын үйл | Журмын төслийг боловсруулан | Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн заавар, дансны жагсаалт болон санхүүгийн тайлангийн маягт | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журамд нэмэлт өөрчлөлт оруулах | Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж мөрдүүлсэн байх | шинэчлэн батлагдах өөлөвлөгөөт ажил хойшлогдсонтой холбо отойгоор "Банк бус санхүүгийн байгууллагын үйл аж иллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах боломжгүй байна. "Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам" -д өөрчлөлт оруулж чанаргүй зээлийн зохистой харьцааг хүчингүй болгосон. Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-д нэмэлт өөрчлөлт оруулсантай холбогдуулан "Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-д ББСБ-ын онцлогт нийцүүлэн "Активыг ангилах, активын эрдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ыг тусад нь баталж, мөрдүүлэх нь зүйтэй гэж үзэж, журмын төслийг Сангийн яамны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газарт Хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлуулахаар хүргүүлээд байна .Төслийг боловсруулахдаа Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооноос холбогдох саналыг авсан ба журмын төслийг ББСБ-ын салбарын Бодлогын орон тооны бус зөвлөлийн хуралд танилцуулж, хэлэлцүүлсэн | **100** |
| **31** | | **1.2.25** | Хадгаламж, зээлийн хоршооны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ыг шинэчлэн боловсруулах | | "Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон дагаж мөрдөх үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам" -ыг шинэчлэн боловсруулж батлан мөрдүүллээ. Мастер файлыг журмын дагуу боловсруулан Fina системтэй холболоо. | **100** |
| **32** | | **1.2.26** | Шаардлагатай тохиолдолд олон улсын стандарт, холбогдох хууль, журмын өөрчлөлтийн хүрээнд зохицуулалтын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой журам, зааварт өөрчлөлт оруулах, зөвлөгөө өгөх, ажлын хэсэгт орж ажиллах | Зохицуулалтын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой журам, зааварт өөрчлөлт орсон байх, зөвлөгөө өгөгдсөн байх, ажлын хэсэгт орж ажилласан байх | "Үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа явуулах этгээдэд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн үлгэрчилсэн заавар", "Үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд мөрдөгдөх дансны үлгэрчилсэн жагсаалт, санхүүгийн тайлан, түүний тодруулга"-д нэмэлт, өөрчлөлт оруулан "Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар" -ыг хавсралтаар баталсан болно. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2014 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн А56 дугаар тушаалаар бай гуулагдсан Нягтлан бодох бүртгэлийн багц материалыг шинэчлэх ажлын хэсэгт Хорооны төлөөлөлийг ажиллуулж байна. Бизнесийн орчныг сайжруулах, тусгай зөвшөөрөлтэй холбоотой шат дамжлагыг багасгах чиглэлийн хүрээнд "Даатгалын байгууллагад аудит хийлгүүлэх ажилл агааг зохицуулах журам"-д өөрчлөлт оруулан даатгалын байгууллагад аудит хийх эрхийг хугацаагүй болгох арга хэмжээ авсан. Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэлийн журам, Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг шинэчлэн батлах тухай журам, Зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагааны бүртгэлийн журмыг өөрчлөх ажлын хэсгийг байгуулан судалгаа хийж байна. | **100** |
| **33** | | **1.2.27** | ХАА-н бирж | Журмын төслийг | "Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагаанд | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | (ТӨХХК)-ийн үйл ажиллагаанд хяналт тавих зохицуулалтын журмыг боловсруулах | боловсруулан Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж мөрдүүлсэн байх, Хорооноос баталж мөрдүүлж буй дүрэм, журам, заавар нь холбогдох хууль тогтоомжид бүрэн нийцсэн байна. | хяналт тавих журам"-ын төслийг боловсруулан ҮХААЯ, ТӨХ, ХАА-н бирж, Биржийн зохицуулах өөвлөлийн ажлын алба, ХАА -н мэргэшсэн брокерийн холбооноос санал авч Хорооны хуралдаанаар хэлэлцэж баталлаа. | 100 |
| 34 | | 1.3.1 | ХАА-н биржийн зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагааны зохицуулалтын журмын төслийг боловсруулах | | “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ыг боловсруулан "Цэц-Инвест ХААБ" ХХК, "Баяр плант ХААБ" ХХК-уудад газар дээрх шалгалтыг үйцэтгэх явц даа тус журам хэрэгжих боломжтой эсэхийг давхар судалж, журмын хавсралтад тусгасан маягтуудын дагуу мэдээллийг бөглүүлж туршсан. Журмыг Хорооны тогтоолоор батлан мөрдүүлж эхлээд байна.<br>.Мөн журмыг хэрхэн хэрэгжүүлэх, дагаж мөрдөх талаар ХААБ-уудын удирдлагад 1 удаа танилцуулга хийсэн. | 100 |
| **Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого** | | | | | | |
| 35 | **1.3. Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах чиглэлээр** | 1.3.2 | Засгийн газар, орон нутгийн болон компанийн өрийн хэрэгслийг Хөрөнгийн биржээр арилжаалах арга хэмжээ авах | Өрийн хэрэгслийг хөрөнгийн биржээр арилжаалах чиглэлээр холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах санал гарган , холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байх | "Засгийн газрынүнэт цаасыг бүртгэх т ухай" Хорооны тогтоол гаргаж дотоодын үнэт цаасны зах зээл дээр нийтэд санал болгон гаргах нийт 100,0 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүн бүхий Засгийн газрын өрийн бичгийг үнэт цаасны бүртгэлд бүртгэсэн. Хөрөнгийн бирж дээр 11 сарын 04-ний өдрөөс эхлэн Засгийн газрынөрийн хэрэгсэл арилжаалагдаж эхлээд байгаа ба нийтдээ 28 орчим тэрбум төгрөгийн Засгийн газрын өрийн хэрэгсэл Хөрөнгийн биржээр арилжаалагдаад байна. | 100 |
| 36 | | 1.3.3 | Гадаадын үнэт цаасыг Монголын үнэт цаасны зах зээлд арилжаалах нөхцлийг бүрдүүлэх | Холбогдох журам дүрмийг баталж, нийтэд мэдээлэл хүргэх, сургалт сурталчилгааны ажил зохион байгуулсан байх | Хорооны 2014 оны 6 дугаар тогтоолоор "Үнэт цаасны бүртгэлийн журам" -ыг шинэчлэн баталснаар гадаадынүнэт цаас Монголын хөрөнгийн зах зээлд арилжаалагдах нөхцөл боломж бүрдсэн бөгөөд энэ чиглэлээр гадны болон дотоодын хөрөнгө оруулалтын банк, мэргэжлийн бай гууллагатай хамтран ажиллаж байна. Мөн Хадгаламжийн бичгийн бүртгэх харилцааны журмыг Хорооны тогтоолоор баталсан. | 100 |
| 37 | | 1.3.4 | Компанийн засаглалын кодексийн шинэчилсэн найруулгын төсөлд санал өгч, шаардлагатай зүйл заалтыг даатгалын зохицуулалтын холбогдох журамд тусгах | Санал өгсөн байна, шаардлагатай заалтыг даатгалын журамд тусгуулсан байна | Компанийн засаглалын талаар даатгалын компани заавал Төлөн удирдах зөвлөлтэй байх, ТУЗ-ийн гишүүдийн тоо, хараат бус гишүүдийн тоо зэрэг зохицуулалтыг тусган Хорооны 2013 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан "Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам"-д нэмэлт оруулсан. | 100 |
| 38 | | 1.3.5 | КЗҮЗ-өөс даатгалын компаниудад 2012-2013 онд хийсэн | Судалгааны тайлан, дүгнэлтийг Хорооны удирдлагад | Компанийн засаглалын талаар даатгалын компаниудад судалгаа хийж байгаа ба Урт хугацааны даатгагч “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн засаглалын зэрэглэл тогтоох судалгааг гаргуулан авч, судалгааны тайлан, дүгнэлтийг боловсруулаад | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | компанийн засаглалыг сайжруулах судалгааны санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх, даатгагчдын компанийн засаглалын зэрэглэлийг тогтоох, дотоод хяналтын талаар судалгаа хийх | танилцуулсан байна | байна. | |
| 39 | | 1.3.6 | ХАА-н бирж, ХАА-н биржийн зуучлагч (брокер)-ийн компануудад Компанийн засаглалын кодексийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах | Нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах | ХАА-н бирж, ХАА-н биржийн зуучлагч (брокер)-ийн компануудад Компанийн засаглалын кодексийг нэвтрүүлэх б элтгэл ажлуудыг хийж, холбогдох сургалт, сурталчилгааг 15 ХААБ-ын удирдлагыг оролцуулан хийсэн ба 10 ХААБ-ын үйл ажиллагаанд засаглалын кодексыг хэрэхн нэвтрүүлж буйд шалгалт хийлээ. | **100** |
| **Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө** | | | | | | |
| **40** | **1.3. Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах чиглэлээр** | **1.3.7** | Хувийн тэтгэврийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах | Хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан байх | Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас байгуулсан Хувийн тэтгэврийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт орж ажиллаж байна. | **100** |
| **41** | | **1.3.8** | Хөрөнгийн бирж болон брокер дилер компаниудын чадавхийг сайжруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ | Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ЭЗХЯ-тай хамтран ажилласан байна. | Хөрөнгийн зах зээлийн чадавхийг сайжруулах Японы Жайка байгууллагын төслийн хүрээнд холбогдох мэдээлэл, судалгааны ажил бүрэн хийгдэж, хөтөлбөрийг боловсруулсан. Энэхүү төслийн хүрээнд хөрөнгийн бирж болон мэргэжлийн холбоодынөөрийгөө зохицуулах байгууллага болох, тэдгээрийн чадавхийг дээшлүүлэхэ эр зорин ажиллах юм. өХөлбөр 2014 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс 2017 оны 7 дугаар сарыг хүртэлх хугацаанд хэрэгжинэ. Жайка-ийн төслийн хүрээнд 5 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөх баг ирж ажилласан. | **100** |
| **42** | | **1.3.9** | Урт хугацааны даатгалыг нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалтай уялдуулах, тэтгэврийн даатгалын чиглэлээр судалгаа шинжилгээ хийх | Судалгааны тайлан, дүгнэлтийг Хорооны удирдлагад танилцуулсан байна | Нийгмийн даатгалын ерөнхий газрын холбогдох албан тушаалтнууд болон магистрын дипломын ажлын судалгааны ажлаас шаардлагатай мэдээллийг цуглуулан судалгааны ажил хийж, танилцуулга гаргасан, Турк улсын хувийн тэтгэврийн даатгалын чиглэлээр судалгаа хийж, танилцуулга гаргасан. | **90** |
| **43** | | **1.3.10** | Зээлийн батлан | Зээлийн батлан | Зээлийн батлан даалтын сангаар дамжуулан ББСБ, ХЗХ-дын зээлийг зээлийн | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | даалтын сангаар дамжуулан ББСБ, ХЗХ-дын зээлийг зээлийн батлан даалтын сангийн үйлчилгээнд хамруулах | даалтын сангийн үйлчилгээнд хамрагдах ББСБ, ХЗХ-дын тоо нэмэгдсэн байх | батлан даалтын сангийн үйлчилгээнд хамруулах зорилгоор Зээлийн батлан даалтын санд үүсэлт гаргасан. Одоогоор Зээлийн батлан даалтын сангийн үйлчилгээнд 6 ББСБ хамрагдсан. | **100** |
| **Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэл** | | | | | | |
| **44** | **1.3. Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах чиглэлээр** | **1.3.11** | Банк бус санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох | Хууль батлагдаж ,түүнтэй нийцүүлэн гаргах дүрэм журам шинээр боловсруулагдсан, нэмэлт өөрчлөлт орсон, шинэчлэгдсэн байна. | "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль"-ийн шинэчлэн найруулсан хуулийн төслийг Засгийн газраар УИХ-д өргөн бариулах шийдвэр гарснаар Засгийн газрын 2014 оны 6 дугаар сарын 18-ны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэж санхүүгийн түрээс, ломбард, валютын арилжааны талаарх олон улсын судалгааг нэгтгэх үүрэг болгосны дагуу холбогдох судалгааг хийж хүргүүллээ. | **100** |
| **45** | | **1.3.12** | Санхүүгийн зах зээлийн бүтцийг олон тулгуур бүхий, зохистой болгох, чөлөөт өрсөлдөөний орчныг бүрдүүлэх, санхүүгийн олон төрлийн бүтээгдхүүн бий болгох, санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсэгт орж ажиллах | Ажлын хэсэгт орж ажиллан салбар бүрээр санал боловсруулсан байх | "Санхүүгийн зах зээлийн хөгжлийн хөтөлбөр /2014-2020 он/"-ийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг томилон ажиллуулж "Монгол Улсын санхүүгийн зах зээлийн 2020 он хүртэлх хугацааны шинэчлэл, хөгжлийн хөтөлбөр"-ийн төслийг боловсруулан УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлээд байна. Тус хөтөлбөрт Монгол улсын санхүүгийн салбарын үндсэн үзүүлэлтүүдийг салбар тус бүрээр 2020 он хүртэл тооцож, тооцооны үр дүнг нэгтгэн боловсруулсан. | **100** |
| **46** | | **1.3.13** | "Зээлийн хүү буурах зах зээлийн орчинг бүрдүүлэх хөтөлбөр"-т тусгагдсан ажлын дагуу санхүүгийн зах зээлд оролцогчдын болон жижиг зээлдэгчдийн санхүүгийн боловсролыг | Ажлын хэсэгт орж ажилласан, саналаа хүргүүлсэн байх | "Иргэдийн санхүүгийн боловсролын хөтөлбөр боловсруулах" ажлын хэсэг байгуулан хөрөнгийн зах зээл, бичил санхүүгийн зах зээл, даатгалын зах зээлд оролцох санхүүгийн боловсрол олгох чиглэлээр хийгдэж байсан сургалт, семинар, хэлэлцүүлэг зэрэг зохион байгуулж байсан арга хэмжээний талаарх судалгаа гарган хөтөлбөрийг боловсруулсан. Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх талаар Орос, Япон, Хонконгийн зохицуулагч байгууллагуудын туршлагыг судаллаа. | **100** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | дээшлүүлэх хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт орж ажиллах | | | |
| **47** | | **1.3.14** | "Зээлийн хүү буурах зах зээлийн орчинг бүрдүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд санхүүгийн зах зээлд оролцогчдын чадавхийг бэхжүүлж, ББСБ, ХЗХ-дыг зээлийн мэдээллийн санд хамруулах | Зээлийн мэдээллийн санд хамрагдах ББСБ, ХЗХ-дын тоо нэмэгдсэн байх | "Зээлийн хүү буурах зах зээлийн орчинг бүрдүүлэх хөтөлбөр "-ийн хүрээнд санхүүгийн зах зээлд оролцогчдын чадавхийг бэхжүүлж, ББСБ, ХЗХ-дыг зээлийн мэдээллийн санд хамруулах чиглэлээр ХЗХ-дод Монголбанкны Зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллуулах, гэрээний хуулбарыг Хороонд үүрэхийг үүрэг болгож, Хорооны цахим хуудсаас зээлийн мэдээллийн санд өгөгдөл дамжуулах "Microfinance" программыг гарын авлагын дагуууһэ төлбөргүйгээр суулган ашиглахыг зөвлөн ажиллалаа. Үүний үр дүнд 2014 оны 4 дүгээр улирлын байдлаар 52 ХЗХ зээлийн мэдээллийн санд холбогдоод байна. Ялангуяа орон нутгийн ХЗХ-д интернэтгүй, тогтсон цахим хаяггүй зэрэг техникийн дэд бүтэц тоног төхөөрөмж дутмагаас шалтгаалан Зээлийн мэдээллийн сангаас тавигдаж байгаа шаардлагыг хангахгүй байх тохиолдол байна. Зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 322 ХЗХ байгаагаас 178, орон нутагт байгаа 40 ББСБ-аас 11 нь Монголбанкны Хяналт, шалгалтын газрын Зээлийн мэдээллийн сантай гэрээ байгуулж, зээлийн мэдээллийн сантай холбогдоод байна. | **100** |
| **48** | | **1.3.15** | "Зээлийн хүү буурах зах зээлийн орчинг бүрдүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд Хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр ХЗХ-дыг хадгаламжийн даатгалд хамруулах бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх | ХЗХ-дыг даатгалд хамруулах бэлтгэл ажлыг хангасан байх | Хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэн ХЗХ-дыг хадгаламжийн даатгалд хамруулах бодлогын арга хэмжээ авч ХЗХ өөр хадгаламж хамгааллын санг байгуулж ажиллах шаардлагыг "Хадгаламж, зээлийн хоршооны зохистой харьцааны шалгуурүзүүлэлт болон дагаж мөрдөх үзүүлэлтийг тооцож хяналт тавих журам"-д тусгав. Мөн Азийн хөгжлийн банкны төслийн олон улсын зөвлөхүүдээс өгсөн зөвлөмжийг ХЗХ-дын удирдах ажилтнууд болон нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад зориулсан бүсчилсэн сургалт, хэлэлцүүлэгт танилцуулан санал авч ажилласан. | **100** |
| **49** | | **1.3.16** | Даатгалын салбарыг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулах | Дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулж, мэргэжлийн байгууллагуудад хүргэсэн байна | Даатгалын салбарын дунд хугацааны стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэн ба тус яамны төрийн нарийн бичгийн дарга дээр хянагдаж байна. | **100** |
| **50** | | **1.3.17** | Албан журмын даатгалын нэр төрлийг олшруулах чиглэлээр судалгаа хийж танилцуулга | Холбогдох хуулийн | Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн Эмнэлгийн мэргэжилтний хариуцлагын даатгалын тухай хуулийн төсөлтэй танилцаж, Хорооны 2014.05.29 -ний өдрийн 6/2587 тоот албан бичгээр саналаа өгсөн ах Ажлын хэсгийн уулзалтанд оролцож санал өглөө. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | гаргах, ажлын хэсэгт орж ажиллах: Нотариатч, өмгөөлөгчийн хариуцлагын даатгалын тогтолцоог бүрдүүлэх хуулийн төсөл боловсруулах, Эрүүл мэндийн салбарын ажилтны хариуцлагын даатгалын тогтолцоог бий болгох, Үрийн тариалангийн даатгалын эрх зүйн орчинг боловсронгуй болгох | төслийн ажлын хэсэгт орж ажилласан байх | | **95** |
| **51** | | **1.3.18** | Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын албаны үйл ажиллагааг Хороонд хэрэгжүүлэх, тогтвортой байдлын тайланг бэлтгэх, хүргүүлэх. | Тайлан хүргэгдсэн байх, холбогдох үйл ажиллагаанууд хийгдсэн байх | Санхүүгийн тогтвортой байдлын 2013 оны 4, 2014 оны 1-2 дугаар улирлын тайланг Сангийн яам, Монголбанктай хамтран гаргалаа. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2014 онд хурлаараа Хорооны зүгээс банк бус санхүүгийн байгууллагуудыг Монголбанкны валютын дуудлага худалдаанд оролцуулах, гадаад валютын своп, форвард хэлцэл байгуулах, үнэт цаас худалдан авах үйл ажиллагаанд хамруулах, бичил санхүүгийн зээлийг дамжуулан зээлдүүлэх үйл ажиллагаанд хамруулах гэсэн 4 асуудал оруулж хэлэлцүүлэн шийдвэрлүүлэв. | **100** |
| **52** | | **1.3.19** | Валютын захад тогтворгүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх | Валютын үйл ажиллаганд зохицуулалт, хяналтын оновчтой тогтолцоог бий болгох ажлыг эхлүүлнэ. | Валютын биржийн талаар олон улсын практикыг судалж, валютын биржийн үйл ажиллагааны талаарх ойлголт, түүний бүтэц, зохион байгуулалт, хяналт зохицуулалтын талаар судалгаа хийсэн. Мөн ББСБ -уудыг Монголбанкны гадаад валютын дуудлага худалдаа болон своп, форвард хэлцэлд оролцуулах, Монголбанкны үнэт цаас худалдан авах талаар санал боловсруулан Санхүүгийн тогтвортой байдлын хуралдаанд танилцуулж хэлэлцүүлсэн. Зөвлөлийн хурлаас гарсан зөвлөмжийн дагуу Хороо болон Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны төлөөлөл бүхий хамтарсан 2 ажлын хэсэг байгуулагдан санал дүгнэлт гаргах чиглэлээр хамтран ажилласны үр дүнд 10 дугаар сарын 27-ны өдөр Худалдаа Хөгжлийн Банк, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо болон валютын арилжааны эрхтэй ББСБ-ууд хамтран "Хамтын ажиллагааны гурван талт гэрээ" байгуулсан ба ингэснээр ББСБ-ууд Монголбанкны гадаад валютын дуудлага худалдаанд 2014 оны 12 сарын 01-ны өдрөөс эхлэн оролцох боломжтой болоод байна. | **80** |
| **53** | | **1.3.20** | Валютын захад банк бус санхүүгийн | | ББСБ-уудыг Монголбанкны гадаад валютын дуудлага худалдаа болон своп, форвард хэлцэлд оролцуулах, Монголбанкны үнэт цаас худалдан авах талаар | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | байгууллага, санхүүгийн зах зээлийн бусад оролцогчдыг идэвхтэй оролцуулах, ханшийн эрсдэлээс хамгаалах санхүүгийн үүсмэл хэрэгсэлийг зах зээлд нэвтрүүлэх зорилгоор валютын арилжааны тогтолцоог бий болгох | | санал боловсруулан Санхүүгийн тогтвортой байдлын хуралдаанд танилцуулж хэлэлцүүлсэн. Зөвлөлийн хурлаас гарсан зөвлөмжийн дагуу Хороо болон Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо ны төлөөлөл бүхий хамтарсан 2 ажлын хэсэг байгуулагдан санал дүгнэлт гар гах чиглэлээр хамтран ажилласны үр дүнд 10 дугаар сарын 27 -ны өдөр Худалдаа Хөгжлийн Банк, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо болон валютын арилжааны эрхтэй ББСБ-ууд хамтран “Хамтын ажиллагааны гурван талт гэрээ” байгуулсан ба ингэснээр ББСБ-ууд Монголбанкны гадаад валютын дуудлага худалдаанд 2014 оны 12 сарын 01-ны өдрөөс эхлэн оролцох боломжтой болоод байна. | **100** |
| **54** | | **1.3.21** | Санхүүгийн зах зээлийн харилцагчдын эрх ашгийг хамгаалах, олон нийтийн санхүүгийн сууръ мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран эхлүүлэх | Хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт орж ажиллан саналаа тусгаж ажилласнаар | "Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр" боловсруулах ажлын хэсгийг байгуулан хөтөлбөрийн төслийг боловсруулан эхний хэлэлцүүлгийн шатанд байна. Монголын Аялал Жуулчлалын Холбоотой хамтран төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх зорилго бүхий сургалтыг зочид буудал, аялал зуучлалын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд ад зориулсан сургалт, "Сэтгүүлчдийн боловсролыг дээшлүүлэх сургалт"-ыг тус тус зохион байгуулж сургалтын явцад гарсан саналуудыг хөтөлбөрт тусган ажиллалаа. | **100** |
| **"Санхүүгийн салбарт итгэх олон нийтийн итгэлийг бий болгох", "Харилцагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, хадгаламж эзэмшигчдийн эрхийг хамгаалах стратеги зорилтуудын хүрээнд:<br>Хоёр. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих талаар** | | | | | | |
| **55** | **2.1. Зохицуулалтад хамрагдах хуулийн этгээд, иргэний үйл ажиллагаанд газар дээрх болон зайны хяналт шалгалт хийх чиглэлээр** | **2.1.1.** | Зохицуулалтад хамрагдах хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хийх газар дээрх шалгалтын төлөвлөгөө, удирдамжийг Улсын ерөнхий байцаагчаар батлуулан шалгалтыг хийж нэгдсэн дүнг Хорооны | Санхүүгийн салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих нөхцөл бүрдсэн байна. | **ҮЦГ:** 2014 онд нийт 23 зохицуулалттай этгээдэд төлөвлөгөөт шалгалтыг, 17 аймаг дахь 25 салбарын үйл ажилл агаанд төлөвлөгөөт бус шалгалтыг орон нутгийн төлөөлөгчдөөр хийлгэн ажиллаа. Мөн нэр бүхий 3 компанийн хамтын ажиллагаа болон гадаад арилжаанд шалгалт хийсэн. ХАА-н брокерийн үйл ажиллагаа эрхэлдэг нийт 10 компанид газар дээрх хяналт, шалгалтыг явуулж илэрсэн зөрчил, дутагдлыг арилг уулахаар хугацаатай үүрэг, даалгавар өгч биелэлтэд хяналт тавин ажиллаа. Мөн “МИК актив нэг ТЗК” ХХК, “МИК актив хоёр ТЗК” ХХК болон тэдгээрийн хөрөнгө итгэмжлэн удирдагч “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК-ийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалт хийж Улсын байцаагчийн албан шаардлагаар “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК-ийн удирдлагад хугацаатай үүрэг өгөн ажилл алаа.<br>**ДГ:** Ердийн даатгалын 7, даатгалын зуучлагч 6, хохирол үнэлэгч 6 компани болон Албан журмын даатгагчдын холбоонд тус тус газар дээрх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Даатгалын байгууллагад аудит хийх зөвшөөрөл | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хуралдаанд танилцуулах | | бүхий 13 аудитын компаниудад шалгалт хийсэн. ӨЭКТГ -тай хамтран "Ард даатгал" ХХК, "Улаанбаатар хотын даатгал" ХХК, "Практикал даатгал" ХХК, "Хаан даатгал" ХХК-уудын орон сууц эзэмшигчийн хариуцлагын даатгалын үйл ажиллагаанд сэдэвчилсэн шалгалтыг хийлээ. Дээрх даатгалын компаниудад хууль тогтоомжийг дагаж мөрдөх үүргийг улсын байцаагчийн албан шаардлагаар өгсөн. Нийт 17 аймагт очиж ажиллан 104 даатгалын салбарт шалгалт хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах талаар 10 даатгалын компанид шаардлага хүргүүлсэн. 17 даатгалын компанийн 2013 оны санхүүгийн тайланд аудит хийсэн аудитын 12 компанийг шалгасан бөгөөд илэрсэн зөрчил дутагдлыг арилуууллаа. Тайлант хугацаанд газар дээрх хяналт шалгалтаар 62,7 сая төгрөгийн , зайны хяналтаар 17,9 сая төгрөгийн торгууль оногдуулсан байна.<br>**БСГ:** 2014 онд 36 ББСБ, 35 ХЗХ-ны үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалт хийхээр төлөвлөн 100 хувь гүйцэтгэлээ. Мөн төлөвлөгөөнөөс гадуур нэр бүхий 26 ХЗХ, давхардсан тоогоор 131 ББСБ, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан 50 иргэн, хуулийн этгээдэд үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Ингэснээр 2014 онд нийт 61 ХЗХ, давхардсан тоогоор 167 ББСБ болон Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд давхардсан тоогоор нэр бүхий 50 иргэн, хуулийн этгээдэд үзлэг шалгалт хийсэн бол Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр нэр бүхий 20 хуулийн этгээдийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Тайлант онд Улсын байцаагч нараас нийт 55 албан шаардлагыг ББСБ, ХЗХ-дод өгсөн ба 14,4 сая төгрөгийн төгрөгийн захиргааны хариуцлага оногдуулсан байна.<br>Мөн Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд хийж гүйцэтгэсэн газар дээрх шалгалтаар барилгын 3, тээвэр зуучийн 6 хуулийн этгээдэд Улсын байцаагчийн албан шаардлагаар, тээвэр зуучийн 2 хуулийн этгээдэд мэдэгдэл хүргүүлсэн. 2 компанид 11,520,000 төгрөгийн, 12.9 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна. | **100** |
| **56** | | **2.1.2.** | Хорооны улсын байцаагчдын бүртгэлийг хөтлөх, тэдгээрийг томилж чөлөөлөх шийдвэрийг гаргуулах | Хууль тогтоомжид нийцүүлэн төсөл бэлтгэн шийдвэр гаргуулж, бүртгэлийг үнэн зөв, бүрэн хөтлөх | Улсын байцаагчийн эрхийг 15 ажилтанд олгож, 6 байцаагчийн эрхийг түдгэлзүүлж, 3 байцаагчийн эрхийг хүчингүй болгожээ.<br>2014 онд Улсын ерөнхий байцаагч 1, улсын ахлах байцаагч 10, улсын байцаагч 60, нийт 71 улсын байцаагч ажиллаж байна. | **100** |
| **57** | | **2.1.3.** | Хорооны улсын байцаагч нарын дунд сургалт, семинар зохион байгуулах, шаардлагатай мэдээ мэдээллээр хангах | Сургалт, семинарыг зохион байгуулж, дүнг Хорооны удирдлагад танилцуулсан байх | Дэлхийн банкны суурин төлөөлөгчийн газраас зохион байгуулсан хянан шалгагч байцаагч нарт зориулсан "Хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн зохицуулалт" сургалтанд байцаагч нарыг хамруулав. | **100** |
| **58** | | **2.1.4.** | Хорооны улсын байцаагчдаас тусгай | Захиргааны шийтгэл | Хорооны улсын байцаагчдаас гаргасан зөрчлийг арилгуулахаар 156 албан шаардлага хүргүүлж, 85 захиргааны арга хэмжээ авч хугацаатай үүрэг даалгавар | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | зөвшөөрөл эзэмшигчдэд захиргааны шийтгэл ноогдуулахаар бичсэн зөрчлийн тухай тэмдэглэл, албан шаардлагад дугаар олгох, гүйцэтгэлд хяналт, тавих, прокурорт хянуулах | ноогдуулсан нэгдсэн бүртгэл болон зөрчлийн тухай тэмдэглэл бүрэн хөтлөгдөж, биелэлтийг хангуулсан байх | өгсөн байна. Улсын байцаагчдаас 128.4 сая төгрөгийн торгууль шийтгэвэр ноогдуулжээ. | **100** |
| **59** | **2.1. Зохицуулалтад хамрагдах хуулийн этгээд, иргэний үйл ажиллагаанд газар дээрх болон зайны хяналт шалгалт хийх чиглэлээр** | **2.1.5.** | Шаардлагатай тохиолдолд бусад байгууллагатай хамтран зохицуулалтын хүрээний байгууллагад нэгдсэн шалгалт хийх | Санхүүгийн салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих нөхцөл бүрдсэн байна. | Валютын арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавих, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр 01 дүгээр сарын 16 -ны өдөр Төмөрчний гудамжинд байрлах нэр бүхий 58 иргэн, хуулийн этгээдийг хамарсан үзлэгийг хийж гүйцэтгэсэн. Уг үзлэгээр нийт 30 иргэн, хуулийн этгээдэд 2014 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор зөрчил дутагдлаа арилгах үүрэг, даалгавар өгсөн ба биелэлтэд хяналт тавин ажилласан. Мөн 5 дугаар сарын 26-ны өдөр нийт 42 ББСБ-д давтан үзлэг хийсэн. Сэлэнгэ, Дархан-Уул, Булган, Хөвсгөл, Ховд, Увс, Завхан, Архангай, Сүхбаатар аймгийн 26 ХЗХ, Сэлэнгэ, Завхан, Хөвсгөл, Булган, Сүхбаатар аймгийн 8 ББСБ-ын үйл ажиллагаанд газар дээрх үзлэг хийж ажилтай нь танилцаж, зөвлөгөө, зааварчилгаа өгөх ажлыг зохион байгуулсан. Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны Төмөрчний гудамжид тусгай зөвшөөрөлгүйгээр гадаад валютын арилжаа эрхэлж буй иргэд, хуулийн этгээдийн үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор 7 удаагийн үзлэг, шалгалтыг хийж 19 иргэнд 5,000-60,000 төгрөгийн торгууль ногдуулсан. Мөн тус дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтарсан үзлэг хийхээр удирдамжийн төсөл боловсруулан хамтарсан шалгалтыг хийхээр төлөвлөн ажиллахын зэрэгцээ Чингэлтэй дүүрэгт мэдээлэх самбар ажиллуулж, Төмөрчний гудамж дахь урсдаг зараар сэрэмжлүүлэг явуулах ажлыг зохион байгуулж ажиллалаа. Үзлэгээр тусгай зөвшөөрөл бүхий 25 ББСБ, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж байсан 19 иргэн хамрагдаад байна. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд барилгын 8, тээвэр зуучийн 12, нийт 20 хуулийн этгээдийн үйл ажиллагаанд газар дээрх шалгалтыг хийж гүйцэтгэлээ. | **100** |
| **60** | | **2.1.6.** | Зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаанд зайны хяналт тавьж тайланг хугацаанд нь хүлээн авч, хариу хүргүүлэх | Зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, цаашид авах арга хэмжээний талаар зааварчилга өгч ажиллан, санхүүгийн мэдээллүүдийг нэгтгэн дүн шинжилгээ хийгдэн холбогдох байгууллагуудыг | **ТГ:** Үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгож /IPO/ буй ХХК-ийн, үнэт цаасны бүртгэлээс хувьцаагаа хасуулах, бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбоотой хийгдсэн хөрөнгийн үнэлгээ, хувьцааны үнэлгээ, төслийн хэрэгжих магадлал, санхүүгийн тайлангийн үнэн зөв эсэх , санхүүгийн тайлангийн аудитын чанарын талаар 17 ХК-д бизнесийн үнэлгээг хийлээ.<br>**ҮЦГ**: 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг нийт 198 ХК -иас хүлээн авсан бөгөөд үүнээс 133 ХК-ийн санхүүгийн тайланг аудитын байгууллагаар баталгаажуулахад хяналт тавьж ажилласан.<br>**ДГ:** Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд болох ердийн даатгалын 13 компанид, урт хугацааны даатгалын 1 компанид, даатгалын зуучлагч 16 компанид, даатгалын хохирол үнэлэгч 10 компанид 2013 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | мэдээллээр хангах нөхцөл бүрдсэн байна. | оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хянаж тайлангийн хариу хүргүүлсэн. Эдгээрээс 31 компанид гарсан зөрчил, дутагдлыг арилгуулах талаар хугацаатай үүрэг даалгавар өгсөн.<br>2014 оны 1 дүгээр улиралд даатгалын зуучлагч компанийн санхүүгийн тайланг хянаад зөрчилтэй гэж үзсэн 9 компанид тайлангийн дүгнэлтийг, 2014 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хянаад үйл ажиллагаа явуулж буй даатгалын зуучлагч 19 компанид, 2014 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хянаад, хариу өгөх шаардлагатай гэж үзсэн 13 компанид тайлангийн дүгнэлтийг хүргүүлж, зөрчил дутагдлыг арилгах хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан. 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дүгнэлтийг үйл ажиллагаа явуулсан 13 даатгалын хохирол үнэлэгч компанид, 2014 оны 1 дүгээр улирлын даатгалын хохирол үнэлэгч компаниудын санхүүгийн тайланг хянаад, зөрчил дутагдалтай байсан 8 компанид, 2014 оны 2 дугаар улирлын тайланг хянаад үйл ажиллагаа явуулж байсан 16 компанид, 2014 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хянаад хариу өгөх шаардлагатай гэж үзсэн 10 даатгалын хохирол үнэлэгч компанид зайны хяналтын дүгнэлтийг хүргүүлж, зөрчил дутагдлыг арилгах хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан.<br>Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч урт хугацааны компани болох "Нэйшнл лайф даатгал" ХХК-ийн 2013 оны жилийн эцсийн болон 2014 оны 1-3 дугаар улирлын санхүүгийн тайланг хянаад тус тус албан бичгээр тайлангийн дүгнэлтийг хүргүүлсэн болно.<br>**БСГ.** ББСБ, ХЗХ-дын 2013 оны жилийн эцсийн болон 2014 оны 1, 2, 3 дугаар улирлын санхүүгийн тайлан, үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг Fin-A системээр хүлээн авч хянаж нэгтгэв. 2013 оны жилийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд нийт 141 ХЗХ-ны 97,2 хувь буюу 137 ХЗХ, 2014 оны 1 дүгээр улирлын нэгтгэлд 140 ХЗХ -ны 98,6 хувь буюу 138, 2 дугаар улирлын нэгтгэлд 139 ХЗХ-ны 98.6 хувь буюу 137 ХЗХ, 3 дугаар улирлын нэгтгэлд 140 ХЗХ-ны 97.1 хувь буюу 136 ХЗХ-ны санхүүгийн тайлан хамрагдсан. Харин ББСБ-уудын 2013 оны жилийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд нийт 263 ББСБ-ын 98.8 хувь буюу 260, 2014 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлд тайлан ирүүлбэл зохих нийт 289 ББСБ-ын 99 хувь буюу 286, 2 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлд 326 ББСБ -ын 100 хувь, 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлд 351 ББСБ -ын 98.9 хувь буюу 347 ББСБ-ын санхүүгийн тайлан хамрагдсан. 2013 оны жилийн эцсийн тайлангаар 131 ХЗХ, 259 ББСБ, 2014 оны I улирлын байдлаар 137 ХЗХ, 65 ББСБ, II улирлын байдлаар 136 ХЗХ, 324 ББСБ, III улирлын байдлаар 130 ХЗХ /нийт давхардсан тоогоор 534 ХЗХ/, 84 ББСБ /нийт давхардсан тоогоор 732. ББСБ/-д тайлангийн хариуугаар үүрэг даалгавар, зөвлөмж хүргүүлсэн.<br>Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаанд хяналт тавих чиглэлээр Сангийн 2013 оны жилийн эцэс, 2014 оны 1, 2, 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хүлээн авч хянан, тухай бүр тайлангийн хариуг хүргүүлсэн **.** | **100** |
| **61** | | **2.1.7.** | Зохицуулалтын байгууллагуудын санхүүгийн тайланд дүн шинжилгээ | | Зохицуулалтын байгууллагуудын 2013 оны жилийн эцсийн болон 2014 оны 1-3 дугаар улирлын санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийж нэгтгэл боловсруулан Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл, УИХ-ын ЭЗБХ, ХЗБХ, СЯ, МБ, ҮСХ, Мэргэжлийн холбоодод тус бүр 3 удаа хүргүүлээд байна. | **100** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хийж нэгтгэл боловсруулан, холбогдох газруудад хүргүүлэх | | | |
| 62 | | 2.1.8. | Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах | Хуулийн хэрэгжилтийг хангуулж, үүргийн биелэлтийг хянасан байх | Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон дотооддоо мөрдөж буй журмын хэрэгжилтийн хяналт, шалгалтыг нийт 7 хувьцаат компанид хийлээ. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг нийт 4 ХХК-д хийсэн. Мөн 2013 онд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчилд ногдуулсан торгуулийн үлдэгдэлийг төлөөгүй байсан 4 компаниар 18.9 сая төгрөгийг төлүүллээ.<br>Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагын Ази Номхон далайн бүс нутгийн хяналтын бүлгийн уулзалт Улаанбаатар хотод болсон. Энэ уулзалт нь Монгол улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны дутагдалтай талаа сайжруулан Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагын хяналтын "Хар саарал" ангилалаас шат дэвшилснийг баталгаажуулах зорилготой байсан.<br>2014 оны 6 сарын 23-27–ны өдрүүдэд Парис хотноо зохиогдсон тус байгууллагын нэгдсэн хуралдаанаар Монгол Улсыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны стратегийн дутагдлуудаа зассаныг тэмдэглэж,өөрийн хяналтаас гаргах тухай шийдвэрийг албан ёсоор гаргалаа.<br>Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагаанд оролцогчдод хийх газар дээрх хяналт, шалгалтын хүрээнд нийт 7 зохицуулалттай этгээдэд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон дотооддоо мөрдөж буй журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. Мөн дээрх хуулийн хүрээнд Эрүүгийн хуульдүнэт цаасны дотоод мэдээлэл ашиглах, үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах зэрэг асуудлаар нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажиллан саналаа тусган хуулийг батлууллаа. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд хяналт тавьж ажиллах ажилтныг 158 Хадгаламж зээлийн хоршоо, 332 банк бус санхүүгийн байгууллага, даатгалын зуучлагч 20 компани, хохирол үнэлэгч 19 компанид томилон ажиллуулж байна. | 100 |
| 63 | | 2.1.9. | Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр газар дээрх хяналт шалгалтыг дангаар буюу төрийн бусад байгууллагатай хамтран хийж гүйцэтгэх, хяналт, | Хорооны удирдлагад танилцуулан холбогдох арга хэмжээнүүдийг авах | Засгийн газрын 11-11 мэдээллийн төвөөс Хороонд ирүүлсэн №1311306762 өргөдөл болон иргэн Х.Хулангаас гаргасан өргөдөл хүсэлт, иргэн Б.Мөнхкишигийн "Кристалсити" ХХК-тай холбоотой гаргасан өргөдөлийн дагуу Валютын хяналтын улсын байцаагчид дээрх 2 компанийн үйл ажиллагаанд шалгалт хийж өргөдлийн хариуг УИХ -ын ТГ-ын Захиргаа, нийтлэг үйлчилгээний хэлтэс болон иргэдэд албан тоотоор хүргүүлэв. Камдер ХХК-д Хорооны валютын хяналтын улсын байцаагчийн албан шаардлага, зөрчлийн тэмдэглэлийг хүргүүлж шалгалтын тайланг танилцуулсан. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын талаар "Кристалсити" ХХК-дулсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | шалгалтын ажлын явц болон үйл ажиллагаанд илэрсэн нийтлэг зөрчил, дутагдалд дүгнэлт хийж, нэгдсэн танилцуулга гаргах | | | |
| **64** | | **2.1.10.** | Зохицуулалтын байгууллагаас төвлөрүүлэх Улсын тэмдэгтийн хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний төлөлтөд хяналт тавих, бүрэн төвлөрүүлэх | Зохицуулалтын үйлчилгээний хөлс, улсын тэмдэгийн хураамжийг хугацаанд нь Хорооны дансанд төвлөрүүлж санхүүгийн хэлтэстэй тооцоо нийлсэн байх | Улсын байцаагчийн эрхийн үйл ажиллагаагаар хэрэгжүүлснээр хүү торгуулийн орлогоор 128.4 сая.төг хуримтлуулсныг улсын төсвийн орлогод төвлөрүүлэн төсвийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллалаа. Хорооны зохицуулалт үйлчилгээний орлогоор 1 млд 272 сая төгрөг оруулж, төсвийн дансанд байршуулан төсвийн гүйцэтгэлд зарцуулсан бөгөөд Улсын тэмдэгтийн хураамжийн орлогоор 111 байгууллагаас 91.5 сая төгрөг төвлөрснийг Орон нутгийн төсвийн орлогод 100 хувь төвлөрүүлэн ажиллалаа. | **100** |
| **65** | **2.2. Банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох чиглэлээр** | **2.2.1.** | Банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан этгээдийн баримт бичгийг хянаж шийдвэрлүүлэх | Хорооны зохицуулалтын хүрээнд хамаарах үйл ажиллагаа эрхлэх нөхцөл шаардлагыг хангаж буйд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авснаар харилцагч үйлчлүүлэгчдийн эрх ашиг хамгаалагдсан байна. | 2014 оны онд Брокер дилерийн 1, Хөрөнгө оруулалтын менежментийн компани 3, Давхар даатгалын 2, Даатгалын хохирол үнэлгээчийн 5, Даатгалын зуучлагчийн 7 Даатгалын хохирол үнэлэгчийн компани 3, Даатгалын зуучлагчийн компани 2, Банк бус санхүүгийн байгууллага 130, Хадгаламж зээлийн хоршоо 109, ХААБ-ын арилжааны зуучлагч байгууллага 2, Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх компани 2 нийт 261 тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлт шинээр ирүүлснийг бүртгэн холбогдох газруудад шилжүүлсэн. | **100** |
| **66** | | **2.2.2.** | | Зохицуулалтын хүрээнд хамаарах байгууллагуудын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох асуудлыг шийдвэрлүүлэх | Хорооны тогтоолоор **481**, Хорооны даргын тушаалаар **1381** нийт **1862** тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх, бүртгэлтэй холбоотой шийдвэрүүд гарсныг журмын дагуу А1 маягт болон цахим бүртгэл, бүртгэлийн дэвтрүүдэд дараах байдлаар бүртгэлээ.<br>***Үнэт цаасны бүртгэл, зохицуулалттай үйл ажиллагааны чиглэлээр*** : Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсон 12, бүртгэл сэргээсэн 5, бүртгэлээс хассан 17, оноосон нэрөөрчилсөн 1, Гадаадын хөрөнгийн бирж дээр үнэт цаас гаргасан 2, Нэгдмэл сонирхолтой этгээдээс бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авсан 2, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан 2, Үнэт цаасны зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон 5, үйл ажиллагаа нэмж олгосон 6, түдгэлзүүлсэн 18, сэргээсэн 2, хүчингүй болгосон 23, Харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавараар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | болсон 10, , Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 4 шийдвэр тус тус Хорооны тогтоолоор, эрх бүхий албан тушаалтан томилсон 4, Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх этгээдийн оноосон нэр өөрчилсөн 1, Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон 8 , Хүчингүй болсон БДК-ийн харилцагчдыг шилжүүлсэн 1 шийдвэр Хорооны даргын тушаалаар<br>***Даатгалын компани, даатгалын мэргэжлийн оролцогчдын чиглэлээр:***<br>Даатгалын компанийн эрх бүхий албан тушаалтан томилсон 9, Даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрөл шинээр олгосон 6, зуучлагчийн тусгай зөвшөөрөл шинээр олгосон 10, даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл түдгэлзүүлсэн 1, даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл сэргээсэн 1, даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл хүчингүй болгосон 1, дүрмийн санд өөрчлөлт оруулсан 5, даатгалын зуучлагчийн компанийн эрх бүхий албан тушаалтан томилсон 2 шийдвэр Хорооны тогтоолоор гарсныг, Даатгалын компанийн салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрөл олгосон 8, Даатгалын компанийн салбарын зөвшөөрөл хүчингүй болгосон 10, Даатгалын Хохирол үнэлэгчийн салбарын зөвшөөрөл шинээр олгосон 28, Даатгалын хохирол үнэлэгчийн дүрмийн сан, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон 1, Даатгалын зуучлагчийн салбарын зөвшөөрөл олгосон 79, Даатгалын зуучлагчийн дүрмийн сан, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон 4, даатгалын төлөөлөгчид тусгай зөвшөөрөл олгосон 651 даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл хүчингүй болгосон 428 шийдвэр Хорооны даргын тушаалаар<br>***Бичил санхүүгийн чиглэлээр:***<br>ББС-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон 120, түдгэлзүүлсэн 5, сэргээсэн 1, хүчингүй болгосон 5, үйл ажиллагаа нэмж олгосон 12, үйл ажиллагаа хүчингүй болгосон 2, үйл ажиллагаа түдгэлзүүлсэн 1, хаалттай өрийн бичиг гаргасан 4, ХЗХ-ны тусгай зөвшөөрөл шинээр олгосон 25, үйл ажиллагаа нэмж олгосон 2, сунгасан 28, түдгэлзүүлсэн 7, сэргээсэн 3, хүчингүй болгосон 6, олгохоос татгалзсан 2, ХЗХ-ны салбарын зөвшөөрөл олгосон 6 шийдвэр Хорооны тогтоолоор, ББСБ-ын салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрөл шинээр олгосон 14 , дүрмийн сан, хувь нийлүүлэгчид өөрчлөлт оруулсан 85, оноосон нэр өөрчилсөн 2, Хоёрдогч өглөгөөр эх үүсвэр татсан 2, ХЗХ-ны оноосон нэр өөрчилсөн 1 шийдвэр Хорооны даргын тушаалаар<br>***Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний чиглэлээр:*** ХААБ-ийн арилжааны зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон 2, ХААБ-ийн арилжааны зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан 31, Зэрэглэл тогтоох эрхийг хүчингүй болгосон 1, Үнэт цаасны зах зээлд оролцогчдод үйлчилгээ үзүүлэх аудитын компанийг шинээр бүртгэсэн 24, Үнэт цаасны зах зээлд оролцогчдод үйлчилгээ үзүүлэх хуулийн компанийг шинээр бүртгэсэн 13, Үнэт цаасны зах зээлд оролцогчдод үйлчилгээ үзүүлэх үнэлгээний компанийг шинээр бүртгэсэн 16, Үнэт цаасны зах зээлд оролцогчдод үйлчилгээ үзүүлэх хуулийн компани хүчингүй болсон 8, Даатгалын байгууллагад аудит хийх эрх шинээр олгосон 8, эрх түдгэлзүүлсэн 1, эрх сэргээсэн 1, хийх эрх | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүчингүй болгосон 3 шийдвэр ХААБ-ийн арилжааны зуучлагчийн дүрмийн сан, хувь нийлүүлэгчийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан 6, Даатгалын байгууллагад аудит хийх эрх олгосон 28, эрх сунгасан 20 тус тус Хорооны тогтоолоор шийдвэрлэлээ. | |
| **“Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, тогтвортой хөгжлийг бэхжүүлэх” стратегийн зорилтын хүрээнд: Гурав. Системийн эрсдэлийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх талаар** | | | | | | |
| **67** | **3.1. Санхүүгийн салбарын зохицуулалт, эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох талаар хийх судалгааны ажлын чиглэлээр** | **3.1.1** | Салбаруудын орон тооны бус зөвлөлийг шинэчлэн байгуулж, үйл ажиллагааг жигд тогтвортой хэвшүүлсэн байх | Санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг үйлчилгээний хүрээний байгууллагуудын зохицуулалт хяналтыг боловсронгуй болгох чиглэлээр хамтран ажиллаж үр дүнг тооцсон байна. | Бичил санхүүгийн орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах зорилгоор Хадгаламж зээлийн хоршооны болон Банк бус санхүүгийн байгууллагын бодлогын орон тооны бус зөвлөлийн хурлыг 2014 оны 5 дугаар сарын 16-нд хуралдуулж, ХЗХ, ББСБ-ын өнөөгийн байдал, салбарын хэмжээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тулгамдаж буй асуудал болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн. Даатгалын салбарын орон тооны бус зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгууллаа.<br>Төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачдын бүрэлдэхүүн бүхий "Үнэт цаасны зах зээлийн бодлогын зөвлөл", "Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн арилжааны орчны орон тооны бус бодлогын зөвлөл"-ийг Хорооны дэргэд байгуулсан. Энэхүү хоёр зөвлөл нь хуралдаж үйл ажиллагааны дүрмийг батлан цаг үеийн тулгамдсан асуудлаар хуралдан ажиллаж байна. Түс зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг Хорооны ажлын алба холбогдох төрийн болон төрийн бус байгууллагад хүргүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд "Үнэт цаасны зах зээлийн бодлогын зөвлөл" 3 удаа, "Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн арилжааны орчны орон тооны бус бодлогын зөвлөл" 2 удаа тус тус хуралдаад байна. Японы ЖАЙКА байгууллагаас Хороон дээр хэрэгжих төслийн хүрээнд Бодлогын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр техник туслалцаа авч ажиллах юм. | **100** |
| **68** | | **3.1.2** | Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын салбарын чиглэлээр бусад улс орнуудын эрх зүйн орчны талаар судалгаа хийх | Монгол улсын санхүүгийн зах зээлд одоо мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийг боловсронгуй болгох болон зах зээлийн цаашдын хөгжлийн хандлагыг олон улсын жишигт хүргэх чиглэлээр судалгааны баримт бичгүүд боловсруулагдсан байна. | Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нийцүүлэн Хорооноос шинээр болон шинэчлэн баталсан 20 гаруй журмыг боловсруулахад гадаадын шилдэг туршлага, зохицуулалтын орчны судалгаа хийж, дээрх журмын төслүүдийг боловсруулсан болно. Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаатай холбоотойгоор БНСУ-ын эрх зүйн орчинг, "ХАА-н биржийн арилжааны зуучлагч (брокер)-дийн үйл ажиллагааны зохицуулалтын журам" боловсруулах ажлын хүрээнд Япон, Сингапур орны туршлагыг судалсан.<br>ХАА-н биржийн хяналтын журмын төсөл боловруулахтай холбогдуулж Энэтхэгийн бараа түүхий эдийн зах зээл, биржийн хяналттай холбогдох материалыг судалж байна.<br>Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх талаар Орос, Хонконгийн зохицуулагч байгууллагуудын туршлагыг судалж байна. .Банк бус санхүүгийн үйл ажиллагааны шинэчлэн найруулсан хуулийн төсөлтэй холбогдуулан Филлипин, Чех, Ирланд, Тажикстан, Боливи улсын гадаад валютын арилжааны зохицуулалт, Герман, Орос, Украйн, Япон, Филлиппин улсын барьцаалан зээлдүүлэх газрын зохицуулалт, Солонгос, Япон, Герман улсын санхүүгийн түрээсийн тухай хууль болон зохицуулалтын талаар тус тус судалсан. Санхүүгийн байгууллагын хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн үйлчилгээний нэр | **100** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төрөл, тэдгээрийн үйл ажиллагааны онцлогийн талаар судалж, түүнд үндэслэн Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчлэн найруулсан хуулийн төсөлд заасан хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн гаргах үйл ажиллагааны нэр томъёоны тодорхойлолтод дүгнэлт гаргасан.<br>Судалгаанд дэлхийн томоохон санхүүгийн байгууллагууд болох HSBC Holding, Morgan Stanley, JAIC, MIC зэрэг байгууллагын бүтээгдэхүүн, үйл ажиллагааны талаар тусгав.<br>Энэтхэг /Индексжүүлсэн даатгал/, Герман/эрсдэлд суурилсан хяналт/, Вьетнам /индексжүүлсэн даатгал/, Филиппин /индексжүүлсэн даатгал/, Сингапур/хяналт шалгалт/ улсуудын даатгалын эрх зүйн орчны талаар судалгаа хийсний үндсэн дээр хуулийн төсөл, журам зааврын танилцуулгад тусгасан. Мөн Турк улсын даатгалын талаарх стандарт, журам зохицуулалтыг судалсан. /даатгалын арбитр, даатгалын тэтгэврийн сан, хөдөө аж ахуйн даатгалын сан, тэтгэврийн даатгал, даатгалын мэдээллийн болон даатгалын сургалт/Давхар даатгалын гэрээ болон СТОУС-4-ийн давхар даатгалын гэрээний талаар судалгаа хийлээ. Даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэх журмын судалгаа хийж, даатгалын бүтээгдэхүүний зохицуулалтын талаар БНСУ, Англи, Австрали, Казакстан зэрэг улсын веб хуудас болон Базелийн хорооноос гаргасан зөвлөмжийг судалсны үндсэн дээр Орон сууцны зээлийн даатгалын талаар заалтуудыг журмын төсөлд тусгасан. " ХАА-н биржийн арилжааны зуучлагч (брокер)-дийн үйл ажиллагааны зохицуулалтын журам" боловсруулах ажлын хүрээнд Япон, Сингапур орны туршлагыг судалж байна. ХАА-н биржийн хяналтын журмын төсөл боловсруулахтай холбогдуулж Энэтхэгийн бараа түүхий эдийн зах зээл, биржийн хяналттай холбогдох материалыг судалж байна. | |
| **69** | | **3.1.3** | Санхүүгийн зах зээлд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилт болон түүнийг боловсронгуй болгохтой холбоотой судалгаа хийх | | Хөрөнгө оруулалтын сангийн менежментийн компанийн тусгай зөвшөөрлийг олгох үед зах зээлд зохицуулалттай этгээд өөрийн тусгай зөвшөөрөл дээр хамтад нь тусгай зөвшөөрөл олгодог гадаадын томоохон хөрөнгө оруулалтын банкууд болон зохицуулагч байгууллагын зохицуулдаг аргачлалын талаар судалгаа хийлээ. Японы санхүүгийн үйлчилгээний агентлаг дээр AFPAC хөтөлбөрийн хүрээнд 2 албан хаагчийг 4 сарын хугацаатай дадлага хийлгэж Япон улсын хөрөнгийн зах зээл, түүний бүтэц, хууль эрх зүйн орчин, хяналт шалгалтын чиглэлээр 2 улсын хууль эрх зүйн зохицуулалтын харьцуулалт хийсэн. Улмаар тодорхой зохицуулалтыг нэмж оруулах, нэмэлт өөрчлөлт оруулах дүрэм, журмын жагсаалтыг гаргаад байна. АНУ, Их Британи, ОХУ, Япон, БНСУ, БНХАУ, Люксембург, Казакстан, Малайз, Филиппин, Лаос, Кени болон бусад улс орнуудын үнэт цаасны зах зээлийн болон бусад салбарын эрх зүйн зохицуулалтын талаар судалгаа хийж тухай бүр удирдлагад танилцуулсан.<br>Санхүүгийн зах зээлийн чиг хандлага, макро эдийн засгийн болон зохицуулалтын байгууллагуудын түвшинд эрсдэлийг хэмжих чиглэлээр эконометрикийн арга, аргачлал ашиглан хийж гүйцэтгэх санхүүгийн тогтвортой байдлын индексүүд, зохицуулалтын байгууллагуудын зэрэглэл тогтоох аргачлал боловсруулах, зах зээлийн гол гол үзүүлэлтүүдэд нөлөөлөх хүчин зүйлүүдийг судлах "Судалгааны ажлын төлөвлөгөө" -г гарган ажиллалаа. ББСБ-ын дүрмийн сангийн, ЗБДС-ийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг нэмж тогтоох, | **100** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Чанаргүй зээлийн зохистой харьцааны судалгааг тус тус гарган Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо той хийсэн уулзалтад танилцуулсан. Мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланд ХЗХ-ны зээлийн үйлчлүүлэгч бүтээгдэхүүн, зориулалт, ББСБ -ын зээлийн хүү болон шимтгэл хураамж, салбар тус бүрийн Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлэх 20 сая төгрөгөөс дээш болон сэжигтэй гүйлгээ зэрэг мэдээллийг хүлээн авдаг байхаар мастер файлд холбогдох өөрчлөлтийг оруулж, уг өөрчлөлтийг Fin-A системээр хүлээн авах, нэгтгэлд хамруулав.<br>Санхүү эдийн засгийн дээд сургуультай хамтран ажиллах гэрээг 2014 оны 3 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан бөгөөд гэрээний дагуу "Монголын санхүүгийн салбарын тогтвортой байдлын шинжилгээ, судалгаа, түүний үр дүнг тогтмол мэдээллэх", "Монголын бизнесийн байгууллагад зэрэглэл тогтоох арга зүйг боловсруулах" сэдэвт судалгааны ажлуудыг хийж судалгааны ажлын 1, 2 дугаар шатны тайлан гарсан. Судалгааны ажлуудтай холбоотойгоор Даатгалын байгууллага болон ББСБ-уудын зэрэглэлийг тогтооход шаардагдах тоон мэдээлэл, санал асуулга зэргийг цуглуулж судалгаандаа ашиглалаа. Мөн "TOP 20" индекс, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа" -г хийж эхлээд байна. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нийцүүлэн Хорооноос шинээр болон шинэчлэн баталсан 20 орчим журмыг боловсруулахад АНУ, Их Британи, ОХУ, Япон, БНСУ, БНХАУ, Люксембург, Казакстан, Малайз, Филиппин, Лаос, Кени болон бусад улс орнуудын үнэт цаасны зах зээлийн болон бусад салбарын эрх зүйн зохицуулалтын талаар судалгаа хийж журмын төслүүдийг боловсруулсан болно. | |
| **70** | | **3.1.4** | Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын салбарын эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдүүлэх, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, салбарын байгууллагуудын хөгжлийг олон улсын чиг хандлагад ойртуулах судалгаа хийнэ. | Хорооны зохицуулалтын салбарын эрсдэлийг тодорхойлж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх эхлэлийг тавина. | Хорооны зохицуулалттай этгээдэд эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх зохистой харьцаа, хянан шалгагчийн гарын авлагыг Дэлхийн банкны зөвлөхийн тусламжтайгаар боловсруулж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог 2015 оноос хэрэгжүүлэхээр ажиллаж байна.<br>Даатгалын чиглэлээр даатгалын байгууллагын эрсдэлийг үнэлэх CARAMELS -ийн арга, Даатгалын андеррайтинг ба бүтээгдэхүүний үнэ тогтоолтын эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, зах зээлийн эрсдэл, зохицуулалтын эрсдэлүүдийг судалж, танилцуулга гаргасан. Сингапурын даатгалын компанийн эрсдэлийн талаар судалгаа хийлээ. | **100** |
| **71** | | **3.1.5** | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог | | Үнэт цаасны чиглэлээр Дэлхийн банкны Korean Trust Fund төслийн шугамаар эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах, хяналт шалгалтын гарын авлага бэлтгэх чиглэлээр олон улсын зөвлөх Дэвид Уайт ажиллаж | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | бүрдүүлэх талаар судалгаа хийх | | мэргэжлийн оролцогчдод хийх хяналт шалгалтын удирдамжийг т боловсруулан иргүүлснийг судалж байна. Мөн "Эрсдэлд сурилсан хяналт, шалгалт "сэдвээр 3 хоногийн сургалтыг Хорооны болон Үнэт цаасны биржийн Хяналтын албаны ажилтнуудын дунд зохион байгууллаа.<br>Даатгалын чиглэлээр Урт хугацааны даатгагч, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч компани, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, даатгалын компанид актуар тооцоололтой холбоотойгоор гарч болзошгүй эрсдэлийг тодорхойлсон. Мөн урт хугацааны даатгагч, даатгалын зуучлагч, даатгалын хохиролүнэлэгч компаниудад газар дээрх шалгалт хийх шалгуур үзүүлэлт, тус компаниудыг эрсдэлээр нь ангилж шалгалт хийх байгууллагыг тодорхойлох заавар, шалгалтын хяналтын хуудсыг боловсруулсан. Зах зээлийн эрсдэл, Хөрвөх чадварын эрсдэл, Үйл ажиллагааны эрсдэл, Даатгалын эрсдэл, Харилцагчийн эрсдэлийн тодорхойлолтыг тус тус гаргалаа. | **100** |
| **72** | | | Үнэт цаасны салбарыг татварын бодлогоор дэмжих санал боловсруулах | Татварын тухай хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналыг эрх бүхий байгуулагад хүргүүлсэн байх | АНУ, Их Британи, ОХУ, Казакстан, Малайз, Филиппин, Лаос, Кени улсын татварын орчин, эрх зүйн зохицуулалтын талаар судалгаа хийгдсэн. Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг татварын бодлогоор дэмжих зорилгоор татварын багц хуульд нэмэлт,өөрчлөлт оруулах саналыг боловсруулсан ба УИХ -ын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлээд буй "Монгол улсын санхүүгийн салбарын 2020 он хүртэлх шинэчлэл, хөгжлийн хөтөлбөр"-т энэ талаар тусгалаа. | **100** |
| **73** | | **3.1.6** | Дэлхийн банкны санхүүжилтээр "Монголын даатгалын салбарын эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах" чиглэлээр дэлхийн банкны дотоодын болон олон улсын зөвлөхтэй хамтран судалгаа хийж, үндэсний давхар даатгалын компани байгуулах үндэслэл, зөвлөмж гаргасан байх | Судалгаа зөвлөмжийг гарган удирдлагад танилцуулсан байна | Дэлхийн банкны санхүүжилтээр "Монголын даатгалын салбарын эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах" чиглэлээр дэлхийн банкны дотоодын болон олон улсын зөвлөхтэй хамтран үндэсний давхар даатгалын компани байгуулах үндэслэл гаргах судалгааны ажлыг хийж зөвлөмж, тайлан, дүгнэлт гаргалаа. | **100** |
| **"Олон нийтийг сургах, санхүүгийн зах зээлийн тухай олон нийтийн ойлголтыг сайжруулах" Хорооны стратегийн зорилтын хүрээнд:<br>Дөрөв. Санхүүгийн зах зээлийн сургалт сурталчилгааны талаар** | | | | | | |
| **74** | **4.1. Зохицуулалтын байгууллагад явуулах сургалтын чиглэлээр** | **4.1.1** | Хорооны нийгмийн маркетингийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Санхүүгийн зах зээлийн талаар нийтэд мэдээлэгдсэн байна. | Хорооны нийгмийн маркетингийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр хэвлэл мэдээллийн 46, Төрийн 3, Төрийн бус 2 байгууллагуудтай "Санамж бичиг" -ийн хүрээнд хамтран ажиллаж байгаагаас гадна зохицуулалтын байгуулагуудын Мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж байна. "Санхүүгийн хяналт, зохицуулалтын байгууллага үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ойн арга хэмжээ"-ний хүрээнд " Хорооны зохицуулалтын байгууллагуудын чуулга | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | уулзалт”-ыг зохион байгуулав. Чуулга уулзалтад үнэт цаас, даатгал, ББСБ, ХЗХ-ны салбарын төлөөлөл болон Азийн хөгжлийн банкны зочид төлөөлөгчид зэрэг нийт 171 төлөөлөгч оролцож салбар тус бүрийн хяналт, зохицуулалт, өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар хэлэлцэж, нэгдсэн зөвлөмжийг гаргасан.<br>**Үнэт цаасны чиглэлээр** Зохицуулалттай зах зээлийн хүрээнд 20 телевиз, 1 радио, 3 өдөр тутмын сонин, 1 сэтгүүл, 2 сайт буюу нийт 27 хэвлэл мэдээллийн хэрэгсэлд 56 удаагийн ярилцлага, мэдээлэл өгч, 4 удаагийн нэвтрүүлэгт оролцож өөрийн үйл ажиллагаа, зохицуулалтын зах зээлийн талаарх мэдээлэл, мэдлэгийг тараан ажиллаа. Мөн, санхүү, эдийн засаг, НББ-ийн чиглэлээр мэргэшүүлдэг их, дээд сургуулийн оюутнуудад Хорооны үйл ажиллагаа, чиг үүрэг болон зохицуулаттай зах зээлийн өнөөгийн байдал сэдвээр хичээл заалаа. "Санхүүгийн зах зээлийн талаар сэтгүүлчдэд таниулах нь" сэдэвт сургалтанд зохион байгуулж , IPO, Хөрөнгө оруулалтын сангуудын хууль эрх зүйн орчин, Кастодианы үйлчилгээ сэдвүүдээр илтгэл тавин сэтгүүлчдийн зүгээс тавьсан асуултанд хариулт өгөв. Сургалтанд нийт 12 хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчид оролцсон.<br>Тайваны “Грэйт Тай” биржээс зохион байгуулсан “Үнэт цаасны Биржийн бус зах зээлийн арилжааны талаарх ойлголт” сэдэвт сургалтыг зах зээлийн оролцогчдын дунд зохион байгуулсан. АХБ-тай хамтран 2014 оны 9-р сарын 1-ний өдрөөс 5-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Хөрөнгө оруулалтын сангийн хяналт ба зохицуулалт" сэдэвт ОУ-ын сургалтыг зохион байгуулж уг сургалтад зах зээлийн оролцогчдыг ижил мэдээллээр хангав.<br>**Бичил санхүүгийн чиглэлээр** Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх журам, зааврын эмхтгэлийг шинэчлэн, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийг сурталчилсан, гадаад валютын арилжаа эрхлэхийг хүсэгч болон иргэдэд зориул сан плакат, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг сурталчилсан плакатуудыг тус тус хэвлүүлсэн.<br>Бичил санхүүгийн салбартай холбоотой мэдээлэл бүхий “ Microfinance in Mongolia” facebook хуудас нээн хөтлөн ажиллуулж байгаа бөгөөд тус хуудсаар олон нийтэд 14 мэдээллийг нэмж оруулаад байна.<br>**Даатгалын салбарын чиглэлээр** 9 ажлыг зохион байгуулав. Хорооны вэб сайтад Даатгалын салбарын сарын мэдээ, улирлын нэгтгэл танилцуулгууд, "Даатгалын салбарын зохицуулалт" сэдэвт сургалт, “Даатгалын хэтийн төлөв” сэдэвт өглөөний цайн уулзалт, "Эрсдэлд суурилсан хяналт" сэдэвт газрын дотоод сургалт, Цэцээгүний оргилын хог цэвэрлэх явган аялал, Канадын Toronto centre-тэй хамтран зохион явуулсан "Даатгалын сургалт", Даатгалын салбарынхан Чингисийн талбайн өтөлд мод тарьсан, Жолоочийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх Ажлын хэсгийн танилцуулга, Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх даатгалын бодлого, зохицуулалтын орон тооны бус зөвлөлийн хурлыг зохион байгуулсан талаарх мэдээллүүдийг нийтэлсэн. Мөн "Mongolian economy" сэтгүүлд гаргах даатгалын салбарын нэгтгэл танилцуулга, графикуудыг бэлтгэж, хүргүүлсэн.<br>Иргэд даатгуулагчдын олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зорилгоор news.mn цахим хуудсанд 7 удаагийн мэдээлэл гаргасан. | |
| **75** | | **4.1.2** | Зохицуулалтын байгууллагууд болон иргэдэд зориулсан сурталчилгаа мэдээллийг хүргэхэд олон нийтийн мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах ажлыг зохион байгуулж ажиллах | Нийтэд мэдээлэгдсэн байх | Тайлант онд нийт 31 телевиз, 2 радио, 2 мэдээллийн агентлаг, 10 сонин, 2 сэтгүүл, 1 ТББ, 14 сайт болон төрийн 3 байгууллагатай хамтран ажиллалаа. Хорооны удирдлагууд болон орон нутгийн 4 төлөөлөгч, мэргэжлийн холбоодын 16 төлөөлөл, зохицуулалтын хүрээний 7 байгууллагын төлөөлөлийг давхардсан тоогоор нийт 109 сэдвийн хүрээнд хэвлэл мэдээллийн хэрэгсэлд 391 удаагийн ярилцлагыг зохион байгуулав. | **100** |
| **76** | | **4.1.3** | Хорооны цахим хуудсаар мэдээллийг олон нийтэд хүргэх | Мэдээллийг цахим хуудсанд байршуулсан байх | Албан ёсны Фэйсбүүк, Твиттер хуудсууд, Мэдээллийн самбарууд болон "Өдрийн сонин", “Зууны мэдээ” сонинуудад тус бүр 21 удаа буюу нийт 126 удаагийн цацалтаар Хорооны хуралдааны тогтоолууд болон бусад мэдээ мэдээллийг олон нийтэд мэдээллээ. Хорооны хуралдаанаас гарсан нийт **469** тогтоолыг Хорооны албан ёсны цахим хуудсанд байршуулсан. Хорооны албан ёсны фэйсбүүк, твиттер хуудасны тогтмол хэрэглэгчийн тоо 3225, мэдээ, мэдээллийн хандалтын тоо 38372, нийтлэгдсэн мэдээ, мэдээллийг бусад хэрэглэгч рүү түгээсэн тоо /share, retweet хийсэн тоо/ 334-д хүрсэн байна. | **100** |
| **77** | | **4.1.4** | Хорооны удирдлага болон нэгжийн удирдлагыг хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд ярилцлага, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах | Ярилцлага, мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан байх | Олон улсын гэрээ болон "Санамж бичиг"-т гарын үсэг зурах , хурал зөвлөгөөн сургалт семинар, хэлэлцүүлэг, нээлттэй өдөрлөг зохион байгуулах үеэр болон , цаг үеийн асуудлаар иргэд олон нийтэд мэдээлэл хүргэх зорилгоор нийт давхардсан тоогоор 27 сэдвийн хүрээнд МҮОНТВ, Блүүмберг, Ийгл тв, C1 телевиз, Стар тв, Монгол тв, Етв, ТМ тв, ТВ-8 тв, UBS, 25-р суваг тв, Парламент тв, 2-р сурваг тв, NTV, ТВ-9 телевизүүд болон МҮОНР, УИХ -ын хэвлэл мэдээллийн алба, Зууны мэдээ, Үндэсний шуудан, Өглөөний мэдээ сонингууд болон www.news.mn, www.bloomberg.mn, www.hunnu.mn сайтуудад нийт 391 удаагийн ярилцлага болон мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулж, эдгээр мэдээллийн архивын сан үүсгэж ажилласан. | **100** |
| **78** | | **4.1.5** | Хороо болон зохицуулалтын хүрээний байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээллийн хэрэгслээр гарсан бүхий л мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүлээн авч удирдлагад танилцуулах, шаардлагатай | Хорооны удирдлагыг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд гарсан холбогдох мэдээлийн тоймоор хангасан байх. | Хороо болон зохицуулалтын хүрээний байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээллийн хэрэгслээр гарсан нийт 74 мэдээ, мэдээллийг 10 удаагийн танилцуулах хуудсаар удирдлагад танилцуулсан. "Силикат" ХК-ийн талаар www.hunnu.mn сайтад гарсан мэдээлэлтэй холбоотойгоор эрхий албан тушаалтнууд тус сайтад хариу ярицлага, мэдэгдэл өглөө. | **100** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | тохиолдолд тодруулга, тайлбар, дүгнэлт хийх холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх | | | |
| 79 | | 4.1.6 | Хорооны түүхэнд холбогдох болон онцлох үйл явдлыг баримтжуулах, баяжуулах, гэрэл зураг, дүрс бичлэгийн сан бүрдүүлэх | Хорооны үйл ажиллагаа, түүхэнд холбогдох баримтууд хадгалагдаж үлдсэн байна. | Хорооны хэмжээнд зохион байгуулагдсан нийт 54 үйл ажиллагааны талаарх гэрэл зураг, дүрс бичлэгийн сан бүрдүүлж ажиллалаа. | 100 |
| 80 | | 4.1.7 | Орон нутагт санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах | Сургалт семинар зохион байгуулагдсан байх | Хорооны төлөөлөгчдөөр дамжуулан орон нутаг дахь зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих удирдамжийг салбар бүр боловсруулан ажилласан. 2014 онд 50 ажилтан 17 аймагт хяналт шалгалт хийх, сургалт зохион байгуулах ажлаар томилогдон ажиллажээ. Санхүүгийн зохицуулах хороо, Монголын даатгагчдын холбооноос зохион байгуулсан даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох сургалт, даатгалын салбарын хууль тогтоомжийн сурталчилгааны ажлыг Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт зохион байгуулсан. Мөн Иргэдийн даатгалын боловсролыг дээшлүүлэх талаар "Бичил даатгалын зах зээлийн чадавхийг бэхжүүлэх төсөл" -тэй хамтран ажиллаж, телевизийн цуврал нэвтрүүлэг 3, телевизийн реклам 2, радиогийн реклам 2, зохиомжит нэвтрүүлэг 1 -ийг "Н Энтэртаймэнт" ХХК-аар гүйцэтгүүлэн, МҮОНТ, МҮОНР, UBS, TV9, Ийгл телевизүүдээр олон нийтэд түгээсэн. | 100 |
| 81 | | 4.1.8 | Орон нутгийн төлөөлөгчдийн сургалт, семинарыг зохион байгуулж, үр дүнг Хорооны удирдлагуудад танилцуулах | | Хорооны орон нутаг дахь төлөөлөгчдийн ээлжит семинарыг 2014 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан ба семинарт Хорооны удирдлагууд, Газар, хэлтсийн дарга нар болон 21 аймаг, нийслэл, дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, бүртгэлийн мэргэжилтнүүдийн хамт нийт 51 ажилтан буюу 80.9% нь оролцсон. Семинараар Хорооны орон нутаг дахь төлөөлөгчдийн 2013 оны жилийн ажлын тайлан, 2013 онд батлагдсан Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон тэдгээрийг дагалдан гарсан дүрэм журмууд, санхүүгийн салбарын өнөөгийн байдал, цаашид анхаарч ажиллах зарим асуудлаар Үнэт цаасны газар, Даатгалын газар, Бичил санхүүгийн газруудаас орон нутаг дахь зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаанд санхүүгийн салбарын хууль тогтоомжуудыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, орон нутагт сурталчлах, иргэдийг мэдээллээр хангах талаар чиглэл өглөө. | 100 |
| 82 | | 4.1.9 | Зохицуулалтын байгууллагууд, тэдгээрийн ажилтнуудад зориулсан сургалтыг | | **Үнэт цаасны чиглэлээр:** Хөрөнгө оруулалтын сангийн Нягтлан бодох бүртгэл , активын үнэлгээ, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоох , Монголын үнэт цаасны төлбөр ба кастодианы үйл ажиллагаа, Монголын үнэт цаасны төлбөр ба кастодианы үйл ажиллагаа, Сургагч багш бэлтгэх сургалтыг тус тус зохион байгуулж сургалтанд Сангийн яам, Монгол банк, МҮЦАЭХ, ҮЦТТХТ | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах | | ХХК, МХБ, Хөрөнгө оруулалтын сангийн менежментийн компаниуд болон аудитын байгууллагуудын төлөөлөл ийг хамрулав. Дэлхийн банкны олон улсын зөвлөх Дэвид Уайт "Эрсдэлд суурилсан хяналт, шалгалт " сэдвээр 3 хоногийн сургалтыг тус газрын болон МХБ-ийн хяналтын албаны албан хаагчдын дунд зохион байгуулсан.<br>"Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ын төсөл боловсруулах ажилтай холбогдуулан Үйлдвэр Хөдөө аж ахуйн яам, Биржийн зохицуулах зөвлөлийн ажлын алба, ХАА -н бирж ТӨХХК-уудын удирдлагуудыг оролцуулсан уулзалтыг зохион байгуулсан.<br>"ХАА-н биржийн арилжааны зуучлагч (брокер)-дийн үйл ажиллагааны зохицуулалтын журам" батлагдсантай холбогдуулж ХААБ -ын удирдлагуудад мэдээлэл хүргэх зорилгоор уулзалт, сургалт зохион байгуулсан.<br>Компанийн засаглалын үндэсний зөвлөлтэй хамтран компанийн засаглалын чиглэлээр хувьцаат компаниудын удирдлагуудын түвшинд 3 удаагийн сургалт зохион байгуулсан.<br>**Бичил санхүүгийн чиглэлээр:** ББСБ-ын салбарт 2014 онд зохион байгуулах олон нийтэд болон зохицуулалтын байгууллагад зориулсан сургалт, сурталчилгааны төлөвлөгөөг боловсруулж, Хорооны Ажлын албаны дарга, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны ерөнхийлөгчийн хамтарсан 2014 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 57 тоот тушаалаар батлуулсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу Холбооноос улирал бүр удирдах ажилтан, эдийн засагч, нягтлан бодогч нарт зориулсан сургалтуудыг шаттайгаар зохион байгуулан ажилласны үр дүнд нийт 9 тогтмол сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 309 ББСБ-ын ажилтнууд сургалтад хамрагдсан ба “Өдрийн сонин-“д 5 цуврал нийтлэл, 4 ТВ-ээр олон нийтэд зориулсан сурталчилгааны ажлыг хийгээд байна. Мөн уг төлөвлөгөөний дагуу Хорооноос шинээр тусгай зөвшөөрөл авсан ББСБ-уудын удирдах ажилтнуудын ур чадварыг нэмэгдүүлэх, банк санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, журам, заврын нэгдсэн ойлголтыг бий болгож, хэрэгжилтийг хангах зорилгоор “Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, журам заавар” сэдэвт сургалтыг зохион байгуулахаар Хорооны Ажлын албаны даргын 6 дугаар сарын 3-ны өдрийн 127 дугаар тушаалаар төсөв, хөтөлбөрийг батлуулснаар сургалтыг 7 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулж, нийт 75 ББСБ-ын удирдах ажилтнууд хамрагдсан.<br>2/ Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж буй 75 ББСБ -д шинээр нэвтрүүлэх санхүүгийн программын талаарх сургалтыг “Итауко” ХХК-тай хамтран хийсэн.<br>3/ Хороо, Монголбанк, Тагнуулын ерөнхий газартай хамтран Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг таниулах сэдэвт сургалтыг 5 дугаар сарын 26-ны өдөр Маршал харшид хийж, нийт 30 ББСБ оролцсон.<br>4/ 11 дүгээр сарын 17 -22-ны хооронд Люксембургийн Вант Улсын Санхүүгийн технологи, солилцооны агентлаг буюу ATTF байгууллагаас хийсэн “Бичил санхүүгийн байгууллагын стратеги, үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага” сэдэвт сургалтыг Улаанбаатар хотод Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбоо, МОН-004, Хорооны хамтран зохион байгуулахад Хороо өөрөө ж зохион байгуулалтыг хариуцан ажилласан<br>**Даатгалын чиглэлээр:**<br>1/ 2013 онд шинээр болон шинэчлэн батлагдсан журам, заавруудыг даатгалын мэргэжлийн холбоод болон даатгалын компаниудын удирдах ажилтнуудад таниулах зорилготой "Даатгалын салбарын зохицуулалт" сэдэвт сургалт, семинарыг зохион байгуулсан. Сургалт, семинарт 21 хүн хамрагдсан.<br>2/ АЖДХ-ны орон нутгийн төлөөлөгчдөд зориулсан сургалтад оролцож санал солилцов.<br>3/ Даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 8 банкны холбогдох хэлтсийн удирдах ажилтнуудтай уулзалт зохион байгуулж, Банкны даатгал зуучлалд тулгамдаж буй асуудлууд, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцож, Хорооны 2014 оны 170 дугаар тогтоолоор Хорооны 2008 оны 291 дүгээр тогтоолоор батлагдсан журамд орсон нэмэлт өөрчлөлтийг танилцуулсан. | |
| **83** | | **4.1.10** | Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд эрх олгох сургалтын системийг боловсронгуй болгох | Сургалтын хөтөлбөрийг холбогдох мэргэжлийн сургалтын байгууллагын оролцоотойгоор боловсруулсан байх | 2014 оны сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн сургалтын байгууллагын оролцоотойгоор хамтарч боловсруулсан. “Мэргэшлийн шалгаруулалт явуулах, мэргэжилтэнд эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай журам" -ыг батласан бөгөөд шинэчилсэн журмын дагуу мэргэшлийн зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл, бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Хөрөнгийн зах зээл ажил, үйлчилгээ явуулах мэргэжилтнүүдийг аттестатчилах болон шинээр эрх олгох сургалтыг шинэчилсэн хөтөлбөрөөр зохион байгуулж ажилласан. | **100** |
| **84** | | **4.1.11** | Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн байгууллагын удирдах ажилтны 3 дугаар зөвлөгөөнийг зохион байгуулах | Сургалтын төлөвлөгөө гаргаж зохион байгуулсан байх. | Уг зөвлөгөөнийг Санхүүгийн салбарын нэгдсэн чуулга уулзалт нэртэйгээр Хорооны зохицуулалтад байгаа үхб мэргэжлийн байгууллагыг оролцуулан зохион байгуулсан. Зөвлөгөөнийг Хорооны зохицуулалттай бүх зах зээлийн удирдах ажилтнууд оролцон мэдээлэл, санал солилцох байдлаар зохион байгуулсан. | **100** |
| **85** | | **4.1.12** | Даатгалын мэргэжлийн оролцогчдод зориулсан сургалтуудыг зохион байгуулж, шалгалт авах | Сургалтууд явагдаж, оролцогчдын мэдлэг, мэдээлэл дээшилсэн байна. | Даатгалын хохирол үнэлэгчдийн холбоотой хамтран даатгалын хохирол үнэлгээний сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 69 иргэн оролцсоноос 47 иргэн тэнцсэн байна.<br>Мөн Монголын даатгалын зуучлагчдын холбоотой хамтран Нийслэл болон аймаг, орон нутагт нийт 25 удаагийн банкны ажилтнуудад зориулсан даатгалын зуучлалын сургалтыг зохион байгуулж, Хаан банк, Хас банк, Капитал банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Төрийн банк, Голомт банк, Ариг банк, Худалдаа хөгжлийн банкны нийт 1002 ажилтан сургалтад хамрагдсанаас шалгалтад 893 ажилтан тэнцсэн байна. Торонтогийн центр сургалтын төвтэй хамтран зохион байгуулсан сургалтад даатгалын мэргэжлийн оролцогч компаниудыг оролцуулан сургалтыг зохион байгуулсан. | **100** |
| **86** | | **4.1.13** | Монголын даатгагчдын холбоотой хамтран даатгалын төлөөлөгчийн сургалтад хяналт | | Даатгалын төлөөлөгчийн сургалтыг 13 удаа зохион байгуулж 17 аймгийг хамруулсан 407 даатгалын төлөөлөгчөөс шалгалт авч, хяналт тавьж ажилласан. | **100** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | тавьж оролцох, шалгалт авах | | | |
| **87** | | **4.1.14** | Даатгалын актуарын сургалт зохион байгуулж, хяналт тавих, шалгалт авах | | "KOIKA"- байгууллагын төслийн зөвлөхтэй хамтран даатгалын компаниудын актуарчдын мэргэжлийн түвшинг тодорхойлох шалгалтыг авсан бөгөөд шалгалтанд 14 даатгалын компанийн актуарчид оролцсон. “Эрсдэлийн удирдлага”, “Даатгалын онол” гэсэн сэдвүүдээр нийт 8 удаа даатгалын газрын ажилтнууд хамрагдсан сургалт зохион байгуулсан.<br>Даатгалын компаниудын актуарчидад зориулсан сургалт зохион байгуулсан. Сургалтанд ердийн даатгалын 11 компанийн 12 актуарч, урт хугацааны даатгалын компанийн 1 актуарч оролцсон. | **92** |
| **88** | | **4.1.15** | Даатгалын салбарын 80 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх, ойн арга хэмжээнүүдийн хүрээнд хийгдсэн ажлуудыг олон нийтэд сурталчлах | Даатгалын мэргэжлийн холбоодтой хамтарч төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн байна | Даатгалын салбарын 80 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх, ойн арга хэмжээнүүдийн хүрээнд “Даатгалын хэтийн төлөв” сэдэвт өглөөний цай уулзалтыг зохион байгуулж, мэргэжлийн холбоод болон даатгалын компаниудын удирдлагуудтай санал солилцов. “Хүртээмжтэй даатгал Улаанбаатар-2014” олон улсын чуулга уулзалтыг зохион байгууллаа.“Даатгалын салбарын нээлттэй өдөрлөг”-ийг зохион байгуулж, 12 даатгалын компани, Бичил даатгалын төсөл, Албан журмын даатгагчдын холбоо, даатгалын мэргэжлийн оролцогчдыг оролцуулав. "Даатгалын салбарын нээлттэй хэлэлцүүлэг" зохион байгуулсан. Явган аялал зохион байгуулж Богд хан уулын Цэцээ-Гүн оргилын ойр орчим болон Төр хурахын амнаас Цэцээ-Гүн хүртэл 7 км-ийн замын дагуух ахуйн хогийг цэвэрлэсэн. Тус арга хэмжээнд МДХ, МДЗХ болон даатгалын компаниудын 60 орчим ажилчид идэвхитэй оролцлоо. Дээрх зохион байгуулсан ажлуудын талаарх мэдээллийг тухай бүр Хорооны вэб сайтад байршуулж, олон нийтэд хүргэсэн. | **100** |
| **89** | **4.1. Зохицуулалтын байгууллагад явуулах сургалтын чиглэлээр** | **4.1.16** | Люксембургийн МОН-004 төсөлтэй хамтарч ажиллах | Сургалт зохион байгуулагдсан байна | Хонконг,Тайланд, Камбож, Энэтхэг, Солонгос, Турк, Люксембург улсуудад зохиогдсон чуулга уулзалт, сургалтад 17 ажилтныг төслийн санхүүжилтээр оролцуулав. Мөн дотооддоо зохион байгуулсан хэлэлцүүлэг, семинар, сургалтыг төслийн дэмжлэгтэйгээр 6 удаа зохион байгууллаа. Хорооны архивын баримтыг зориулалтын нягтаруулсан 32 үүгэнтэй болгож баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, албан хэрэг хөтлөлтийг тусгай програм ашиглан бүртгэдэг болох, зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд олгодог тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, эрхийн нэгдсэн бүртгэлд програм ашиглах талаар ажлын гүйцэтгэл гаргах ажлуудад МОН -004 төслөөс хөрөнгө гаргуулан дээрх ажлуудыг хийж гүйцэтгэлээ.<br>Даатгалын чиглэлээр 1 уулзалт хэлэлцүүлэг, 4 сургалт, хүүхдийн гар зургийн уралдаан зэрэг нийт 6 ажлыг зохион байгуулсан байна. | **100** |
| **90** | | **4.1.17** | Даатгуулагчид зориулсан гарын авлага хэвлүүлэх | Даатгуулагчийн гарын авлагыг хэвлүүлсэн байна | Даатгуулагчийн гарын авлагыг 3 хувилбараар боловсруулан, 5000 хувь хэвлүүлсэн бөгөөд, АЖДХ, Бичил даатгалын мэдээллийн төвөөр дамжуулан олон нийтэд түгээж байна. | **100** |
| **91** | | **4.1.18** | Даатгалын зах | | Ерөнхий сайдын зөвлөх, СЯ, ЭЗХЯ-ны газрын дарга нар болон мэргэжлийн | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | зээлийн талаар танилцуулга гаргаж, мэргэжлийн арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулах | Танилцуулга гаргасан байна | банкны захирал нарт давхар даатгалын чиглэлээр танилцуулга хийв. Сар, улирал бүр даатгалын зах зээлийн талаар нэгтгэл, танилцуулга гаргаж, Хорооны вэб сайтад байршуулсан. Санхүү эдийн засги йн дээд сургуулийн 90 жилийн ойн хүрээнд болох "Монголын нийгэм-эдийн засгийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд" сэдэвт ОУ-ын эрдэм шинжилгээний хуралд "Ердийн даатгалын компанийн төлбөрийн чадварын эрсдэлийг тооцоолох нь" сэдвийн хүрээнд илтгэл хэлэлцүүллээ. | **100** |
| **92** | | **4.1.19** | Даатгалын зах зээлийн талаар мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх талаар өдөрлөг, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах: НҮБХХ-ийн "Бичил даатгалын зах зээлийн чадавхийг бэхжүүлэх төсөл"-тэй хамтран, хүртээмжтэй даатгалын талаарх олон нийтэд хандсан сурталчилгааг зохион байгуулах | Даатгалын талаар телевизийн сурталчилгаа, хэвлэмэл хуудас хийгдэж, сургалт зохион байгуулагдсан байна | НҮБХХ-ийн "Бичил даатгалын зах зээлийн чадавхийг бэхжүүлэх төсөл"-тэй хамтран "Хүртээмжтэй даатгал 2014" Олон улсын чуулга уулзалтыг зохион байгуулсан. Мөн төслийн санхүүжилтээр "Даатгалын салбарын зохицуулалт" сэдэвт сургалт, семинарыг зохион байгуулсан. Семинараар 2013-2014 онд шинээр болон шинэчлэн батлагдсан журам, зааврыг даатгалын мэргэжлийн холбоод болон даатгалын компаниудын удирдах ажилтнуудад танилцуулав. Мөн Иргэдийн даатгалын боловсролыг дээшлүүлэх талаар "Бичил даатгалын зах зээлийн чадавхийг бэхжүүлэх төсөл" -тэй хамтран ажиллаж, телевизийн цуврал нэвтрүүлэг 3, телевизийн реклам 2, радиогийн реклам 2, зохиомжит нэвтрүүлэг 1-ийг "Н Энтэртаймэнт" ХХК-аар гүйцэтгүүлэн, МҮОНТ, МҮОНР, UBS, TV9, Ийгл телевизүүдээр олон нийтэд түгээсэн. | **100** |
| **93** | | **4.1.20** | АХБ-ны төслийн хүрээнд сургалт, сурталчилгааны чиглэлээр хамтран ажиллах | Төсөлтэй хамтран ажилласан байх | ХЗХ-дын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй журам, зааврыг боловсронгуй болгох, тэдгээрт Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж байгаа МОН-9152 төслийн олон улсын зөвлөхүүдээс өгсөн санал, зөвлөмжийг хэлэлцэх хэлэлцүүлэг болон ХЗХ-дын зохицуулалтын эрх зүйн орчин, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналт шалгалтын талаар бүх ХЗХ-дыг хамруулан бүсчилсэн 5 удаагийн хэлэлцүүлэг, сургалтыг Улаанбаатар хот, Орхон аймгийн Баян-Өндөр сум, Дундговь аймгийн Мандалговь сум, Увс аймгийн Улаангом суманд тус тус амжилттай зохион байгуулж, нийт 136 ХЗХ-ны 348 удирдах ажилтнууд оролцуулав. Азийн хөгжлийн банкны төслийн санхүүжилтээр "Монгол улсад ХЗХ үүсэж, хөгжсөн түүхийг өгүүлсэн баримтат кино" бүтээгдсэн ба "Зохицуулалтын байгууллагуудын анхдугаар чуулга уулзалт"-д оролцогчдод үзүүлж, телевизийн 2 сувгаар давталттайгаар цацагдсан. Дээрх төслийн санхүүжилтээр ХЗХ-ны эрх зүйн орчин, төрөөс үзүүлж буй үйлчилгээ болон ХЗХ-ны хоршооны талаарх ойлголтыг олон нийтэд хүргэх, салбарын ач холбогдлын талаар сурталчлах Хороо, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын холбоо, ХЗХ-ны болон ХЗХ-дын гишүүдийн төлөөлөл оролцсон | **100** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | телевизийн нэвтрүүлгийг бүтээсэн ба МҮОНТ -ээр олон нийтэд цацагдсан. Азийн хөгжлийн банкнаас зохион байгуулсан JFPR төслүүдийн өдөрлөгт идэвхтэй оролцож, Хорооны үндсэн чиг үүрэг, Ядуурлыг бууруулах Японы сангаас Азийн хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлж Хорооны хэрэгжүүлж буй "Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх" төслийн хүрээнд ХЗХ-дын хөгжилд бий болсон ахиц дэвшлийг олон нийт болон өдөрлөгт оролцогчдод танилцуулах сурталчилгаа хийгдсэн. Бичил санхүүгийн газрын ажилтнуудын ур чадварыг дээшлүүлж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын арга зүй, санхүүгийн байгууллагуудын эрсдэлийг тооцож бүртгэх болон эконометриксийн талаарх ерөнхий ойлголтыг бий болгож, түүнийг бодлого боловсруулах, шийдвэр гаргахад хэрхэн ашиглах талаарх практик мэдлэгийг олгох зорилгоор "Эрсдэлд суурилсан хяналт шалгалт" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд Бичил санхүүгийн газрын 25 ажилтан хамрагдсан байна. | |
| **94** | | **4.1.21** | АХБ-ны төслийн хүрээнд төслийн үндэсний зөвлөхтэй хамтран иргэдэд зориулсан гарын авлага бэлтгэх | Гарын авлага хэвлэгдэн тараагдсан байх | Төслийн үндэсний зөвлөхөөс боловсруулсан "Хадгаламж, зээлийн хоршоо гэж юу вэ" сэдэвт иргэдэд зориулсан гарын авлагыг 2000 ширхэг хэвлэн ХЗХ-дын бүсчилсэн сургалтын үеэр орон нутгийн иргэдэд тараасан. Монголын хадгаламж, зээлийн хоршоодын холбооноос боловсруулсан "ХЗХ-дын үйл ажиллагаанд мөрдөх бодлого, журмын үлгэрчилсэн гарын авлага" баримт бичгийг хянаж, санал өгсөн. Гарын авлагыг 600 хувь хэвлэн шинээр ХЗХ байгуулахыг хүсч буй иргэд болон ХЗХ -дод тараагдаж байна. "ХЗХ-ны зохицуулалт, хяналт шалгалт, чадавхижуулалт" гарын авлага, "Хоршооллын хөдөлгөөн ба Хадгаламж зээлийн хоршоо"товхимол боловсруулан 300 хувийг хэвлэж, JFPR үзэсгэлэнгийн үеэр олон нийтэд танилцуулагдсан ба нийт ХЗХ-дод хүргэгдэж байна. | **100** |
| **95** | | **4.1.22.** | Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх аудит, үнэлгээний байгууллага, хуулийн компанийн ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах | Сургалт хийгдсэн байх | Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх 12 аудитын компани шинэчлэгдэн бүртгэгдэж, 14 аудитын компани шинээр бүртгэгдсэн. Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэхээр 14 үнэлгээний компани шинэчлэн бүртгүүлж.1 үнэлгээний компани шинээр бүртгэгдээд байна. | **100** |
| **96** | | **4.1.23** | Даатгалын байгууллагад аудит хийх эрх олгохтой холбоотой сургалтыг зохион байгуулах | Сургалт хийгдсэн байх | Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааны төрөлжсөн сургалтыг 2014 оны 11 дүгээр сарын 20 -21-ний өдрүүдэд ММНБИ -тэй хамтран зохион байгуулсан. Уг сургалтад эрх сунгуулах болон шинээр эрх авах аудиторууд хамрагдсан бөгөөд тус сургалтад нийт 54 хүн оролцсон бөгөөд шалгалтад нийт 48 хүн хамрагдсан. | **100** |
| **97** | | **4.1.24** | ХАА-н биржийн зуучлагч (брокер)-д биржийн арилжаанд оролцох | Батлагдсан төлөвлөгөөний дагуу сургалт зохион | Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-дад зориулсан мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх олгох сургалтын хөтөлбөрийг Биржийн зохицуулах хөвлөлийн ажлын алба, Хөдөө аж ахуйн гаралтай бараа,түүхий эд бэлтгэн нийлүүлэгч мэргэшсэн брокеруудын нэгдсэн холбоотой | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх олгох сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах төлөвлөгөөг батлуулж, зохион байгуулах | байгуулагдсан байх | хамтран баталсан. Сургалтыг Холбоотой хамтран зохион байгуулсан ба сургалтанд хамрагдаж шалгалтанд тэнцсэн 29 этгээдэд биржийн арилжаанд оролцох мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх өгч, сертификат олгосон. | **100** |
| **98** | | **4.1.25** | ХАА-н биржийн зуучлагч (брокер)-ийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2013 оны 77 дугаар тушаалаар батлагдсан Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заав  рын дагуу гаргах тухай нягтлан бодох бүртгэлийн сургалт зохион байгуулах | Сургалт зохион байгуулагдсан байх | ХААБ-ын удирдлага, ажилтнуудын оролцсон уулзалт дээр нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа дутагдал, асуудлуудын талаар танилцуулга, зааварчилгаа өгч, хэлэлцүүлэг хийлээ. | **100** |
| **99** | | **4.1.26** | Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор журмыг сурталчлах | Төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлсэн байх | Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагааг нэвтрүүлэх зорилгоор журмыг сурталчлах төлөвлөгөөг батлуулан ажилласан. Төлөвлөгөөний дагуу Малайзын зэрэглэл тогтоогч байгууллага /RAM/-с туршлага судлах, хоблогдох мэдээ, материал авахаар хүсэлт гаргасан. Мөн АХБ -тай энэ үү чиглэлээр хамтран ажиллах хүсэлтийг гаргаад байна. Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох чиглэлээр арилжааны банк, даатгал, үнэт цаасны компани болон бусад мэргэжлийн байгууллагын удирдлагын түвшинд уулзалт -хэлэлцүүлгийг зохион байгуулж, уг хэлэлцүүлгээс санал зөвлөмжийг гаргасан болно. | **100** |
| **100** | | **4.1.27** | Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагааны талаарх төрөлжсөн сургалтыг зохион байгуулах | Батлагдсан төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулагдсан байх | АХБ-тай Монгол улсын санхүүгийн зах зээлд зээлжих зэрэглэлийн салбарыг хөгжүүлэх тал дээр хамтран ажиллах, төсөл боловсруулах талаар ярилцаж санал солилцсоны үр дүнд зээлжих зэрэглэлийн үйлчилгээг Монголд хөгжүүлэх, нэврүүлэх төсөл хэрэгжүүлэх талаар мэдэгдэл ирүүлсэн. “Зээлжих зэрэглэлийн тогтолцоог Монгол Улсад хөгжүүлэх, түүний ач холбогдол” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. | **100** |
| **101** | | **4.1.28** | ХАА-н бирж дээр арилжаалагдах үүсмэл санхүүгийн хэрэгсэлийн төрөлжсөн сургалтыг | Сургалт хийгдсэн байх | ХАА-н Бирж дээр санхүүгийн үүсмэл хэрэгсэл арилжих систем суурилуулах хөрөнгө оруулалтын асуудал 2014 онд шийдэгдээгүй тул төлөвлөгөөний дагуу зохион байгуулах сургалт хойшлогдсон. Мөн ХАА -н биржтэй хамтран “Бараа, түүхий эдийн зах зээл дээрх үүсмэл санхүүгийн хэрэгслийн тухай ойлголт, эрсдэлүүд” сэдэвт сургалтын хөтөлбөрийг боловсруулж сургалт зохион байгуулж хянан шалгагчдыг хамруулав. БНХАУ-ын Жэнжоугийн хөдөө аж | **100** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах | | ахуйн бараа, түүхий эдийн биржийн туршлага судлав. | |
| 102 | | 4.1.29 | Үндэсний мөнгөн тэмдэгтээр төлбөр тооцоог илэрхийлж, гүйцэтгэхийг сурталчлах чиглэлээр олон нийтийн өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүдтэй хамтран ажиллаж зөвлөгөө, ярилцлага, хэлэлцүүлэг хийх ажлыг зохион байгуулах | Олон нийтэд мэдээлэл хүрсэн байх | Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор нийт 4 ХХК-д шалгалт хийсэн. Мөн 2013 онд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчилд ногдуулсан торгуулийн үлдэгдэлийг төлөөгүй байсан 4 компаниар 18.9 сая төгрөгийг төлүүллээ. | 100 |
| 103 | | 4.1.30 | Санхүүгийн талаар сэтгүүлчдийн мэдлэгийг дээшлүүлэх, санхүүгийн зах зээлийн талаар үнэн, бодитой мэдээлэл түгээх зорилгоор санхүүгийн зах зээлийн сургалтыг зохион байгуулах | Сургалт зохион байгуулагдсан байна. | "Санхүүгийн зах зээлийн талаар сэтгүүлчдэд таниулах нь" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд нийт 12 хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчид оролцсон. Сургалтаар Хорооны чиг үүрэг болон зохицуулалтын хүрээний асуудлуудын талаар сэтгүүлчдэд мэдээлэл өгсөн. Түүнчлэн IPO, Хөрөнгө оруулалтын сангуудын хууль эрх зүйн орчин, Кастодианы үйлчилгээ, Компанийн засаглалын эрх зүйн орчин Хадгаламж, зээлийн хоршооны эрх зүйн орчин, Давхар даатгал сэдвээр тус тус хичээл заасан. | 100 |
| 104 | | 4.1.31 | Их, дээд сургуулийн оюутнуудад зориулж санхүүгийн зах зээлийн талаар мэдээлэл өгөх, Радио, ФМ-ийн хуваарьт нэвтрүүлэгтэй болох энэ чиглэлээр медиа компанитай хамтран ажиллах | Олон нийтийг шаардлагатай мэдээллээр хангасан байна. Вэб сайтад Хорооноос гарсан журам, зааврыг байршуулж иргэдийг үнэн зөв мэдээллээр хангасан байх. | Эрдэм мэдлэг түгээх төв ТББ -ын зүгээс эрхлэн гаргадаг "Санхүүгийн лавлах мэдээ" сонинтой 03 дугаар сарын 28-нд хамтран ажиллах гэрээ байгуулсан. Хамтын ажиллагааны хүрээнд тус сонины ТВ -1 телевиз болон ФМ 107.5 радиогоор цацагддаг хуваарьт нэвтрүүлгээр Хороны үйл ажиллагааны талаар тогтмол мэдээлэл өгөхөөр болсны дагуу мэдээлэл өгөн ажиллаж байна. Тайлант хугацаанд ТВ-1 телевизээр 2 удаагийн бүрэн хэмжээний ярилцлагын нэвтрүүлэг, ФМ107,5 радиогоор 4 удаагийн нэвтрүүлэг тус тус бэлтгэн олон нийтэд хүргэсэн. Үнэт цаасны газраас их, дээд сургуулийн оюутан, судлаач нарт зориулж санхүүгийн зах зээлийн талаар мэдээлэл өгсөн 3 удаагийн уулзалтын талаарх мэдээллийг Хорооны цахим хуудас, фэйсбүүк, твиттер хуудсууд болон мэдээллийн самбарт байршуулж мэдээлсэн. Хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхэлдэг “Жи Жи Медиа” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж хамтран ажиллаж байна. | 100 |
| 105 | | 4.1.32 | Хорооны вэб хуудсыг мэдээ, | | Тайлант хугацаанд Хороны вэб сайтын "Мэдээ мэдээлэл" цэсэнд нийт 100 мэдээ, "Журам, заавар, тогтоол "цэсэнд 405 журам, заавар, тогтоол, тэдгээрийн | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдээллээр баяжуулан шинэчлэх, нэгжүүдээс ирүүлсэн мэдээллийг байршуулах ажлыг зохион байгуулж, олон нийтийг үнэн зөв мэдээллээр хангах | Хорооны вэб хуудас үнэн зөв мэдээллээр шинэчлэгдсэн байх. | өөрчлөлт, нэмэлт, "Тусгай зөвшөөрөл, эрх, бүртгэл эзэмшигч" цэсэнд 164 байгууллагын мэдээллийн өөрчлөлт, нэмэлт, "Статистик" цэсэнд 29 тайлан, мэдээ, "Компанийн засаглал" цэсэнд 2 дэд цэс нээж, нийт 7 мэдээлэл, "Бидний тухай" цэсийн "Байгууллагын бүтэц" хэсэгт СЗХ -ны шинэчлэгдсэн бүтэц болон Хяналтын зөвлөлийн шинээр томилогдсон дарга, гишүүдийн мэдээллийг тус тус байршуулан ажиллалаа.<br>Түүнчлэн "Санал асуулга" цэсэнд "Иргэдийн санхүүгийн боловсролд зориулан хийгдэх гэж буй 26 ангит олон ангит уран сайхны кинонд ямар төрлийн агуулга бүхий мэдээлэл багтаахыг хүсэж байна вэ?" гэсэн асуулт бүхий санал асуулгыг 1 сарын хугацаанд байршуулж иргэдээс нийт 161 саналыг авлаа. | 100 |
| 106 | 4.2. Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр | 4.2.1 | Хорооны вэб хуудас, фейсбүүк болон твиттер хуудсанд асуулт, хариулт, санал, гомдлын буланг идэвхтэй ажиллуулж, иргэд байгууллагын асуултад тухай бүр хариулт өгч байх, Хорооны мэдээллийн самбарын мэдээллийг тогтмол шинэчлэх, хүртээмжтэй болгох ажлыг зохион байгуулах, хариуцсан албан тушаалтан, нэгжтэй хамтран ажиллах | Иргэдийн санал, хүсэлтэд тухай бүр хариулт өгсөн байх, Мэдээлэл тогтмол шинэчлэгдэж, үнэн зөв мэдээлэл иргэдэд хүрсэн байх. | Хорооны албан ёсны фэйсбүүк хуудсанд иргэдээс ирсэн салбарын үйл ажиллагаатай холбоотой нийт 21 асуултыг хүлээн авч хариулт өгөх ажлыг шуурхай зохион байгуулж ажиллалаа. | 100 |
| 107 | | 4.2.2 | Хорооны удирдлагууд санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа эрхлэж буй мэргэжлийн холбоодтой мэдээлэл солилцох уулзалтыг тогтмол зохион байгуулж ажиллах | | Үнэт цаас, Бичил санхүү, Даатгалын зах зээлд оролцогчдын Мэргэжлийн холбоодтой "Өглөөний цай" уулзалтыг 3 удаа зохион байгуулсан. | 100 |
| 108 | | 4.2.3 | Санхүүгийн зах | | Хадгаламж зээлийн хоршоодын удирдах ажилтнуудад зориулсан хэлэлцүүлэг | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | зээлийн талаарх мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх талаар өдөрлөг, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах | Хорооноос гаргасан шийдвэр болон санхүүгийн зах зээлийн талаарх мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд тухай бүр хүргэснээр санхүүгийн зах зээлд оролцогчид, хөрөнгө оруулагчид, иргэдийн итгэл итгэлийг дээшлүүлж, зохицуулалтын байгуулагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажилласан байна. | болон Даатгалын нээлттэй өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулахад холбогдох газруудтай хамтран ажиллаж, тухай бүр хэвлэл мэдээллийн хэрэгслээр арга хэмжээний талаар мэдээлэх ажлыг зохион байгуулсан. Тайлант хугацаанд 1 дээд хэмжээний айлчлалын арга хэмжээ, 1 [illegible] арга хэмжээ, 1 олон улсын форум, 1 нээлттэй өдөрлөг,1 хэлэлцүүлэг, 2 семинар, 16 сургалт, 6 санамж бичиг байгуулах арга хэмжээ зохион байгуулж хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллалаа. | **100** |
| **109** | | **4.2.4** | Иргэдэд зориулсан санхүүгийн зах зээлийн талаарх гарын авлага, тараах материал гаргах, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэх ажлыг зохион байгуулах | | Иргэдийн санхүүгийн боловсролд зориулан 26 ангит телевизийн киног Азийн хөгжлийн банкны шугамаар хэрэгжиж буй төслийн хүрээнд бүтээж олон нийтэд хүргэхээр киноны зураг авалт хийх продакшнуудыг шалгаруулаад байна. | **100** |
| **110** | | **4.2.5** | Орон нутагт санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах | | Хорооны төлөөлөгчдөөр дамжуулан орон нутаг дахь зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих удирдамжийг салбар бүр боловсруулан ажилласан. 2014 онд 79 ажилтан 21 аймагт хяналт шалгалт хийх, сургалт зохион байгуулах ажлаар томилогдон ажиллажээ. Санхүүгийн зохицуулах хороо, Монголын даатгагчдын холбооноос зохион байгуулсан даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох сургалт, даатгалын салбарын хууль тогтоомжийн сурталчилгааны ажлыг Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт зохион байгуулсан. | **100** |
| **"Санхүүгийн салбарт итгэх олон нийтийн итгэлийг бий болгох, Харилцагч үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах стратегийн зорилтын хүрээнд:**<br>**Тав. Санхүүгийн салбарын хөрөнгө оруулагч, харилцагчдын эрх ашгийг хамгаалах талаар** | | | | | | |
| **111** | **5.1. Харилцагч үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр** | **5.1.1** | Зохицуулалтын хүрээний салбарын асуудлаар иргэд, байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичгийг хянан, шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авах | Санхүүгийн зах зээлд оролцогчид, иргэд, хөрөнгө оруулагчдын санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэн тэдгээрийн эрх ашгийг хамгаалах, эрх зүйн туслалцаа үзүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд хийсэн байна. | 2014 онд Хороо гадны байгууллага, иргэдээс 386 өргөдөл гомдол хүлээн авсан байна. Ирсэн өргөдлийг хянан шуурхай шийдвэрлэсний үр дүнд хугацаа хэтэрсэн буюу шийдвэрлэгдээгүй байгаа өргөдөл байхгүй байна. | **100** |
| **112** | | **5.1.2** | Захиргааны хэрэг болон иргэний хэрэг | | Тайлангийн хугацаанд Захиргааны хэргийн шүүхэд 2 удаа, Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл 1 удаа оролцож, нэхэмжлэл 1, хариуцагчийн тайлбар 2, | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа, арбитрын ажиллагаанд хөрөнгө оруулагч, харилцагчдын эрх ашгийг хамгаалж төлөөлж оролцох | | хүсэлт 5 удаа, холбогдох нотлох баримт 85 хуудас тус тус гаргасан. | **100** |
| **113** | | **5.1.3** | Хорооны архивын баримтаас байгууллага, иргэдийн хүсэлтээр лавлагаа, хуулбар олгох | Журмын дагуу лавлагаа, хуулбар, олгож, бүртгэлд бүртгэснээр | Архивын баримтаас гадны байгууллага иргэдэд болон ажилтнуудад 2255 хадгаламжийн нэгж олгож ашиглуулсан ба 102 хадгаламжийн нэгжээс лавлагаа олгож 191000 төгрөг байгууллагын дансанд төвлөрүүлэв. | **100** |
| **114** | | **5.1.4** | Хорооны холбогдох газар, нэгжийг Монголбанкны Зээлийн мэдээллийн санд хадгалагдаж буй зээлдэгчдийн талаарх мэдээллээр хангах | Тайлан гаргах | Хорооны холбогдох газар, нэгжийн 184 албан тоотоор ирүүлсэн хүсэлтийн дагуу 1446 мэдээллийг Монголбанкны Зээлийн мэдээллийн санд хадгалагдаж буй зээлдэгчдийн талаарх мэдээллээс шалган бүртгэгдсэн 951 аж ахуйн нэгж, иргэдийн мэдээллийг 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар холбогдох газруудад хүргүүлсэн. | **100** |
| **115** | | **5.1.5** | Хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргагчдад нэгдсэн зөвлөгөө, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах | Мэдээлэл хүссэн зах зээлд оролцогч этгээдүүдэд мэдээлэл хүрсэн байх | Эрх нь зөрчигдсөн хувьцаа эзэмшигчид болон зах зээлийн талаарх ойлголт, мэдээлэл шаардлагатай иргэдэд тухай бүр заавар, зөвлөгөө өгөн ажилласан. Мөн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгжид холбогдох хууль, журмыг таниулан сурталчлан зөвлөгөө өгч ажиллаа. Хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлийн талаар мэдээлэл хүргэх, сурталчлан таниулах зорилгоор 2 удаа, хуульд заасан үүргээ хэрэгжүүлэх болон компанийн засаглалын кодексыг шинэчлэн батлагдсантай холбоотой сургалтыг орон нутгийн болон Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг 110 хувьцаат компанийн удирдах ажилтнуудад зориулан зохион байгуулсан. Зарим нэр бүхий ХК-ийн жижиг хувьцаа эзэмшигчийн зөрчигдсөн эрхийг хамгаалах чиглэлээр хууль тогтоомжоор олгогсон бүрэн эрхийн хүрээнд ажиллаж байна. | **100** |
| **116** | | **5.1.6** | Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон хөрөнгө оруулалтын санд төвлөрүүлсэн ХОЭБ-ийн баталгаажилт, бүртгэлийг цэгцлэх чиглэлээр судалгаа хийж арга хэмжээ | Судалгаа хийж, холбогдох арга хэмжээний саналыг Хороо, газрын удирдлагад танилцуулсан байх | Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон хөрөнгө оруулалтын санд төвлөрүүлсэн ХОЭБ-ийн баталгаажилт, бүртгэлийг цэгцлэх чиглэлээр судалгаа хийлээ. | **80** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | авах | | | |
| 117 | | 5.1.7 | Хорооны 2008 оны 77 дугаар тогтоолоор арилжааг нь зогсоосон компанид өгсөн үүргийн хэрэгжилтийг хангаагүй компанийг эрх бүхий байгууллагад шалгуулахаар шилжүүлэх, татан буулгахаар шүүхэд нэхэмжлэл гаргах | Хуулийн байгууллагад шилжүүлэх санал боловсруулж хүргүүлсэн байх | Нийт 45 ХК-ийг хуулийн байгууллагад шилжүүлэхэ эр бэлтгэл ажлыг хийж байна. "Разноимпекс", "Монел", "Дарзам" зэрэг компаниудыг хуулийн байгууллагад шилжүүлэхээр болов. | 70 |
| 118 | | 5.1.8 | Хувьцаат компаниудын ногдол ашиг тараах ажиллагаанд хяналт тавих, нийтэд мэдээлэх ажиллагааг эрчимжүүлэх, шаардлагатай бол холбогдох журамд өөрчлөлт оруулах | Хорооны удирдлагад танилцуулсан байх ба Хорооны цахим хуудсанд байршуулсан байх | 2014 оны жилийн эцсийн байдлаар 29 ХК ноогдол ашиг тараахаар мэдэгдэл ирүүлсэн бөгөөд ногдол ашгийн мөнгөн хөрөнгийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан тараалгахад хяналт тавьж ажиллалаа. Ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн компаниудын талаарх мэдээллийг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлсэн. | 100 |
| 119 | | 5.1.9 | Санхүү, төлбөрийн чадваргүй болсон зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, хадгаламж эзэмшигч, харилцагчдыг хохиролгүй болгох арга хэмжээ авч ажиллах | Хадгаламж эзэмшигч, харилцагчдыг хохиролгүй болгох үе шаттай арга хэмжээ авч ажилласан байх | 2006 оноос хойш Хорооноос тусгай зөвшөөрөл аваагүй боловч өмнө нь Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байсан "Төв азийн хөрөнгө оруулалт" хоршооны хадгаламж, эзэмшигч нарын өргөдөл гомдлыг шийдвэрлэх, мөн Хорооноос тусгай зөвшөөрөл аваагүй боловч Цагдаагийн байгууллагад шалгагдаж байгаа "Зиндаа инвест", "Эрдэнийн эргэлт" хоршоодын барагдуулалтад анхаарч хяналт тавих, цагдаагийн байгууллагатай хамтарч ажиллаж байна. | 100 |
| **"Монгол улсын санхүүгийн салбарын тогтовортой байлыг хангах ,тогтвортой хөгжлийг бэхжүүлэх Хорооны стратегийн зорилтын хүрээнд: Зургаа. Олон улсын байгууллага, Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах талаар** | | | | | | |
| 120 | **6.1. Олон улсын сургалт семинар зохион байгуулах, хамтын** | 6.1.1 | "Бичил даатгалын зах зээлийн чадавхийг бэхжүүлэх төсөл"-ийн дэмжлэгтэйгээр "Монголын | Олон улсын бага хурлыг зохион байгуулж, холбогдох байгууллагуудыг оролцуулсан байна | "Хүртээмжтэй даатгал Улаанбаатар 2014" Олон улсын чуулга уулзалтыг 2014 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **ажиллагааны "Санамж бичиг байгуулах" хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд** | | даатгалын зах зээлийн экспо-2014” олон улсын бага хурал зохион байгуулах | | | |
| **121** | | **6.1.2** | Монгол Улсын санхүүгийн салбарын болон Хорооны чадавхийг бэхжүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулж, санхүүжилт олох, хэрэгжүүлэх /WB, ADB, USAID, GIZ, EBRD ба бусад байгууллагууд/ чиглэлээр ажиллах | \Монгол улсын Санхүүгийн салбар болон Хорооны чадавхийг бэхжүүлэх чиглэлээр төслийн үзэл баримтлалыг боловсруулах бэлтгэл ажлыг хангаснаар | Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр Японы ядуурлыг бууруулах сангийн санхүүжилтээр $2’912’000-н нийт төсөвтэй Эмзэг бүлгийн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх JFPR MON/9152 төсөл нь 2012 оны 1-р сарын 17-ны өдрөөс эхлэн 2015 оны 1-р сарын 17-ны өдрийг хүртэлх 3 жилийн хугацаатайгаар, Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн чадавхийг бэхжүүлэх тухай Дэлхийн банкны USD 350’000-н санхүүжилттэй төсөл нь тус Хороо болон Монголын Хөрөнгийн Бирж дээр 2013 оны 10 дугаар сараас эхлэн, Германы GIZ байгууллагаас хэрэгжүүлж буй “Бичил даатгалын төсөл”тус тус хэрэгжиж байгаа бөгөөд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Мянганы хөгжлийн ядуурлыг бууруулах гол зорилтын хүрээнд ядуу, орлого багатай иргэдэд чиглэсэн “Бичил даатгалын зах зээлийн чадавхийг бэхжүүлэх” төслийг 2014 оны 5-р сарын 31-ний өдрийг хүртэл хэрэгжсэн. | **100** |
| **122** | | **6.1.3** | IOSCO- Үнэт цаасны хороодын Олон Улсын Байгууллагтай хамтран ажиллах, санамж бичиг байгуулах талаар идэвхи саначилгатай ажиллах | Үнэт цаасны олон улсын байгууллагаас тавьж буй шаардлагын талаар бэлтгэл ажлыг зохион байгуулснаар | Үнэт цаасны зах зээлийн тухай хууль шинэчлэн батлагдсанаар Хороо нь IOSCO-ийн “Олон талт хамтын ажиллагаа” -нд нэгдэн орж IOSCO-ийн гишүүн орон боллоо. Хороо нь уг баримт бичигт нэгдэн орсноор IOSCO-ийн нийт 198 гишүүн орнуудын Үнэт цаасны зах зээлийн зохицуулах байгууллагаас мэдээлэл авах, солилцох, хяналт шалгалтын чиглэлээр хамтарч ажиллахаас гадна уг байгууллагын зах зээлийн нөлөө бүхий хяналт, зохицуулалтын орчинг сайжруулах чиглэлээр тусламж дэмжлэг авах өргөн боломж нээгдэж байгаа юм. | **100** |
| **123** | | **6.1.4** | Олон Улсын Холбооны Даатгалын хянан шалгагчдын байгууллага /IAIS/ -тай хамтран ажиллах, санамж бичиг байгуулах талаар идэвхи санаачилгатай ажиллах | Даатгалын хянан шалгагчдын Олон Улсын Холбооны байгууллагаас тавьж буй шаардлагын талаар бэлтгэл ажлыг зохион байгуулснаар | Даатгалын хянан шалгагчдын олон улсын байгууллага /International Association of Insurance Supervisors /IAIS//-ын Олон талт харилцан ойлголцлын санамж бичигт нэгдэн орох талаар тэдний зүгээс тавьж буй шаардлага, асуулгуудын хариуг тухай бүр нь хүргүүлж, бэлтгэл ажлыг ханган ажиллав. Тус байгууллагаас жил бүр уламжлан болгон зохион байгуулдаг “21 дэх удаагийн ээлжит чуулга уулзалт”-д оролцуулах бэлтгэл ажлыг ханган Хорооны гишүүн, дэд дарга нарыг оролцуулав. | **85** |
| **124** | | **6.1.5** | Японы Санхүүгийн үйлчилгээний байгууллагатай /FSA/ -тай санамж бичиг байгуулах талаар идэвхи | Японы санхүүгийн үйлчилгээний байгууллагатай /FSA/ хоёр талт санамж бичиг байгуулах бэлтгэл ажлыг хангаснаар | Япон Улсын Санхүүгийн Үйлчилгээний Байгууллагатай Мэдээлэл солилцох, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх тухай Харилцан ойлголцлын санамж бичгийг 2014 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр байгуулж, хоёр байгууллагын дээд удирдлагуудын хамтарсан уулзалтыг 2014 оны 5 дугаар сарын 26-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулж ажилласан. Япон Улсын Санхүүгийн үйлчилгээний байгууллагын дэмжлэгтэйгээр Японы олон улсын хамтын | **100** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | санаачилгатай ажиллах | | ажиллагааны байгууллагын /JICA/ санхүүжилтээр $2’000’000 -н нийт төсөвтэй Үнэт цаасны зах зээлийн чадавхийг бэхжүүлэх төсөл нь 2014 оноос 2017 он хүртэлх 3 жилийн хугацаатайгаар хэрэгжүүлэхээр болов. | |
| **125** | | **6.1.6** | Гадаад улсын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн байгууллагуудтай байгуулсан “Санамж бичиг”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Олон улсын мэргэжлийн холбоодоос гаргасан стандарт, дүрэм,журмыг Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн практикт нэвтрүүлэх, гадаадын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын тэргүүн туршлагыг нэвтрүүлсэн байна. | Монгол Улсад уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй гадаадын 13 компани Лондон, Нью-Йорк,Торонто, Хонконг, Австралийн хөрөнгийн Биржүүд дээр бүртгэлтэй байна. Эдгээр улсуудын зохицуулалтын байгууллагатай харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулснаар тухай улсуудын хөрөнгийн зах зээлийн туршлагаас судлах, харилцан мэдээлэл солилцох зэрэг чиглэлээр хамтран ажиллах боломж нээгдэх юм. Иймд Их Британи, АНУ, Канад, Австрали, ХБНГУ-ын зохицуулах байгууллагуудтай хоёр талт хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах талаар судалгааг хийсэн. | **100** |
| **126** | | **6.1.7** | Гадаад улсын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн байгууллагуудтай “Санамж бичиг” байгуулах талаар идэвхи санаачилгатай ажиллах | | БНХАУ-ын Үнэт цаасны хороотой байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах талаар харилцан ойлголцолд хүрч, хамтран ажиллахаар болов. Лаосын Төв Банкны төлөөлөгчид Бичил санхүүгийн салбарын зохицуулалтын хүрээнд туршлага судлах уулзалтыг хийлээ. | **100** |
| **127** | | **6.1.8** | Хорооны зохицуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын мэргэжлийн холбоодод нэгдэн орох ажлыг зохион байгуулах | | Санхүүгийн зохицуулах хороо нь IOSCO-ийн гишүүнээр элссэн. Үүний үр дүнд IOSCO-ийн гишүүн 198 орнуудын Үнэт цаасны зах зээлийн зохицуулах байгууллагаас мэдээлэл авах, солилцох, хяналт шалгалтын чиглэлээр хамтарч ажиллахаас гадна уг байгууллагын зах зээлийн өмнөө бүхий хяналт, зохицуулалтын орчинг сайжруулах чиглэлээр туслаж, дэмжлэг авах зэрэг өргөн боломж нээгдэж байгаа юм. | **100** |
| **128** | **6.2. Гадаадын хандивлагч, хөрөнгө оруулагч нарын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх төслийн чиглэлээр** | **6.2.1** | Санхүүгийн хамтын ажиллагааны нийгэмлэг /AFI/ -тай хамтран ажиллах, Бичил санхүүгийн чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр ажиллах | Төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаснаар | “Малчдын өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор малчдыг Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаанд үүсмэл санхүүгийн хэрэгслийг ашиглан шууд оролцуулах боломжийг бий болгох нь” 50’000 еврогийн санхүүжилт бүхий төслийг боловсруулж Санхүүгийн хамтын ажиллагааны нийгэмлэг /СХАН/-т хүргүүлсэн. Хүсэлтийг СХАН нь хүлээн авснаар Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаа өндөр түвшинд хөгжсөн орнуудын туршлагаас судлах тухай төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. Санхүүгийн хамтын ажиллагааны нийгэмлэг /СХАН/-ээс жил бүр уламжлан болгон зохион байгуулдаг “Дэлхийн Бодлогын Хурал-2014” чуулга уулзалтад 3 хүн оролцов. Дээрх чуулга уулзалтын үеэр СХАН нь цаашид биеэ даасан байгууллага болохтой холбоотойгоор байгууллагын дүрэм, гишүүнчлэлийн төлбөрийн асуудлыг хэлэлцэж, гишүүн орны төлөөлөгч нартай санал солилцсон юм. Тус Хороо нь СХАН-ийн гишүүн байгууллагаар 2009 онд элсэн орсон бөгөөд тус байгууллагын дэмжлэгтэйгээр мэдлэг солилцох буцалтгүй тусламжийн хүрээнд | **100** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | цахим мөнгөн гүйлгээ болон гар утсаар төлбөр тооцоо авах чиглэлээр гишүүн орнуудын туршлагаас судлаж байсан. Маягийн тунхаглалын биелэлтийг боловсруулж СХАН-т хүргүүлэв. 2019 оноос СХАН нь гишүүн орнуудын санхүүжилтээр биеэ даасан олон улсын байгууллага болох зорилтын хүрээнд тус Хороо нь цаашид гишүүн байгууллага хэвээр үлдэх шаардлагатай эсэх асуудлыг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн тус Хороо нь цаашид СХАН-ийн гишүүн байгууллага хэвээр байх шийдвэрийг гаргасан юм. | |
| **129** | | **6.2.2** | Люксембургийн Хөгжлийн Агентлагаас санхүүжүүлэх СЗХ-ны чадавхийг бэхжүүлэх, Сургалтын төв байгуулах төслийн хэрэгжилтийг хангах | Төслийн хэрэгжилтийн өдөр тутмын үйл ажиллагааг дэмжин ажилласнаар | Монгол Улсын Засгийн Газар, Люксембургийн Их Гүнт улсын Засгийн Газар хооронд байгуулсан 2008 оны 10-р сарын 28-ны өдрийн Харилцан ойлголцлын санамж бичиг, 2010 оны 7-р сарын 9-ний өдрийн Протоколын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны дэргэд €200’000-н нийт төсөвтэй Санхүүгийн салбарын чадавхийг бэхжүүлэх, сургалтын төв байгуулах төсөл /МОН -004/ нь 2011 оны 1-р сарын 10-ны өдрөөс эхлэн 4 жилийн хугацаатайгаар хэрэгжиж байна. МОН/004 төслийн санхүүжилтээр 8 сургалт, семинар, зөвлөгөөн 19 удаагийн гадаад арга хэмжээ, томилолтын зардлын дэмжлэгийг авлаа. Мөн энэ хугацаанд Кастодиан үйлчилгээний зохицуулалт, санхүүгийн загварчилал, хөрөнгө оруулалтын сан, даатгалын андеррайтер, стратегийн төлөвлөгөө, эрсдлийн удирдлага, бичил санхүүгийн эрсдлийн удирдлага, стратегийн гүйцэтгэл зэрэг чиглэлүүдээр Люксембургийн Санхүүгийн технологи дамжуулах агентлагийн 6 экспертийг давхардсан тоогоор 6 удаа урьж ажиллуулав. МОН/004 төслийн үндсэн хугацаа нь 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөр дуусгавар болж буйтай холбогдуулан 2015 онд төслийн үйл ажиллагааг үргэлжлүүлэхэд шаардлагатай бодлогын баримт бичгийг боловсруулан ажиллав. | **100** |
| **130** | | **6.2.3** | Япон Улсын Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг /JICA / -ийн дэмжлэгтэйгээр Үнэт цаасны газрын чадавхийг сайжруулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх | Төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаснаар | “Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн дүрэм, журам болон тус салбарын чадавхийг сайжруулах” төслийн баримт бичигт тусгах саналыг боловсруулж, холбогдох уулзалтуудыг зохион байгуулсны үр дүнд 2014 оны 5 дугаар сарын 23-нд төслийн баримт бичигт Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурлаа. Төсөл хэрэгжсэнээр Монгол Улсын Үнэт цаас, хөрөнгийн зах зээлийн эрхзүйн орчин боловсронгуй болохын зэрэгцээ тус Хорооны Үнэт цаасны газрын ажилтнуудын чадавхийг сайжруулна. | **100** |
| **131** | **6.3. Төрийн болон ТББ-тай хамтран ажиллах чиглэлээр** | **6.3.1** | Зохицуулалтын байгууллагуудын мэргэжлийн холбоодтой хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг үйлчилгээний хүрээний байгууллагуудын зохицуулалт хяналтыг боловсронгуй болгох чиглэлээр хамтран ажиллаж үр дүнг | Хамтын ажиллагааны хүрээнд ББСБ -уудыг удирдлагын мэдээллийн системээр хангах чиглэлээр гүйцэтгэгч компани болон БСХС -тай хамтран ажиллах гэрээг байгуулаад байна. Мөн төрийн бус байгууллагуудын чиг үүргийг судлан БСХС-аас Хорооны төлөөлөгчдийн зардлыг санхүүжүүлж, СЗХ -3, МХЗХҮХ -2, МББСБХ-2, БСХС-2 нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид Япон улсын Санхүүгийн үйлчилгээний агентлагын урилгаар томоохон ХЗХ, ББСБ, тэдгээрийн мэргэжлийн холбоод, хяналтын зохицуулалт хийдэг төрийн байгууллагын үйл ажиллагаатай танилцсан. МХЗХҮХ -той хамтран ажиллах санамж бичгийг шинэчлэн 2014 оны 4 дүгээр сарын 24 -ний өдөр гарын үсэг зурсан ба санамж бичгийг хугацаагүйгээр байгуулан нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд тухай бүр оруулж байхаар тусгасан болно. МИД -ын төсөл, | **100** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | тооцсон байна. | Монголын даатгагчдын холбоо, Монголын актуарчдын нийгэмлэг, Албан журмын даатгагчдын холбоодтой байгуулсан санамж бичгээ хүрээнд хамтарч ажиллаж байна. Хөдөө аж ахуйн Биржийн зохицуулах зөвлөлийн ажлын алба, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд бэлтгэн нийлүүлэгч мэргэшсэн брокеруудын нэгдсэн холбоо хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг"-ийг 2014 оны 5 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан. Мөн Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоотой харилцан ойлголцлын санамж бичгийг 2014 оны 6 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан. | |
| **132** | | **6.3.2** | Шаардлагатай тохиолдолд зохицуулалтын салбарын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулах | | 2014 оны байдлаар Санхүүгийн зохицуулах хороо нь нийт 30 байгууллагатай санамж бичиг байгуулан ажиллаж байна.Үүнээс гадаад орны ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг 5 байгууллага, Монгол Улсын төрийн 8 байгууллага, 14 мэргэжлийн холбоод, ТББ, 2 банк, 1 хэвлэл мэдээллийн байгууллагатай санамж бичгийн хүрээнд хамтран ажиллаж байна. Мөн тайлант хугацаанд МББСБХ, МХЗХҮХ-той 2010 онд байгуулсан санамж бичгийг шинэчлэн байгуулсан. Түүнчлэн МҮЦАЭХ, АЖДХ, ХААГБТЭБН-ийн нэгдсэн холбоо болон Биржийн зохицуулах зөвлөл, Монголын даатгагчдын холбоо, Хүүхдийн төлөө үндэсний газар, “Эрдэм мэдлэг түгээх төв” ТББ, Жайка олон улсын байгууллагуудтай шинээр санамж бичиг байгуулсан ба эдгээр санамж бичгүүдийн бүртгэл хөтлөх, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг хийж гүйцэтгэсэн. | **100** |
| **133** | **6.4. Гадаад харилцааны чиглэлээр дотооддоо хийх ажлууд** | **6.4.1** | Хорооны үйл ажиллагааны тайланг англи хэл дээр орчуулах | Тайланг вэб сайтад байршуулснаар | Хорооны 2013 оны үйл ажиллагааны тайланг орчуулсан болно. | **100** |
| **134** | | **6.4.2** | Хорооны ажилтнуудын гадаад сургалт, олон улсын хурал, семинартай холбогдох бэлтгэл ажлыг хангах | Хорооны удирдлагуудыг холбогдох сургалт, семинарт оролцох бэлтгэл ажлыг хангаж, оролцуулсанаар | Олон улсын болон өөс нутгийн түвшинд санхүүгийн зах зээлийн оролцогчдод зориулсан семинар, зөвлөгөөнд 65 гадаад томилолт, арга хэмжээнд тус хорооны давхардсан тоогоор 101 ажилтан оролцууллаа. | **100** |
| **135** | | **6.4.3** | СЗХ-ны хуралдаанаас гарсан шийдвэр, тогтоол, холбогдох бичиг баримтыг шаардлагатай тохиолдолд орчуулах, Хорооны англи цахим хуудасны мэдээллийг байнга шинэчлэх | Цахим хуудсыг тухай бүрт нь байнга шинэчлэн, хөтлөн ажилласанаар | Тус Хорооны Удирдах гишүүдийн 14 удаагийн хуралдаанаас гарсан шийдвэр, тогтоол, холбогдох шаардлагатай бичиг баримтыг орчуулж, цахим хуудсыг тухай бүр шинэчлэн ажиллав.<br>2014 оны Үйл ажиллагааны төлөвлөгөөг Англи хэлнээ хөрвүүлэв. Мөн Монголиан Экономи сэтгүүлийн тус Хорооны 20 жилийн ойн хүрээнд хэвлэгдсэн 2014 оны 11 дүгээр сарын №19 /077/ дугаарт нийтлэгдсэн даргын мэндчилгээ, танилцуулга, гадаад хамтын ажиллагаа зэрэг нийтлэлүүдийг боловсруулан, Англи хэлнээ хөрвүүлэн сэтгүүлийн редакцид хүргүүлэв. | **100** |
| **Туслах үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээнд хийж гүйцэтгэх ажлууд<br>Долоо. Төрийн албаны стандартыг хангах удирдлага зохион байгуулалтын талаар** | | | | | | |
| **136** | **7.1.** | **7.1.1** | Санхүүгийн | | Хорооны 2013 оны үйл ажиллагааны тайланг нэгтгэн гаргаж эмхтгэл болгон | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **Ажлын албаны ажлын төлөвлөлт, үр дүнг тайлагнах чиглэлээр** | | зохицуулах хорооны 2013 оны үйл ажиллагааны тайлан нэгтгэж, эмхтгэн УИХ-д хүргүүлэх | Тогтоосон хугацаанд УИХ болон холбогдох газруудад хүргүүлснээр | УИХ-д хүргүүллээ. Мөн Засгийн газар, Монголбанк, Сангийн Яам, Мэргэжлийн Холбоодод тус тус илгээлээ. | **100** |
| **137** | | **7.1.2** | Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах | | Хорооны болон газруудын 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг газар тус бүрээр 1 -2 удаа хэлэлцүүлэн санал авч "Хорооны 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд 204 ажил тусган Хорооны даргын 2014 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 15 дугаар тушаалаар батлуулав. | **100** |
| **138** | | **7.1.3** | Хорооны газруудын жилийн ажлын төлөвлөгөөг баталж хэрэгжилтэд хяналт тавих | Төлөвлөсөн ажлууд хэрэгжсэнээр | Газруудын ажлын төлөвлөгөөг 2014 оны 01 дүгээр сарын 17 -ны өдрийн Ажлын албаны даргын 17 дугаар тушаалаар тус тус батлуулсан. | **100** |
| **139** | | **7.1.4** | Төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн шууд захирагчтай, Төсвийн шууд захирагч Нэгжийн менежерүүдтэй, Нэгжийн менежерүүд газрын ажилтнуудтайгаа үр дүнгийн гэрээ байгуулах | Гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулснаар | 2014 оны Төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн шууд захирагчтай, Төсвийн шууд захирагч Нэгжийн Менежерүүдтэй, Менежерүүд газрын ажилтнуудтайгаа байгуулсан үр дүнгийн гэрээний хувийг хүлээн авах, нэгтгэх ажлыг зохион байгуулж ажилласан. Төрийн захиргааны 106 ажилтан ажилтан үр дүнгийн гэрээ байгуулахаас 100 хувь байгуулсан байна. | **100** |
| **140** | | **7.1.5** | Үр дүнгийн гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулах, дүнг нэгтгэх | Гэрээний дүнг нэгтгэн удирдлагад танилцуулснаар | 2014 онд 106 албан хаагч үр дүнгийн гэрээ байгуулан ажилласан байна. Төрийн албан хаагчийн 2014 оны "Үр дүнгийн гэрээ"-ний биелэлтээр 93 ажилтан дүгнэгдэж үүнээс А үнэлгээтэй 68, В үнэлгээтэй 28, ажилтан үнэлэгджээ. 13 албан хаагч хүндэтгэх шалтгааны улмаас дүгнэгдээгүй байна. | **100** |
| **141** | | **7.1.6** | Хорооны 2014 оны жилийн ажлын төлөвлөгөө, Стратеги төлөвлөгөөний биелэлт гаргаж, ажлын тайланг нэгтгэх | Тогтоосон хугацаанд нь нэгтгэн, Хорооны удирдлагад танилцуулснаар | "Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги/2012-2016/" болон салбаруудын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн 2 дахь удаагийн ээлжит хэлэлцүүлгийг 2014 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулж нийт 178 хүн оролцуулав. Хэлэлцүүлгээр Үнэт цаас, Даатгал, Бичил санхүүгийн салбарын 2012-2016 оны стратегийн хэрэгжилт, хүрсэн түвшин, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай салбар бүрийг хариуцсан дарга нар илтгэл тавьлаа. Энэ удаагийн хэлэлцүүлгийн гол онцлог нь дээрх баримт бичгийг боловсруулахад техникийн дэмжлэгийг үзүүлсэн Люксембургийн Засгийн Газраас Санхүүгийн зохицуулах хороонд хэрэгжүүлж буй "Санхүүгийн чадавхийг бэхжүүлэх, сургалт"-ын төслийн Олон улсын зөвлөх, Люксембургийн Вант Улсын Хүний Нөөцийн нийгэмлэгийн хүндэт гишүүн Оливие Нобло оролцож стратегийн гүйцэтгэлийн шалгуурыг тогтоох, хянах үйл ажиллагааны тухай "Гүйцэтгэлээ мэдэж, мэдэрье" сэдвээр илтгэл тавив. "Санхүүгийн зохицуулах хорооны үйл | **100** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажиллагааны стратеги/2012-2016/" болон салбаруудын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг ном болгон хэвлүүлэхээс гадна Хорооны болон газруудын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн цаг хугацааны хуваарийг нэгтгэн гаргаж газруудын ажлын хэрэгцээнд олгосон. | |
| 142 | | 7.1.7 | Хорооны орон нутгийн төлөөлөгчдийн хийж гүйцэтгэсэн ажлын тайланг нэгтгэн хорооны удирдлагад танилцуулах | Орон нутаг дахь төлөөлөгчдийн ажлын бүтээмжийг дээшлүүлж, мэргэжил арга зүйгээр хангасан байна. | Хорооны орон нутаг дахь төлөөлөгчдийн ээлжит семинарыг 2014 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан ба семинарт Хорооны удирдлагууд, Газар, хэлтсийн дарга нар болон 21 аймаг, нийслэл, дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, үйлчлэгтгэлийн мэргэжилтнүүдийн хамт нийт 51 ажилтан буюу 80.9% нь оролцсон. Семинараар Хорооны орон нутаг дахь төлөөлөгчдийн 2013 оны жилийн ажлын тайлан, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон тэдгээрийг дагалдан гарсан дүрэм журмууд, санхүүгийн салбарын өнөөгийн байдал, цаашид анхаарч ажиллах зарим асуудлаар Үнэт цаасны газар, Даатгалын газар, Бичил санхүүгийн газруудаас орон нутаг дахь зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаанд санхүүгийн салбарын хууль тогтоомжуудыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, орон нутагт сурталчлах, иргэдийг мэдээллээр хангах талаар чиглэл өглөө. | 100 |
| 143 | | 7.1.8 | "Санхүүгийн зохицуулах хорооны авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх төлөвлөгөө"-г батлуулж, мөрдөж ажиллах | Төлөвлөгөө батлагдаж, ажлууд бүрэн хийгдсэн байх | "Санхүүгийн зохицуулах хорооны авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөө"-г Хорооны даргаар батлуулж, Авлигатай тэмцэх газарт 1/749 тоот албан бичгээр хүргүүлсэн. Төлөвлөгөөг нийт 30 заалт бүхий ажлаар гарган, 02 дугаар сарын 01-ны өдрөөс 11 дүгээр сарын 01-г хүртэл хэрэгжүүлнэ. Төлөвлөгөөг биелүүлэх ажлын хэсэг нийт 14 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдан, ажлын хэсгийн эхний уулзалтыг 04 дүгээр сарын 15 -ны өдөр зохион байгуулсан. Уулзалтын хүрээнд төлөвлөгөөний дагуу жилд 2 удаа тайлан авч нэгтгэн Авлигатай Тэмцэх газарт хүргүүлэхээр болсон. | 100 |
| 144 | **7.2. Хорооны хуралдааны шийдвэрийг баримтжуулж, мэдээллийг олон нийтэд хүргэх чиглэлээр** | 7.2.1 | СЗХ-ны ээлжит болон ээлжит бус хуралдааны зохион байгуулалтыг хангаж хуралдаанаас гарсан тогтоол, шийдвэр, хуралдааны тэмдэглэлийг баримтжуулж, хадгалах, биелэлтэд хяналт тавих, Хорооны вэб хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх | Санхүүгийн зохицуулах хороо хуулиар хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэх , олон нийтийг мэдээллээр хангах нөхцөл бүрдсэн байна. | Тайлант хугацаанд Хорооны хуралдаан 21 удаа хуралдан 524 асуудал хэлэлцсэнээс 467 тогтоол, 6 тэмдэглэл гарч нийт 473 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна. Хуралдаанаар 13 асуудал танилцуулагдан 44 асуудал хойшлогдсон байна. Шийдвэрлэсэн асуудлыг газраар ангилавал: Тамгын газар 18, Үнэт цаасны газар 155, Даатгалын газар 51, Бичил санхүүгийн газар 231, Эрсдэлийн үнэлгээ судалгаа, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний газар 17, Компанийн засаглалын төлөвлөгөөг хэрэгжүүлэх алба 1 асуудал тус тус шийдвэрлүүлэн шийдвэр гаргуулжээ. | 100 |
| 145 | | 7.2.2 | Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн | | УИХ-ын 2013 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 77 дугаар тогтоолоор Хяналтын зөвлөлийн 5 гишүүдийг шинээр томилсон. Хяналтын зөвлөлийн хуралдааныг хоёр удаа зарлан хуралдуулж, Хяналтын зөвлөлийн 2014 оны | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хуралдааны зохион байгуулалтыг ханган хуралдаанаас гарсан тогтоол, шийдвэр, хуралдааны тэмдэглэлийг баримтжуулж, хадгалах, биелэлтэд хяналт тавих, Хорооны вэб хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх | | “Ажлын төлөвлөгөө” -ний талаар өмнө "Анод" банкны хувь цаа эзэмшигч Т.Жигмиддагвын гаргасан өргөдлийг хэлэлцэж хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргасан. Албан журмын даатгагчдын холбоо, Монголын даатгалын холбоо, Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Бичил санхүү, Даатгалын газрын ажилтнуудтай ажил хэргийн уулзалтыг тус тус зохион байгуулав. Хяналтын зөвлөлд 6 гомдол, 11 бичиг ирж , 21 бичиг явуулсан байна. | **100** |
| **146** | **7.3. Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган биелэлтийг тайлагнах чиглэлээр** | **7.3.1** | Монгол Улсын “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдийн биелэлтийг гаргаж холбогдох газруудад хүргүүлэх | Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан бодлогын баримт бичгүүдэд Хорооны хариуцсан салбарын чиглэлээр тусгагдсан зорилтууд, Хорооны үйл ажиллагаанд шууд хамаарах болон нийтээр дагаж мөрдөхөөр гаргасан хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийн хэрэгжилт хангагдана. Хорооны удирдлага, гишүүдийг мэдээллээр хангасан байна. | 2014 онд шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон Монгол Улсын хууль 134, Улсын Их Хурлын 72 тогтоол, Засгийн газрын тогтоол 11 ирснийг Хорооны удирдлагуудад “Танилцуулах хуудас”-аар танилцууллаа. Хорооны үйл ажиллагаанд шууд хамааралтай УИХ-ын 5 тогтоол, Засгийн газрын 5 тогтоолд тус тус “Хяналтын карт” нээж биелэлтэд хяналт тавин ажиллалаа. Мянганы хөгжлийн цогц бодлого, Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2013 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл, 2013 онд Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн биелэлтийг 2014.02.06-ны 1/303 тоот албан бичгээр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2015 оны үндсэн чиглэлд өгөх санал, салбарын танилцуулгыг 2014.03.21-ний 1/1236 тоот албан бичгээр Эдийн Засгийн Хөгжлийн Яаманд тус тус хүргүүлэв. Үндэсний аудитын газраас тухайн баримт бичгүүдийн 2013 оны хэрэгжилтэд судалгаа хийн үнэлгээ хийхэд 73 хувьтай гарсан байна. | **100** |
| **147** | | **7.3.2** | Дээд газрын тогтоол шийдвэр, өргөдөл гомдол, хариутай бичгийн шийдвэрлэлтийг хуулийн хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэх | | Хорооны хэмжээнд 2014 онд хэрэгжилтийг нь ханган биелэлт гаргах Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Байнгын хороод, Засгийн газрын нийт 23 тогтоол, шийдвэрийн 106 заалтын биелэлтийг нэгтгэн гаргаж байна. УИХ-ын болон Засгийн газрын тогтоолын биелэлтийг, хэрэгжилт нь бүрэн хангагдсан тогтоол шийдвэрүүдийг хяналтаас хасуулах саналын хамт УИХ -ын Тамгын газар, Эдийн засгийн байнгын хороонд 2014.09.30-ны 1/4296, 1/4297 тоотуудаар тус тус хүргүүлэв. Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн мэдээг нэгтгэн УИХ-ын Тамгын газарт 4 удаа хүргүүлэв. Тайлант хугцаанд 386 өргөдөл хүсэлт хүлээн авч шийдвэрлэжээ. | **100** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **148** | | **7.3.3** | Бодлогын баримт бичгүүд, дээд газрын тогтоол, шийдвэр, албан даалгавар, тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаварын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг Хорооны хуралдаанд танилцуулах | | Хорооны 14 дүгээр хуралдаанаар дээд газрын тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгтгэн танилцуулав. | **100** |
| **149** | **7.4. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэлийн чиглэлээр** | **7.4.1** | Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэл хөтлөх, нэмэлт өөрчлөлт, баяжилтыг хийх, эрхийн гэрчилгээ, үнэмлэх олгох | Тусгай зөвшөөрлийн нэгдсэн бүртгэл журмын дагуу хөтлөгдөж, өөрчлөлтийн талаарх мэдээлэл тухай бүр орсон байна. | 2014 онд Үнэт цаас, Даатгал, Бичил санхүүгийн салбарт тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэхээр 261 хуулийн этгээд шинээр хүсэлт ирүүлснийг бүртгэж холбогдох газруудад шилжүүллээ. Тусгай зөвшөөрлийн асуудлаар Хорооны тогтоолоор 481, Хорооны даргын тушаалаар 1381 нийт 1862 шийдвэр гарсныг нэгдсэн бүртгэл хөтлөх журмын дагуу А1 маягт болон цахим бүртгэл, бүртгэлийн дэвтрүүдэд бүртгэв.<br>2014 онд шинээр тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олгосон 199 хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, салбар нэгжийн гэрчилгээ, 659 иргэнд эрхийн үнэмлэхийн бичилт хийж, баталгаажуулсан. Тусгай зөвшөөрөл сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болсон, салбар нэгжид өөрчлөлт оруулсан, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан зэрэг 792 бүртгэлийг гэрчилгээ, хавсралтанд тэмдэглэгээ хийж баталгаажуулсан. | **100** |
| **150** | | **7.4.2** | Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн бүртгэлийн программын бодлогын даалгавар боловсруулах, "Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн бүртгэлийн мэдээлийн нэгдсэн сан"-тай болох | Программын бодлогын даалгаварыг боловсруулж системийн загварчлал хийгдэснээр мэдээллийн сан бий болох эхлэл тавигдана. | 2014 онд Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэлийн мэдээллийн сан бий болгох ажлын хүрээнд "Програмын системийн даалгавар" боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг Ажлын албаны даргын тушаалаар байгуулагдан, програмын системийн даалгавар гүйцэтгэгч "Болорсофт" ХХК -тай хамтран "МОН-004" төслийн санхүүжилтээр боловсруулав. | **100** |
| **151** | **7.5. Хүний нөөцийн бодлого төлөвлөлтийн чиглэлээр** | **7.5.1** | Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайланг гаргаж Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж тогтоосон хугацаанд гаргаж хүргүүлснээр | Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний 2013 оны тайланг гаргаж Төрийн албаны зөвлөлд оны эхнэд хүргүүлсэн ба 2014 оны тайланг хүргүүлэхэд бэлтгэн программд оруулж байна. Дараа оны 1 дүгээр сарын 5-нд хүргүүлнэ. | **100** |
| **152** | | **7.5.2** | Хорооны нийт | Төрийн албан хаагчийн | Ажилтнуудын ажилласан жил, төрд алба хаасан хугацаа, улсын байцаагчийн эрх | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | ажилтнуудын хувийн хэрэгт баяжилт хийх, хүний нөөцийн холбогдолтой төрөлжсөн болон дэлгэрэнгүй судалгаануудыг гаргах, шинэчлэн хөтлөх | тоо бүртгэлийн чиглэлээр гардаг стандарт судалгаануудтай болсон байна. | олгосон, хүчингүй болгосон, түдгэлзүүлсэн, төрийн жинхэнэ албан хаагчийн зэрэг дэв авсан ажилтнууд, англи хэлний сургалтад хамрагдаж байгаа ажилтнууд, түр болон удаан хугацааны чөлөө олгосон болон хүүхэд асрах чөлөө авсан ажилтнууд, гадаадад суралцаж байгаа ажилтнууд, өөрсөөр ажиллах гэрээгээр ажиллаж байгаа ажилтаны зэрэг 10 гаруй төрлийн судалгаанд баяжилт хийж үйл ажиллагаандаа ашиглах болон удирдлагыг мэдээллээр хангаж ажиллалаа. | 100 |
| 153 | | 7.5.3 | Хүний нөөцийн асуудлаар орон тоо бүтэц, цалин хөлс тогтоох, ажилд томилох, чөлөөлөх, ээлжийн амралт, шагнал урамшил, чөлөө олгох, тусламж дэмжлэг үзүүлэх, сахилгын шийтгэл оногдуулах зэрэг захирамжлалын баримт бичгүүдийн төсөл боловсруулан удирдлагаар шийдвэр гаргуулах | Удирдлагын шийдвэр гарсанаар | Боловсон хүчний шилжилт, хөдөлгөөн болон хүний нөөцтэй холбоотой давхардсан тоогоор 1479 ажилтантай холбоотой цалин хөлс, нэмэгдэл урамшуулал тогтоох олгох, ээлжийн амралтын хуваарь батлах, чөлөө олгох, ажилд томилох, чөлөөлөх, сахилгын шийтгэл ноогдуулах, албан тушаалын ангилал, зэрэглэл дэвшүүлэх, төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргүүлэх, улсын байцаагчийн эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, шагнаж урамшуулах зэрэг 43 төрлийн 157 тушаал шийдвэр гарлаа. | 100 |
| 154 | | 7.5.4 | Төрийн албаны нөөцөөс ажилтан авах, Удирдах ажилтны дүгнэлт гаргуулах, сул орон тооны захиалга өгөх, /Төрийн албанд анх орох иргэний шалгалт зарлуулах/, Төрийн албаны тангараг өргөх ёслолын ажиллагааг зохион байгуулах | Журмын дагуу холбогдох газарт хандан шийдвэрлүүлснээр | Тайлант хугацаанд Хорооны Ажлын албаны удирдах албан тушаалын сул орон тоонд 5 ажилтныг нэр дэвшүүлж дүгнэлт гаргуулахаар, төрийн захиргааны албан тушаалын сул орон тоонд 15 ажилтныг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн сангаас авах хүсэлтийг, холбогдох баримтын хамт бүрдүүлэн Төрийн албаны зөвлөлд, нийтийн албанд нэр дэвшсэн иргэний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянуулахаар Авлигатай тэмцэх газарт, диплом хүчинтэй эсэх лавлагаа гаргуулахаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт, ял шийтгэлтэй эсэх лавлагаа гаргуулахаар Цагдаагийн ерөнхий газарт тус тус албан бичиг хүргүүлснээс 4 удирдах ажилтан, 11 гэрээт ажилтны холбогдох баримт бичиг нь бүрдсэн тул албан тушаалд томилох шийдвэрийн төслийг боловсруулан батлуулсан. "Төрийн захиргааны албан хаагчийн тангараг" өргүүлэх ёслолын ажиллагааг 4 удаа зохион байгуулж Төрийн албаны шалгалт өгч тэнцэн, туршилтын хугацаатай томилогдон ажиллаж байсан 15 ажилтныг тангараг өргүүлэв. | 100 |
| 155 | | 7.5.5 | Хорооны орон нутаг дахь төлөөлөгчдийг томилох, чөлөөлөхтэй | Хорооны даргын тушаал гаргаж, шинээр томилогдсон төлөөлөгчийн хувийн | Хорооны орон нутаг дахь төлөөлөгчөөр 2014 онд 13 төлөөлөгч шинээр томилогдож, 7 төлөөлөгч үүрэгт ажлаас чөлөөлөгдснийг шийдвэр гаргуулсан. Хорооны орон нутаг дахь төлөөлөгчдийн ажилласан жил, шагналын судалгааг гаргаж 12 төлөөлөгчийг Хорооны жуух бичгээр, 5-аас доошгүй жил ажилласан | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | холбоотой асуудлыг шийдвэрлүүлэх, хувийн хэрэг болон бусад too бүртгэлийн судалгаануудыг гаргаж хөтлөх | хэргийн бүрдлийг хангаснаар | 12 өглөөлөгчийг мөнгөн шагналаар шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулав. | |
| **156** | | **7.5.6** | Хувийн ашиг сонирхолын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хэрхэн бөглөх талаар Авлигатай тэмцэх газартай хамтран дотоод сургалт зохион байгуулах | Сургалт бүрэн зохион байгуулагдсан байна. | Хорооны 84 төрийн жинхэнэ албан хаагчдаар 2013 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгүүлэн нэгтгэж хуулийн хугацаанд нь Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. | **100** |
| **157** | | **7.5.7** | Хувийн ашиг сонирхолын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг Хорооны нийт төрийн жинхэнэ албан хаагчдаар бүртгүүлэн нэгтгэх ажлыг зохион байгуулах | Авилгатай тэмцэх газарт хуулийн хугацаанд хүргүүлснээр | “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхолын урьдчилсан мэдүүлэг” болон их хэмжээний хөрөнгийн өөрчлөлт орсон талаар 111 мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүллээ. | **100** |
| **158** | | **7.5.8** | Хорооны болон салбарын шагналуудаар шагнуулахаар зохицуулалтын байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх, Хорооны ажилтнуудыг төрийн дээд одон медаль, салбарын шагналд өргөн мэдүүлэх | Судалгааг журмын дагуу үнэн зөв гарган шийдвэрлүүлснээр | Эрхэлсэн ажилдаа он удаан жилүр бүтээлтэй ажи ллаж буй 10 ажилтныг төрийн дээд одон медалиар шагнуулахаар өргөн мэдүүлсэн ба Хорооны “Жуух бичиг” -ээр 4 ажилтныг, “Санхүү, банкны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр 3 ажилтныг, Ажлын албаны мөнгөн шагналаар 9 ажилтныг тус тус тодорхойлон шагнууллаа. Монгол улсад санхүүгийн хяналт зохицуулалтын байгууллага үүсч хөгжсөний 20 жилийн ойг тохиолдуулан 37 ажилтныг гадны байгууллагын шагналуудаар шагнуулахаар тодорхойлсноос 30 ажилтан шагнагдсан. Хорооны шагналаар шагнуулахаар зохицуулалтын байгууллагаас ирүүлсэн 277 хүний материалыг зохих журмын дагуу хянаж, судалгаа гарган удирдлагад танилцуулснаар Хорооны шагналаар нийт 207 хүнийг шагнагдсан. Төрийн дээд одон медалиар шагнуулахаар зохицуулалтын байгууллагаас хүргүүлсэн 2 2 иргэний материалыг зохих журмын дагуу бүрдлийг хангаж холбогдох байгууллагад хүргүүлж, шагналын програмд бүртгүүллээ. | **100** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 159 | | 7.5.9 | Хороонд шинээр ажилд орсон ажилтнуудад “Чиглүүлэх сургалт”, нийт ажилтнуудад сургалт,семинар, өдөрлөгийг тус тус тодорхой төлөвлөгөөний дагуу зохион байгуулах | Холбогдох хууль тогтоомжийг танилцуулж, сургалт зохион байгуулснаар болон ажилтнуудыг хөгжүүлж, чадавхжуулснаар | Хорооны нийт ажилтнуудад “Монгол хэлний зөв бичгийн дүрэм, найруулга зүй” сургалт, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалд анх шинээр орж ажиллаж буй болон юлсөөр ажиллах гэрээтэй 34 ажилтанд “Төрийн алба, түүний мөн чанар, төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр сургалт, Хорооны удирдах албан тушаалд ажиллаж буй 24 ажилтанд “Төрийн албаны шинэтгэлийн бодлого, зөрчлийн удирдлага”, ”Үр дүнгийн гэрээг үнэлэх нь” сэдэвт сургалт, мөн ахлах хянан шалгагчаас дээшхи 42 албан тушаалтанд “Байгууллагын менежментийн хандлага” “Манлайлал, багийн ажиллагаа” сэдвээр, “Төрийн албан хаагчийн ажлын байранд тавигдах шаардлага”, “Ажлын арга барил, баримтлах зарчим” сэдвээр 22 ахлах референт, ахлах хянан шалгагч нарт зохион байгуулав. | 100 |
| 160 | | 7.5.10 | Хорооны нэр дээр гадаад, дотоодын их, дээд сургуульд доктор, магистрт суралцах ажилтнуудтай гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах | Гэрээний төслийг баталгаажуулснаар | Хорооны нэр дээр гадаад, дотоодын их, дээд сургуульд , магистрт болон дунд хугацааны сургалтанд суралцах 3 ажилтантай гэрээ байгуулах ажлыг зохион байгуулав. | 100 |
| 161 | | 7.5.11 | “Олон улсын ахмадын өдөр”, “Сар шинийн баяр”, "Эх үрсийн баяр", "Санхүүчдийн баяр", тэмдэглэлт ой болон ажилтнуудын чөлөөт цагаа хамтран өнгөөрөх зорилгоор зохиогдож буй спорт урлаг, аялал зугаалгын арга хэмжээнүүдийн зохион байгуулалтыг хангах, хөрөнгийн эх үүсвэр, зардлыг гаргах. | Дотоод журмын хэрэгжилтийг хангана. | “Сар шинийн баяр”,”Олон улсын ахмадын баяр”-ыг тохиолдуулан Хорооноос тэтгэвэрт гарсан өндөр настнууд, мөн онд тэтгэвэрт гарч буй ажилтанд болон Хороонд олон жил тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж байгаа 50, 55 нас хүрсэн ажилтнуудад хүндэтгэл үзүүлэх ажиллагааг, Эх үрсийн баяраар 76 ажилтны 16 нас хүртлэх насны 136 хүүхдэд бэлэг гардуулах ажлыг тус тус зохион байгууллаа.<br>Амьдрал ахуйд нь гачигдал тохиолдсон 11 ажилтанд 1,1 сая төгрөгийн буцалтгүй тусламж, орон сууц худалдан авах, хашаа байшингаа сайжруулахад нь дэмжлэг үзүүлж 11 ажилтанд 200,0 сая, гэр хороололд амьдардаг 11 ажилтанд түлээ нүүрс авахад нь дэмжлэг үзүүлж 2,4 сая, өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрч ажлаас чөлөөлөгдөж буй 1 ажилтанд 36 сарын цалинтай тэнцэх нэг удаагийн мөнгөн тэтгэлэг, буцалтгүй тусламжийг тус тус олгууллаа. Мөн 24 ажилтныг “Амьдрах урлага” иога, бясалгалын курст 5 хоног хамруулсан ба энэ ажилд 800 гаруй мянган төгрөг зарцуулав. | 100 |
| 162 | **7.6. Архив албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр** | 7.6.1 | Нууцын зэрэглэлтэй бичиг, баримтыг бүртгэж, холбогдох ажилтанд шилжүүлэх | Төрийн нууц, байгууллагын нууц, хувь хүний хүний нууцын тухай хуулийн хэрэгжилт болон | Хороонд нууцын зэрэглэлтэй 39 албан бичиг ирснийг холбогдох хууль, журам, зааврын дагуу бүртгэж шилжүүлсэн. Үүнээс 2 албан бичгийн хариуг журмын дагуу явуулсан. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **163** | | **7.6.2** | Шинээр ажилд орсон ажилтнуудад нууцын тухай хууль тогтоомжийг танилцуулж, баталгаа гаргуулах | байгууллагын дотоод мэдээллийн хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж ажилласан байна. | Шинээр ажилд орсон 6 ажилтнуудад нууцын тухай хууль тогтоомжийг танилцуулж, баталгаа гаргуулав. | **100** |
| **164** | | **7.6.3** | Хорооны ирсэн, явуулсан албан бичиг, өргөдөл, гомдлыг бүртгэх, шийдвэрлэлтийн хугацаанд хяналт тавих, шийдвэрлэлтийн мэдээ гаргах | Төрийн албан хэрэг хөтлөлтийн заавар, баримт бичгийн стандартын дагуу албан хэрэг хөтлөгдөж Хорооны удирдлагыг шуурхай мэдээллээр хангасан байна. | 2014 онд Хорооны хэмжээнд 9866 бичиг хүлээн авч, 5633 бичиг явуулж, 386 өргөдөл хүлээн авсныг зааврын дагуу албан хэрэг хөтлөлтийн програмд бүртгэж, 1664 хариутай бичигт бүртгэл хяналтын карт хөтлөн, 1512 бичигт танилцуулах хуудас хөтөллөө.<br>Хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн албан бичиг давхардсан тоогоор 56, өргөдөл давхардсан тоогоор 11 байсныг 7 хоногт мэдээ гарган удирдлагад танилцуулсан. Нийт бичгийн эргэлт тоогоор 8440, хуудсаар 223589 хуудас байна. Хоногийн бичиг хэргийн эргэлт тоогоор 64,6 хуудсаар 908,9 байна. | **100** |
| **165** | | **7.6.4** | Хорооны дарга, Ажлын албаны даргын тушаал, Албан даалгаврын бүртгэл хөтөлж, дугаар олгох, Хорооны орон тооны гишүүдэд танилцуулах | | 2014 онд Хорооны даргаас 351 тушаал гарсныг тухайд нь дарга нарт танилцуулав. Улсын ерөнхий байцаагчийн 20 тушаал, Хорооны даргын Албан даалгавар 1 гарсан байна. | **100** |
| **166** | | **7.6.5** | Газар хэлтсүүдийн 2013 оны баримтыг байгууллагын архивт батлагдсан хуваарийн дагуу хүлээн авч, техник боловсруулалт хийх, бүртгэлд оруулах | Баримтыг бүрэн хүлээн авч бүртгэлд оруулан ББНШК-оор хэлэлцүүлэх | 2014 онд газар, хэлтсүүдийн 2013 онд хөтлөгдөж дууссан 1409 хавтаст хэрэг хүлээн авч архивын эрдэм шинжилгээ техник боловсруулалтын ажлыг хийлээ. Хорооны 2006-2012 оны архивын баримтын бүртгэлд үргэлжлүүлэн дугаарлах зарчмаар бүртгэл жагсаалтыг үйлдэж байгууллагын дэргэдэх ББНШК -ын хурлаар оруулан хэлэлцүүллээ. Нийт 8354 хадгаламжийн нэгж бүртгэгдсэн ба байнга хадгалах баримтын 1 бүртгэл, түр хадгалах баримтын 8 бүртгэл үйлдлээ. Устгах бичгийн жагсаалт гараагүй болно. | **100** |
| **167** | | **7.6.6** | Хорооны албан хэрэг хөтлөлтийн ажилд "Бүтээмж-2014" программыг суурилуулан ашиглаж эхлэх , нийт ажилтнуудад программын талаар сургалт зохион байгуулах | Цаас ашиглалтыг багасгах, мэдээллийн цахим системийг боловсруулж нэвтрүүлэх, үндэс суурь тавигдана. | Хорооны албан хэрэг хөтлөлтөд 2014 оноос эхлэн "Бүтээмж-2014" бичиг хэргийн програмыг ашиглаж эхэлсэн ба програм танилцуулах сургалтыг 1 удаа, програмын ашиглалтын талаар 1 удаа мэдээ гарган нийт ажилтнуудад танилцууллаа.<br>Програм дээр ажиллаж байх хугацаанд гарсан алдаа, өөрчлөлтүүдийг тухай бүр байгууллагын онцлогт тохируулан хийлээ. | **100** |
| **168** | | **7.6.7** | Архивын зориулалтын нягтаруулсан | Тавиур шүүгээг байршуулж, архивын баримтыг зааврын | Архивын хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор архивын сан хөмрөгийн өрөөнүүдэд иж бүрэн засвар хийж тохижуулав. Мөн архивын баримтын зориулалтын шүүгээ суурилуулахад МОН -004 өсөл 21,6 сая | **100** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | шүүгээг суурилуулах ажлыг зохион байгуулах | дагуу байршуулснаар | төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж архивын 2 сан хөмрөгт 32 ширхэг нягтруулсан шүүгээ суурилуулж баримтыг байрлууллаа. | |
| **169** | | **7.6.8** | Хорооны дарга, гишүүд, Ажлын албаны даргын уулзалтын хуваарийг гаргах, зохион байгуулах, Хорооны дарга, орон тооны гишүүд , Ажлын албаны даргад ирсэн албан бичиг, факс, мэдээлэл, өргөдөл, гомдлыг танилцуулж, Хорооны бичиг хэрэгт бүртгүүлэх | Удирдлагад танилцуулж, бичиг хэрэгт бүртгүүлснээр | Хорооны дарга, Дэд дарга нар, Ажлын албаны даргад Хорооны газар хэлтсүүд, ажилтнуудаас болон гадаад дотоодын иргэд, байгууллагаас нийт 2305 ирсэн албан бичиг, 152 факс, 49 урилгыг танилцуулан бичиг хэрэгт шилжүүллээ. Ажлын албаны даргаас газар хооронд 31 бичиг явуулсныг бүртгэж шилжүүллээ. Хорооны дарга, Дэд дарга нар, Ажлын албаны даргын ажил хэргийн 972 удаагийн уулзалтын хуваарийг гаргаж, зохицуулалт хийсэн. | **100** |
| **170** | | **7.6.9** | Хорооны дарга, Ажлын албаны даргын тушаал, Албан даалгаврын бүртгэл хөтөлж, дугаар олгох, Хорооны дэд дарга нарт танилцуулах | Тушаал шийдвэрт дугаар өгч, баримтжуулан дэд дарга нарт танилцуулснаар | 2014 онд Хорооны даргаас 351 тушаал гарсныг тухай бүр дэд дарга нарт танилцуулав. Улсын ерөнхий байцаагчийн 20 тушаал, Хорооны даргын Албан даалгавар 1 гарсан байна. | **100** |
| **171** | **7.7. Санхүүгийн төлөвлөлт, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр** | **7.7.1** | 2013 оны Хорооны төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлан тэнцэл, танилцуулга боловсруулж, шийдвэр гаргуулах | Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан байна. | Хорооны 2013 оны жилийн санхүүгийн тайлан тэнцлийг гарган Үндэсний аудитын газраар санхүүгийн тайлангийн аудит хийлгэн, "Зөрчилгүй" санал, дүгнэлт, зөвлөмжийг авч ажиллаа. | **100** |
| **172** | | **7.7.2** | Хорооны 2014 оны хагас, бүтэн жилийн 2014 оны төсвийн орлого, зарлагын сар, улирлын болон зардлын үйл з ангийн хуваарийг гаргаж Сангийн яаманд хүргүүлэх | | Хорооны 2014 оны зохицуулалтын үйлчилгээний орлого, батлагдсан төсвийн зардлыг зарцуулах сар, улирлын хуваарийг гаргаж, Сангийн Яаманд хүргүүлэн, батлагдсан төсвийн хуваарийг мөрдөн ажиллаж байна.Үндсэн үйл ажиллагааны орлогыг урьдчилан тооцсоноос 773.4 сая. төг буюу 2.9 дахин буюу 293.3 % - иар биелүүлж, улсын байцаагчийн эрхийн үйл ажиллагаагаар хэрэгжүүлснээр хүү торгуулийн орлогоор 81.5 сая.төг хуримтлуулсныг улсын төсвийн орлогод төвлөрүүлэн төсвийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллалаа. | **100** |
| **173** | | **7.7.3** | Хорооны 2014 оны хагас, бүтэн жилийн | | Хорооны 2013 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлан тэнцлийг гаргаж, Үндэсний Аудитын газар, Төрийн Өмчийн хороо, | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцлийг хуулийн хугацаанд гарган, холбогдох байгууллагуудад хүргүүлэх | | Төрийн сангийн газар, Сангийн Яаманд тус тус хүргүүлсэн ба төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлан тэнцлийг Үндэсний Аудитын газарт өргөн барьж, санхүүгийн тайлангийн гүйцэтгэлийн аудит хийлгэн, дүгнэлт, зөвлөмж гаргуулсан. | **100** |
| **174** | | **7.7.4** | Хорооны 2014-2017 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах, МУ-ын 2014-2017 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт Төсвийн ерөнхийлөн захирагчийн тусгах төсвийн төсөл, төсөл, арга хэмжээний саналыг боловсруулж, тооцоог гарган холбогдох газруудад хүргүүлэх | | 2014 оны төсвийн урсгал санхүүжилтын эх үүсвэр нийт дүнгээрээ 2 тэрбум 818 сая.төгрөг , үүнээс үндсэн ба туслах үйл ажиллагааны орлогыг 800.0, улсын төсвөөс санхүүжих урсгал зардлын эх үүсврийг 2 тэр.бум, үндсэн ба туслах үйл ажиллагааны орлогыг 333.3, улсын төсвөөс санхүүжих урсгал зардлыг 830.8 сая.төгрөгөөр тус тус тэнцүүлэн батлуулж үйл ажиллагааг санхүүжүүлэн ажиллалаа. Хорооны 2014 оны төсвийн орлого, зарлагын болон зардлын үйл ангийн хуваарийг сар, улирлаар нь гаргаж Монгол улсын Засгийн газрын “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх тухай” 2014 оны 147 дугаар тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. | **100** |
| **175** | | **7.7.5** | Хорооны эд хөрөнгийн тооллогыг явуулах, Хорооны өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавих | Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт сайжирна. | 2013 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулсан, ба үр дүнгийн байдлаас хамааран тусгай " Ажлын хэсэг" байгуулан, эд хөрөнгө бүртгэлд дахин авах, актлах зэрэг асуудлаар хяналт шалгалт хийгдлээ. 2010 оноос хойш элэгдлээ нөхсөн актлах хөрөнгийн жагсаалт, хөрөнгийн бүртгэлд байгаа цаашид ашиглах боломжгүй хөрөнгө, цаашид ашиглах шаардлагагүй үнэ тогтоож худалдах хөрөнгийн жагсаалт гаргасан. Агуулахад байгаа хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор хананд тавиур суурилуулж хөрөнгийн эмх цэгцтэй хурааж цэгцэлсэн. Ажлын албаны даргын тушаалаар дахин комисс томилогдож шаардлагатай ажлуудыг хийж гүйцэтгэх талаар үүрэг өгсөний дагуу шатар баланс гарган хөрөнгийг ажилтнуудын нэр дээр нэг бүрчлэн гарган танилцуулах, складанд байгаа хөрөнгийг нэг бүрчлэн марк үнээр нь гаргах, хөрөнгийн балансын дүн тохирсон эсэх талаар нягталж илүү дутуу хөрөнгийн жагсаалтаар зөрүүг тооцож залруулга хийхээр бэлтгэж байна. | **100** |
| **176** | | **7.7.6** | Ажлын албаны хэвийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах эд хогшил, тоног төхөөрөмжийн судалгаа гаргаж | | Хорооны 2014 оны төсөвт батлагдсан хөрөнгийн зардлаас эхний ээлжинд нэн шаардлагатай албан хэрэгцээний бичгийн сейфны үнийн судалгааг авч судлан, сонголт хийж, гэрээ байгуулан 7 ширхэг сейф авах хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлсэн байна. 2014 онд шинээр авах хөрөнгө болон төслөөс шилжиж ирсэн хөрөнгийн жагсаалтыг гарган Төрийн өмчийн хороонд хүргүүлэн хөрөнгө бүртгэх зөвшөөрлийг авсны үндсэн дээр 497,4 сая төгрөгийн үнэтэй Фина систем, 6 нэр төрлийн 9,2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаж, Люксембургийн Их Гүнт улсын хөгжлийн агентлагийн “Санхүүгийн | **100** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | санхүүжүүлэх эх үүсвэрийг шийдвэрлүүлэх | | салбарын чадавхыг дээшлүүлэх" төслийн хүрээнд хэрэгжүүлж буй МОН -004 төслөөс хандив тусламжаар ирсэн, 93 нэр төрлийн 68,6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, Ядуурлыг бууруулах Японы сангийн хүрээнд хэрэгжүүлж буй "Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх" төслийн хандив тусламжаар хүлээлгэн өгсөн 41 нэр төрлийн 38,4 сая төгрөгийн техник хэрэгсэл, нийт 134 нэр төрлийн 107,1 сая төгрөгийн хөрөнгийг зохих , журмын дагуу үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусгах ажлыг хийж гүйцэтгэсэн. | |
| **177** | **7.8. Санхүүгийн салбарын мэдээллийн технологийг хөгжүүлэх талаар** | **7.8.1** | Хорооны тусгай зөвшөөрлийн нэгдсэн сангийн дэд системийн анализын баримт бичиг бичүүлэх | Системийн гүйцэтгэгчийг шалгаруулах олон улсын тендер зарлахад техникийн даалгавар бэлэн болсон байх | Тусгай зөвшөөрлийн нэгдсэн сангийн дэд системийн даалгаварыг бичүүлж дууссан. | **100** |
| **178** | | **7.8.2** | "FinA" системд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн тайлан болон санхүүгийн тайлангийн түүх үүсгэх ажлыг эхлүүлэх /өнгөрсөн жилүүдийн тайлангуудыг системд оруулах/. | Өгөгдөл үнэн зөв ордог болсон байх | 2013 оны 02 дугаар улирлаас Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагчийн санхүүгийн тайланг .xls файлаар авч байсан. Санхүү байдал, орлого, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын улирлын тайлангууд, долоо хоног тутам тайлан хүлээн авах арилжаа, зохицуулалтын үйлчилгээний хөлсийн тайлангууд, биелээгүй захиалгын мэдээллийн маягтын Мета дата бүтэц, матрикс, тайлангийн загвар, нэгтгэлийн тайлангийн маягтууд, 36 ХААБ-ийн арилжааны зуучлагчийн эрхийг "FinA" системд тус тусүүсгэ сэн. ХААБ-ийн арилжааны зуучлагчийн 2013 оны 02 дугаар улирлаас эхлэн цаасаар, .xls файлаар хүлээн авсан тайлангуудын түүхийг ФинА системд үүсгэж, 2014 оны 01, 02, 03 дугаар улирлын нийт 36 ХААБ-ын арилжааны зуучлагчийн 432 тайлангуудыг шивж, оруулж, нэгтгэлийн тайлан гаргахад бэлэн болгосон. | **100** |
| **179** | | **7.8.3** | FINA системийн төвшин бүрийн хэрэглэгч нарын сургалтыг зохион байгуулах | Хэрэглэгчид системтэй ажиллаж, хэрэгцээтэй тайланг гаргах чадвартай болсон байх. | FinA системд бүртгэл үүсгэсэн ажилтнуудад тухай бүр заавар зөвлөгөө өгч ажиллаж байна. FinA системийг вэб апликэйшн болгож шинэчлэх ажил хийгдэсний дараа салбар тус бүрээр системд хэрхэн ажиллах зааварчилгаа, сургалтыг явуулж байна. 2014 оны нэгдүгээр улиралд хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг 98.6 хувь, банк бус санхүүгийн байгууллагуудын тайланг 99.0 хувь FinA системээр хүлээн авчээ. | **100** |
| **180** | | **7.8.4** | Төвшин бүрийн хэрэглэгчид FINA системтэй хэрхэн ажиллах тухай журам боловсруулах. | Журмыг баталгаажуулснаар | Санхүүгийн хяналт шалгалтын системийн ерөнхий журмыг батлан мөрдөж байна. | **100** |
| **181** | **7.8. Санхүүгийн салбарын мэдээллийн технологийг хөгжүүлэх талаар** | **7.8.5** | Хорооны Вэб хуудаснуудын хэвийн,найдвартай ажиллагааг хангаж ажиллах, /www.frc.(gov.)mn; www.frc.(gov.)mn/en; | Вэб хуудаснууд хэвийн ажиллаж байх. | Цахим хуудаснуудын хэвийн, найдвартай ажиллагааг хангаан ажиллаж байгаа. Хоёр сард нэг удаа цахим хуудасны баазыг хуулбарлан авдаг. СБССХ, ГХХАХ-ын цахим хуудас хариуцсан референцийн хүсэлтээр цахим хуудасны өөрчлөлтийг хамтран тухай бүр хийдэг. | **100** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | mnt.frc.mn; intranet; санхүүгийн боловсролын вики хуудас/ | | | |
| 182 | | 7.8.6 | “Зохицуулалттай этгээдийн мэдээллийн нэгдсэн сан”-гийн журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан 28 төрлийн мэдээллийн хүснэгтийг “Fina “ системд оруулах | Тайлан хэвийн хүлээн авах | “Fina “ системийн шинэчлэлийн тестлэх төслийг хэрэгжүүлж дууссан. | 100 |
| 183 | | 7.8.7 | Банк бус санхүүгийн байгууллагуудын улирлын гүйлгээ үлдэгдлийн тайлан тэнцэл маягтад нэмэлт өөрчлөлт оруулж, чанаргүй зээлийн зохистой харьцаа, хаалттай өрийн бичиг, өөрийн хөрөнгийн зохистой харьцааны тайлангуудыг шинээр үүсгэх | | Тайлангийн маягтууд шинээр үүсгэн, Fina системд өөрчлөлтийг оруулж холбогдох тохиргоог хийсэн. Одоо Банк бус санхүүгийн байгууллагуудаас уг маягтыг ашиглан тайлан хэвийн хүлээн авч байгаа. Монгол банкны 2013 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн А -3/1020 албан бичгийн дагуу орон сууцны ипотекийн зээлийн хэмжээ тодорхойлох шаардлагаар Банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж зээлийн хоршооны зохицостой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланд /Fina системд/ нэмж оруулан, холбогдох тохиргоог хийсэн. | 100 |
| "Санхүүгийн салбарт итгэх олон нийтийн итгэлийг бий болгох" стратегийн зорилтын хүрээнд:<br>**Найм. Хорооны дотоод хяналтыг хэрэгжүүлэх талаар** | | | | | | |
| 184 | **8.1. Дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр** | 8.1.1 | Ажлын албаны нэгжүүдийн гүйцэтгэх чиг үүргийн хэрэгжилт, төлөвлөгөөний биелэлтийг батлагдсан удирдамжийн дагуу шалгаж дүгнэлт, зөвлөмж, албан даалгавар гарган хэрэгжилтийг хангуулах | Ажлын албаны нэгжүүдийн үйл ажиллагаа, ажлын төлөвлөлт, биелэлтийн чанар сайжирсан байна. | Бичил санхүүгийн газрын 2013 оны үйл ажиллагаа, төлөвлөгөөний биелэлт, чиг үүргийн хэрэгжилтэд шалгалт хийж дүгнэлт гарган 9 заалт бүхий зөвлөмжийг өгсөн. Мөн Хорооны даргын баталсан удирдамжийн дагуу Хорооны тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэл хөтлөлтийг Хорооны 2006 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 25 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэл хөтлөх журам” -ын дагуу шалгаж 4 заалт бүхий зөвлөмж, Хорооны даргын 01 дугаарын Албан даалгавраар хугацаатай үүрэг өгсөн. Хорооны үндсэн чиг үүргийн нэгжүүдэд ажлын ачаалал тооцох хүснэгтийн загварыг хүн/цаг зарцуулалт ихтэй ажлуудыг тоон үзүүлэлтээр илэрхийлэх байдлаар гаргаж хүргүүлсэн бөгөөд ирүүлсэн мэдээг үндэслэн Хорооны зохицуулалтын байгууллага хариуцсан ажилтны ажлын ачаалал, бодлогын хэлтсийн ажилтнуудын ажлын ачааллыг хэмжих дундаж үзүүлэлтийг гаргасан. Үнэт цаасны газрын 2014 оны газар дээрх хяналт, шалгалтын төлөвлөгөөний явцтай танилцаж саналаа хүргүүлсэн байна. 2014.12.15-ны байдлаар Тамгын газраас хугацаа хэтэрсэн албан бичиг өргөдөл | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гомдлын мэдээг 25 удаа ирүүлсэн/өнгөрсөн онд 44/нийт 18 өргөдөл, 50 албан бичиг шийдвэрлэвэл зохих хугацаа хэтэрсэн өргөдөл тухайн бичигт хариу хүргүүлбэл зохих ажилтнаар тайлбар гаргуулах, нэгжийн удирдлагад албан бичиг хүргүүлэн тодруулга авах, хугацаатай үүрэг өгөх зэргээр хяналтыг тогтмол хэрэгжүүлснээр дээрх үзүүлэлт өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 4 дахин буурсан бөгөөд газраар авч үзвэл Үнэт цаасны газар 34 албан бичиг, 13өргөдөл, Бичил санхүүгийн газар 2 албан бичиг, 1 өргөдөл, Даатгалын газар 4 албан бичиг, 4 өргөдөл, Тамгын газар 10 албан бичгийг шийдвэрлэвэл зохих хугацаанаас 1-80 хоног хэтрүүлсэн байна.Тамгын газарт Ажлын албаны хөдөлмөрийн дотоод журмын ажлын цаг ашиглалттай холбоотой заалтын хэрэгжилтийг хангах чиглэлээр 08 дугаарын албан бичгээр зөвлөмж өгсөн. 2014 оны 7 дугаар сарын 01-ний дотор хариу ирүүлэх зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад “хангалтгүй” дүгнэлт гарсан.<br>Хорооны даргын 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтэд “Хангалтгүй” үнэлгээ өгч, Тамгын газрын Захиргааны хэлтсийн Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл эрхийн нэгдсэн бүртгэл хариуцсан ажилтанд Ажлын албаны хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу сануулах сахилгын шийтгэл ногдуулах саналыг тушаалын төсөл ийн хамт хүргүүлсэн. Ажилтнуудын ажлын цаг бүртгэлийн мэдээтэй танилцаж ажлын цаг ашиглалтыг сайжруулах зөвлөмжийг 2014.11.24 -ний 16 дугаарын албан бичгээр газрын дарга нарт хүргүүлсэн. Хорооны санхүү, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтмол хяналт тавьж илэрсэн зөрчлийг арилгах чиглэлээр удаа дараа албан бичиг хүргүүлж, үүрэг даалгавар өгч ажиллалаа. Ажилтнуудын 2014 оны цалин, ээлжийн амралт, нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлтөд шалгалт явуулж нийт 4.538.414 төгрөгийн тооцооллын алдааг тайлант онд багтаан залруулсан.<br>2015 оны төсвийн тооцооллыг зардлын зүйл бүрээр хянаж хариуг санхүүгийн хэлтэст 2014.08.14-ний 14 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.<br>Хорооны нийт ажилтнуудад ажлын үр дүнгээр олгох урамшууллын тооцооллыг хийж Ажлын албаны даргын 164 дүгээр тушаалаар шийдвэрлэсэн. Хорооны нийт ажилтнууд болон удирдах ажилтнуудад зориулсан “Эрсдлийн удирдлага” сэдэвт сургалтыг 2 удаа тус хэлтэс хариуцан зохион байгуулж, “Хорооны үйл ажиллагааны эрсдэл” сэдвээр илтгэл тавьсан. Компанийн засаглалын үндэсний төвөөс зохион байгуулсан сертификат олгох сургалтад хамрагдсан. Хорооны ахлах албан тушаалын ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөр гаргаж амжилттай зохион байгуулсан. ОХУ-ын Хөрөнгийн зах зээлийн институтээс зохион байгуулсан "Үйл ажиллагааны эрсдэл" сэдэвт сургалтад МОН-004 төслийн дэмжлэгтэйгээр оролцсон. Тайлант онд Хорооны хэмжээнд 4 сургалт тус хэлтэс дангаар болон хамтран зохион байгуулсан байна. | |
| **185** | | **8.1.2** | Төсвийн зарцуулалт, Хорооны нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад | Хорооны санхүүгийн үйл ажиллагаанд хатуу хяналт тогтоож, хуульд нийцсэн үйл ажиллагаа явуулах нөхцлийг хангаж ажилласан байна. | Хорооны 2013 оны санхүүгийн үйл ажиллагааг шалгаж дүгнэлт гарган удирдлагад болон ҮАГ -т хүргүүлсэн. 2013 оны жилийн эцсийн тооллогын үр дүнг нягтлан шалгах ажлын хэсэгт орж ажиллан дүгнэлт гарган Ажлын албаны даргын 207 дугаар тушаалаар Санхүүгийн хэлтэст 3 заалт бүхий үүрэг өгч биелэлтийг тооцон холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан.<br>Санхүүгийн үйл ажиллагааг шалгах явцад хариуцсан ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн, тус хэлтсээс өгсөн зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн тооцооны | **100** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | шалгалт явуулж зөвлөмж, албан даалгавар гарган хэрэгжилтийг хангуулах | | нягтлан бодогчид сануулах сахилгын шийтгэл ногдуулах саналыг хүргүүлсэн. Тайлант онд Хорооны Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтийг 10 удаа гаргаж санхүүгийн хэлтэст хүргүүлсэн. | |
| Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх стратегийн зорилтын хүрээнд хийж гүйцэтгэх ажлууд: **Ес. Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр** | | | | | | |
| **186** | **9. 1. Компанийн засаглалын кодекс, бизнесийн ёс зүйг хэрэгжүүлэх хууль эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх** | **9.1.1** | Компанийн засаглалыг хөгжүүлэх төлөвлөгөө, арга хэмжээний үндсэн чиглэл, улсын төсөвт тусган хэрэгжүүлэх. | Улсын төсөвт тусган хэрэгжүүлсэн байна. | 2014 оны үйл ажиллагааны төсөл, төсвийг гарган Хөтөлбөрийн хэрэгжилтэд шаардагдах санхүүжилтийн асуудлаар Улсын Их Хуралд хандан албан бичиг хүргүүллээ. | **30** |
| **187** | | **9.1.2** | Салбарын чиглэлээр шинэчлэгдсэн хуулиудын хэрэгжилтийг хангуулах үүднээс засаглалын зарчим болон засаглалын талаар холбогдох дүрэм журамд тусгах | ОУСК-ийн дэмжлэгтэйгээр Компанийн засаглалтай холбоотой хууль, тогтоомж, дүрэм, журмын эмхтгэл гаргах | Даатгалын багц дүрмийн хүрээнд засаглалын зарчим болон засаглалын талаар тусган батлав. | **100** |
| **188** | | **9.1.3** | Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх, ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгон шалгаруулах тогтолцоог боловсронгуй болгох, мэдээллийн тогтолцоог сайжруулах, эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцооны сонгомол жишгийг бий болгох журмыг шинэчилэн батлуулж | Төрийн өмчит компанийн засаглалын эрх зүйн тогтолцоог боловсронгуй болох | Төрийн өмчийн хорооноос боловсруулж буй Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журмыг нэмж сайжруулах зорилгоор Зөвлөлтэй хамтран ажлын хэсгийг байгуулан Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн төлөөллийг хэрэгжүүлэх журмын төслийг боловсруулан ЗГХЭГ, Төрийн өмчийн хороонд явуулсан. Төрийн өмчийн оролцоотой болон төрийн өмчит компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороодыг байгуулсан өгсөөд Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан үлгэрчилсэн журмыг үндэслэн дэд хороодын болон Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэх ажил хийгдэж дууссан ба Төрийн өмчийн хорооны 2010 оны 166 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг тэнцвэржүүлсэн үнэлгээний аргаар дүгнэх, урамшуулал олгох журам”-ыг шинэчлэх ажил явагдаж байна. Мөн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2013 оны санхүү эдийн засгийн үзүүлэлт болон нийгмийн хариуцлагын талаар хийсэн ажлын тайланг нэгтгэн товхимол болгон гаргасан. | **100** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжүүлэх. | | | |
| **189** | | **9.1.4** | Компанийн засаглалын зарчмын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Хорооны хуралдаанаар батлуулах. | Компанийн засаглалын кодексийг сайжруулах | Монгол дахь Олон улсын санхүүгийн корпорацийн зөвлөхийн зөвлөмжийн дагуу Компанийн засаглалын кодексийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Олон улсын санхүүгийн корпораци олон улсын байгууллага, Глобал компанийн засаглалын форум болон салбарын судлаач, мэргэшсэн туршлага бүхий хүмүүсээс санал зөвлөмж авч "Монголын компанийн засаглалын кодекс"-ыг шинэчлэн батлаж Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудад мөрдөхөөр тус хурлаас шийдвэрлэлээ. | **100** |
| **190** | | **9.1.5** | Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудад компанийн зарчмыг мөрдүүлэх аргачлалыг бий болгох зорилгоор холбогдох дүрэм, журамд компанийн засаглалын кодексын заалтыг тусгаж нэмэлт өөрчлөлт оруулах. | Холбогдох дүрэм, журамд компанийн засаглалын кодексын заалтыг тусгаж нэмэлт өөрчлөлт орсон байна. | | **100** |
| **191** | | **9.1.6** | Аудитын салбарын КЗ-ын тогтолцоог боловсронгуй болгох, шинэчлэгдсэн батлагдсан аудитын тухай хуулийг таниулах | Аудитын тухай хуулийг сурталчилан таниулах семинар сургалтыг зохион байгуулсан байх | Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд зориулсан "Компанийн засаглал ба эрх зүйн зохицуулалт" семинарыг амжилттай зохион байгуулсан. Хорооны нийт ажилтнуудад ХБНГУ-ын нийгмийн хариуцлагын сайн туршлагын талаар илтгэл тавьсан байна. 2014 оны 5 дугаар сард "Эрнст Янг" олон улсын аудитын байгууллагатай хамтран хувьцаат компани, төрийн өмчит хувьцаат компаниудад зориулсан Компанийн засаглал семинарыг 5 сард зохион байгууллаа. Уг семинарт гадаадын мэргэжлийн өндөр туршлага бүхий илтгэгчид оролцож хувьцаат компани, төрийн өмчит хувьцаат компанийн засаглалын олон улсын туршлага, зайлшгүй шаардлага, цаашдын чиг хандлагын талаар илтгэл тавьж нийт 100 гаруй компани, байгууллага оролцлоо. | **100** |
| **192** | | **9.1.7** | Хувьцаат компани, банк, даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, ХААБиржийн Компанийн засаглалын тогтолцоог боловсронгуй болгох | Тухайн салбарын компаниудын засаглалын тогтолцоо боловсронгуй болж, компанийн сайн засаглалын зан төлөв тогтсон байна. | Даатгалын компанийн засаглалыг сайжруулах, даатгалын компани ТУЗ-тай байх, ТУЗ-д хараат бус гишүүнтэй байх зэрэг шаардлагыг Даатгалын багц дүрмийн хүрээнд шинээр боловсруулан батлав. Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексын талаар нийт 130 ХК-ийн удирдах албан тушаалтнуудад 2 удаа сургалт зохион байгууллаа. ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгосон, компанийн дүрмээ шинэчлэн баталсан компаниудын биелэлт 68 %-тай байна. | **100** |
| **193** | | **9.1.8** | Компанийн | Монгол улсын | Компанийн нийгмийн хариуцлагын үндэсний хэмжээний бодлогын баримт | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | нийгмийн хариуцлагын үндэсний хэмжээний бодлогын баримт бичгийг боловсруулж хэрэгжүүлэх | хэмжээнд Компанийн нийгмийн хариуцлагын судалгааг хийж бодлогын баримт бичгийг боловсруулан гаргасан байна. | бичгийн төслийг эцэслэн боловсруулж ажлын хэсгийн хүрээнд хэлэлцэн эцэслэн боловсруулаад төр болон төрийн бус байгууллага, яамд, иргэдийн хүрээнд хэлэлцүүлэхээр ажлыг Эдийн засгийн хөгжлийн яам, ГОУХАН-Эрдэс баялаг түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөртэй хамтран ажиллаж байна. Одоогоор бодлогын баримт бичгийн эхний хэлэлцүүлгийг төрийн байгууллагуудын хүрээнд зохион байгуулсан бөгөөд цаашид 4 цуврал хэлэлцүүлэг хийхээр төлөвлөн бэлтгэл ажил хийж байна.Түүнчлэн Компанийн нийгмийн хариуцлагын чиглэлээр Хүний эрхийн үндэсний Комисст сургалтыг GIZ-тай хамтран зохион байгуулсан. | **100** |
| **194** | **9.2.Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэхэд Засгийн газрын манлайллыг хангах** | **9.2.1** | Төрийн өмчит компанийн засаглалын тогтолцоог боловсронгуй болгох | 2013 онд хийсэн Компанийн засаглалын судалгаанд санал болгосон санал, зөвлөмжийг судлан шаардлагатай зөвлөмжүүдийг төрийн өмчит компаниудад хэрэгжүүлсэн байна. | Төрийн өмчийн хорооноос боловсруулж буй Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журмыг нэмж сайжруулах зорилгоор ажлын хэсгийг байгуулан журмын төслийг боловсруулан ЗГХЭГ, Төрийн өмчийн хороонд явуулсан. | **100** |
| **195** | | **9.2.2** | Төрийн өмчит компанийн удирдалгуудын мэдлэгийг дээшлүүлэх засаглалын сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах | Сргалтуудыг үе шаттайгаар зохион байгуулсан байна. ХААБиржийн засаглалыг сайжруулах зорилгоор бирж түүний брокер, дилер компаниудын хүрээнд засаглалын сургалт, семинар зохион явуулсан байна. | Компанийн тухай хуулийн 75.8 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 10 сургалтын байгууллагууд компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалтад компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн дарга нарыг хамруулан ажиллаж байна. 2014 онд нийт 14 удаагийн сургалт зохион байгуулж 339 төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нарыг хамруулж гэрчилгээ олгосон байна. | **100** |
| **196** | **9.3. Компанийн засаглалын кодекс, бизнесийн ёс зүйг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх** | **9.3.1** | Монгол Улсын Компанийн засаглалын үндэсний тайлан гаргах. | 2014 оны КЗ-ын үндэсний тайлан гаргасан байна. | Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн ээлжит хурлыг зохион байгуулахаар ажиллаж байна. Тус хуралд “Компанийн засаглалын үндэсний тайлан-2014” судалгааны танилцуулга, компаниудын засаглалыг үнэлэх асуудал болон бусад хийж ажлуудын талаар хэлэлцэнэ. | **80** |
| **197** | | **9.3.2** | Компанийн засаглалын өөрөө өөрийгөө үнэлэх үнэлгээний тогтолцоог бий болгох | ТӨК, ХК, Даатгалын компани, Банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж зээлийн хоршоод өөрөө өөрсдийгөө үнэлэдэг тогтолцоог бий болгох. | Зохицуулагч болон оролцогч талуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулагдаж Хувьцаат компаниудын хувьд компаний засаглалаа өөрөө өөрийгөө үнэлэх үнэлгээний 100 асуулттай асуулгыг боловсруулж МХБ-д хүргүүлэн уг асуулгыг МХБ-ийн сайтад байршуулан мөрдүүлэх ажил зохион байгуулагдаж байна. Үнэлгээний асуулгыг мөрдөх аргачлалыг боловсруулж байна. Мөн сайн засаглалтай ХК болох "Тунхаг бичиг"-т КЗҮЗ, МХБ, ТОР20 индексийн сагсыг бүрдүүлэгч ХК-иудын ТУЗ-ийн дарга нартай гурвалсан гарын үсэг зурж нэгдэх үйл ажиллагааг зохион байгуулж байна. | **100** |
| **198** | | **9.3.3** | Компаний засаглалын үндэсний портал | Үндэсний зөвлөлийн хурлыг тус сайтаар дамжуулан онлайн | Компанийн засаглалын ил тод нээлттэй байдлыг бий болгох мэдээллийг олон нийтэд хүргэх ажлын хүрээнд Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевизтэй хамтран ажиллах гэрээ байгуулж улирал бүр компанийн засаглалын | **100** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | сайтаар засаглалын талаарх мэдээллийг олон нийтэд цаг тухайд нь үнэн зөв мэдээллийг хүргэж ажиллана. | хэлбэрээр хийдэг болсон байна. | талаар олон нийтэд танин мэдүүлэх мэдээлэл хүргэхээр тохиролцоод байна. Энэхүү ажлын хүрээнд улирал бүр бэлтгэн гаргах нэвтрүүлгийн зохиол, агуулгыг боловсруулан тус байгууллагад хүргүүлээд байна. Түүнчлэн Хорооны цахим хуудсаар дамжуулан үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол шуурхай нийтлэн иргэдэд мэдээлэл хүргэх ажиллаж байна. Компанийн засаглалыг хөгжүүлэх хөтөлбөрийн үйл ажиллагаа болон засаглалтай холбоотой бусад мэдээллийг шуурхай иргэдэд шуурхай хүргэх зорилгоор олон нийтийн сошиал медиа цахим хуудас twitter.com, facebook.com сайтуудад өөрийн байгууллагын хаягийг нээн мэдээлэл түгээж эхэлсэн. | |
| **199** | **9.4. Компанийн засаглалын кодекс, бизнесийн ёс зүйг хэрэгжүүлэхэд оролцогч талууд, тэдгээрийн төлөөллийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх** | **9.4.1** | Компаниудын дээд шатны удирдлага, хэвлэл мэдээллийн ажилтнуудын чадавхи, мэдлэгийг дээшлүүлэх сургалт (гэрчилгээ олгох ба мэдлэг олгох) зохион байгуулах Сургалтын байгууллагын үйл ажиллагаа түүний сургалтын чанарт хяналт тавьж ажиллах. | Мэдлэг олгох сургалтыг зохион байгуулан, Онлайн сургалтын тогтолцоог бий болгож холбогдох сургалтын хөтөлбөрийг боловсруулан мөрдүүлсэн байна. | Компанийн тухай хуулийн 75.8 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 10 сургалтын байгууллагууд компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалтад компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн дарга нарыг хамруулан ажиллаж байна. 2014 онд нийт 14 удаагийн сургалт зохион байгуулж 339 төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нарыг хамруулж гэрчилгээ олгосон байна. | **100** |
| **200** | | **9.4.2** | Компанийн засаглалын үндэсний форум зохион байгуулах | Компанийн засаглалын 7 дахь удаагийн үндэсний форум зохион байгуулагдсан байна. | Компанийн засаглалын үндэсний форумыг жил бүр хийж хэвшсэн ба энэ оны 6-р сарын сүүлээр хийхээр бэлтгэл ажлыг хангаж дууслаа. | **100** |
| **201** | | **9.4.3** | Компанийн нийгмийн хариуцлагын ISO 26000 стандартыг сурталчлан таниулах. | Компанийн нийгмийн хариуцлагын талаар сургалт, семинар, үндэсний хэмжээний форум зохион байгуулан ажилласан байна. | Компанийн ЗасаглалынҮндэсний Зөвлөл, Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Яам, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн Эрдэс баялаг, Түүхий эдийн Иж бүрэн Санаачлаг хөтөлбөр хамтран Компанийн Нийгмийн Хариуцлагын үндэсний форумыг зохион байгууллаа. Форумаар Компанийн засаглал – Хувийн хэвшлийн санал санаачлаг ба Засгийн газрын бодлогоор тэдгээрийг хэрхэн дэмжих вэ?; КНХ-ын олон тал – Ногоон хөгжил, Хөдөлмөрийн Аюулгүй байдал, эрүүл ахуй, Хүний эрх нь Компанийн нийгмийн хариуцлагын бүрэлдэхүүн хэсгүүд болох нь; Компанийн Засаглал ба Ил тод байдал – Монгол улсад олон улсын тэргүүн туршлагыг хэрхэн хэрэгжүүлэх вэ?; КНХ-ын Үндэсний Бодлогын төсөл, хэрэгжилтэд өгөх санал зөвлөмж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй зэрэг сэдвүүдийг анх удаа онцлон, гадны судлаачдын илтгэлүүдтэй танилцан, үндэсний хэмжээнд хэлэлцүүлэг өрнүүллээ.<br>Тус форумд төр, хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, их сургууль, хэвлэл мэдээллийн нийт 60 гаруй байгууллагын нийт 160 гаруй төлөөлөл оролцов. ГОУХАН-аас компанийн нийгмийн хариуцлагын чиглэлээр 2 удаагийн ахисан түвшний сургагч багшийн сургалт зохион байгуулсан байна. ISO26000 | **100** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | стандартыг хэрхэн таниулан заах талаар 14 нийт сургагч, сургалтыг хэрхэн явуулах аргачлал сэдвээр нийт 20 сургагч багшийг хамруулсан ахисан түвшний сургалтыг зохион байгуулсан. Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос Компаний нийгмийн хариуцлагын стандарт ISO 26000-г сурталчлан таниулах сургалтын модулийг манай байгууллага орчуулан бэлтгээд байна. Уг сургалтын модульд Нийгмийн хариуцлагын талаарх ойлголтууд багтсан бөгөөд цаашид " Компаний засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээний нэг хэсэг болгон боловсруулж, сургагч багш нарыг бэлтгэн, аж ахуй нэг байгууллагад сургалт зохион байгуулах бэлтгэл бүрэн хангагдаад байна. | |
| **202** | | **9.4.4** | Хувьцаа эзэмшигчид, иргэдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах | Сургалт зохион байгуулагдсан байна. | Мэдлэг олгох сургалт зохион байгуулах 11 сургалтын байгууллагатай гэрээтэй хамтран ажиллаж байна. Мөн Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоотой хамтран 2013 оны 2, 3 дугаар саруудад 3 удаагийн 3 өдрийн сургалт зохион байгуулж хорооны нийт 97 ажилтан албан хаагчид хамрагдаж аливаа компанийн төлөөлөн удирдах зөвлөлд орж ажиллах боломжийг олгох компанийн засаглалын сертификатыг олгоод байна. Хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлийн талаар мэдээлэл хүргэх, сурталчлан таниулах зорилгоор 7 удаа буюу 2014 оны 3 дугаар сарын 04-ний, 2014 оны 5 дугаар сарын 30-ны, 2014 оны 6 дугаар сарын 27-ны, 2014 оны 9 дүгээр сарын 11, 12, 23, 26 -ны өдрүүдэд Эм Си Эс Плаза, Чингис ЗБ, Корпорет ЗБ-ын хурлын танхимд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг 175 хувьцаат компаниудын удирдах ажилтнуудад зориулсан сургалтыг зохион байгууллаа. Монголын хөрөнгийн биржийн "А" самбар дээр бүртгэлтэй хувьцаат компаниудын удирдлагуудыг хамруулан 8 удаагийн сургалтыг Олон улсын санхүүгийн корпорацийн дэмжлэгтэйгээр 2014 оны 6 сараас 10 сарын хооронд нийт 94 компанийн 167 хүн оролцсоноос 63 хувьцаат компанийн 117, ХААБ-ийн 15, 10 брокер дилерийн компанийн 19, 10 даатгалын компанийн 16 хүн тус тус хамрагдсан байна. | **100** |
| **203** | | **9.4.5** | Бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчид, ажил олгогчид, хувьцаа эзэмшигчдийн чуулга уулзалт зохион байгуулах | Чуулга уулзалт зохион байгуулагдсан байна. | Азийн сан, АТГ, АНУ-ын олон улсын хөгжлийн агентлаг, НҮБ -ын хөгжлийн хөтөлбөр, УИХ дахь Авилгын эсрэг Парламентчдын албан бус бүлэгтэй хамтран "Авилгагүй нийгмийн төлөө хамтдаа" уриан дор "Авилгын эсрэг төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагааг уялдуулах" үндэсний чуулганыг 2014 оны 6 сарын 25-ны өдөр зохион байгууллаа. Мөн Дундговь аймагт "Говийн бүсийн Ажил олго гч нарын зөвлөгөөн" -д оролцогч Өмнөговь, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр аймгуудын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын удирдлага, үйлдвэрчний эвлэлийн холбоодын дарга нарын нийт 63 хүнд "Компанийн засаглалын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ" сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлсэн болно. | **100** |
| **204** | | **9.4.6** | Гадаадын компанийн засаглалын туршлагаас судлах | Газар дээр нь болон зайнаас туршлагыг судлаж танилцуулга бэлтгэсэн байна. | Тайван, Хонг Конг, Герман улсуудад Компанийн засаглал болон компанийн нийгмийн хариуцлагын чиглэлээр семинар уулзалтанд оролцож туршлага судлав. | **100** |
| **ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ХУВЬ** | | | | | | **98.4** |